

**Увс аймаг дахь хилийн цэргийн ангиудад цэргийн албан  
хаагчдын эрхийн хэрэгжилтэнд хийсэн шалгалтын  
дүнгийн тухай илтгэх хуудас**

Хүний Эрхийн Үндэсний Комисс, Хил хамгаалах Ерөнхий Газартай хамтарч хилийн цэргийн албан хаагчдын эрхийн хэрэгжилтийн байдалд 2006 оны 11 дүгээр сарын 14-нөөс 18-ны өдрүүдэд тусгай удирдамжийн дагуу шалгалт хийж дүнг гаргав. Шалгалтыг ХЭҮК-ын гишүүн Ж.Дашдорж ахалж, ХЭҮК-ын референт А.Саруул, Ж.Цолмон, мэргэжилтэн З.Өнөржаргал нарын бүрэлдэхүүнтэй хийж гүйцэтгэв.

Уг шалгалтад ХХЕГ-аас тус газрын штабын дарга генерал Б.Баатарцогт оролцов. Шалгалтанд ХХЕГ-ын харьяа Увс аймаг дахь хилийн цэргийн 0245, 0311 дүгээр ангиуд, түүний харьяа зарим хилийн застав, хилийн харуулууд хамрагдав. Хилийн цэргийн 0311 дүгээр ангийн харьяа Дөрөөгийн 4 дүгээр застав, Яргайтын харуул, хилийн цэргийн 0245 дугаар ангийн харьяа Боршоо болон Давстын застав, Тээл 1, Тээл 2 зэрэг хилийн харуулуудаар орж ахуй нөхцөлтэй нь танилцаж, тэнд ажиллаж буй цэргийн албан хаагчидтай уулзаж ярилцлага хийж, санал асуулга авч шалгалтыг явуулав.

Санал асуулгыг хуудсыг нийт 197 цэрэг, үүнээс 59 хуучин цэрэг, мөн 45 энгийн ажилчдаас авсан болно. Санал асуулгын хуудсыг тус тусад нь нэгтгэж илтгэх хуудсанд хавсаргасан болно.

Хилийн цэргийн 0245 дугаар анги нь 1976 онд байгуулагдсан. 7 застав, 18 харуулын хэсэгтэй, Увс аймгийн төв Улаангом хотод байрладаг. Хилийн отрядын дарга нь хурандаа Б.Баярбат, Увсын хэсгийн хилийн бүрэн эрхэт төлөөлөгч гэсэн эрх хэмжээг эдэлдэг.

Хилийн цэргийн 0311 дүгээр анги нь байгуулагдаад 5 жил болж байгаа харьцангуй шинэ анги бөгөөд тус аймгийн Баруунтуруун сумын дэргэд байрлаж байсан хуучин Оросын цэргийн хотхоны бааз суурийг түшиглэн байгуулагдсан байна. Ангийн даргаар нь хурандаа М.Заяабаатар ажилладаг.

Шалгалт хийгдэх үед өмнөх онд татагдсан нэг ээлжийн цэргүүд халагдаж, шинэ цэрэг татагдаж цөөн тооны цэргүүд хилийн харуулын үүргээ гүйцэтгэж байв.

Шалгалтанд хамрагдсан цэргийн ангиуд дээр шинээр татагдсан 138 цэрэг бэлтгэл сургуулилтанд хамрагдаж, хилийн харуулын үүрэг гүйцэтгэх албанд бэлтгэгдэж байв. Шинээр татагдсан цэргүүд нь тодорхой хугацаанд бэлтгэл сургуулилт хийж, хилийн заставуудад хуваарилагдаж, дадлагажих ажил хийсний эцэст хилийн харуулын үүрэг гүйцэтгэдэг байна.

Түүнчлэн тус ангиуд дээр ажиллах хугацаанд цэрэгт татагдаад 3-4 хонож байсан дийлэнхи болох 138 шинэ цэргүүд байсан тул хуучин цэргүүдийг тусд нь авч санал асуулгын хуудсыг нэгтгэсэн болно. Санал асуулгын хуудасны нэгтгэлийг тус бүрийг нь хавсралтаар оруулав.

## **1. Орон байр, ахуй нөхцөл**

**1.1.** Хил хамгаалах ерөнхий газрын харьяа хилийн цэргийн байгууллагын тогтолцоо нь цэргийн анги буюу отряд, хилийн цэргийн салбар буюу застав, хилийн цэргийн харуул гэсэн зохион байгуулалттай байдаг. Энэ гурван бүтэц нь дээрээсээ доошоо чиглэсэн босоо удирдлагаар явагддаг. Иймээс цэргийн орон байрны ахуй хангамжийг энэ гурван нэгж дээр тус тусад нь авч үзэх шаардлагатай байлаа.

Шалгалтанд хамрагдсан 0311, 0245 дугаар ангиудын хувьд 0245 дугаар анги нь 30 жилийн өмнө байгуулагдсан учир орон байр, тохижилтын хувьд харьцангуй бэхэжсэн байна.

Хилийн цэргийн 0245 дугаар анги нь Увс аймгийн Баруунтуруун суманд хуучин оросын цэргийн анги байрлаж байсан цэргийн хотхоныг ашиглан байгуулагдаж, тохижуулах, өөрчлөн сайжруулах нилээд ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Цэргүүдийн амьдрах орон байрны нөхцөл нь хилийн застав болон харуул дээр харьцангуй боломжийн байна гэж дүгнэхээр байна. Хилийн застав болон харуул дээр цэргүүд өөр өөрсдийн унтаж амрах ор, дэвсгэр хөнжил гудастай, нөхцөл бололцоогоо ашиглан гэрэлтүүлсэн, зурагт радио, сонсох хөгжимтэй, халаалттай өөрсдөө хоолоо хийж идэх боломжтой, боломжийн хирээр тохижуулсан байна. Харин 0311 дугаар ангийн харьяа Яргайтын харуулын байр нь бусдаасаа нөхцөл муутай хэмжээ багатай, тааз нь доошоо хотойсон засаж сайжруулах шаардлагатай болсон байна. Харуулын байруудад ихэвчлэн 4 цэрэг, нэг ахлагч байрладаг байна.

Хилийн цэргийн ангиуд нь шинээр татагдаж ирсэн цэргүүдийг хүлээн авч, 45 хоногийн хугацаатай бэлтгэл, сургалт явуулж, хилийн заставт хуваарилж, хилийн застасаас хилийн харуулуудад хувиараар гаргадаг байна. Иймээс шинэ цэрэг татагдаж ирэхэд цэргийн ангийн цэргүүдийн байрлах байрны хангамж, хүрэлцээ дутагддаг байна. Энэ нь 11 дүгээр сард татагдан ирж, бэлтгэл сургалт явуулж байгаа нөхцөл байдлаас харагдаж байна.

*Жишээ нь : 0311 дүгээр ангид энэ оны 11 дүгээр сард шинээр 87 цэрэг татагдсан бөгөөд тус бүр 60 м кв хэмжээтэй 2 тасагт шинээр ирсэн цэргүүдийг хуваан байрлуулсан, ор хүрэлцэхгүй байгаа учир нэг тасгийн цэргүүдийг нийтийн модон наар засаж байрлуулсан байна. Энэ нь нэг цэрэгт дунджаар 1.4 квадрат метр талбай оногдож, зөвшөөрөгдөх хэмжээнээс бага байгаа учраас чийгшил ихтэй байгаа болох нь ажиглагдаж байв. Түүнчлэн энэ ангийн цэргийн байр нь шөнийн цагт гэрэлтүүлэг муутай байгаа нь илт байв.*

Жишээ нь : 0245 дүгээр ангид шинээр 91 цэрэг татагдсан бөгөөд ор, унтлагын өрөөний талбай хүрэлцэхгүйн улмаас спорт зааланд газраар ор засан унтуулж байлаа.

Орон байрны хувьд дээрх ангиуд нь чийгшилт ихтэй, халаалт муу, гэрэлтүүлэг хангалтгүй байна.

Цэргүүдэд эргэлт уулзалт ирэхэд тусгайлан байрлуулах зориулалтын эргэлт уулзалтын байр байхгүй байсан хэдий ч эргэлт уулзалт ирэх үед зочид буудалд хүлээн авч уулзуулдаг гэсэн тайлбарыг ангийн удирдлага тавьсан ба цэргүүд ч мөн адил тэмдэглэн хэлсэн байна.

Цэргийн ангиудын албан хаагчдын орон сууцны хангамжийг сайжруулах, орон сууцаар хангах чиглэлээр нилээд анхаарч ажилладаг байна. Зарим хилийн харуул дээр ажиллаж байгаа ахлагч нар орон байраар хангагдсан байна. Цэргийн ангийн албан хаагчдыг орон сууцаар хангахад 0311 дүгээр ангийн дарга М.Заяабаатар идэвхи санаачлага гаргаж ажилласан байна.

Тус ангийн дарга М.Заяабаатар өөрөө сүрлэн байшингийн төслийн сурагалтанд хамрагдаж цэргийн хотхон байгуулж, 3 сарын дотор гал тогоо, 1 өрөө бүхий хямд төсөр 20 орон сууц барьж, ажилчдаа байраар хангасан байна. Энэхүү санаачлага туршлага нь бусад цэргийн анги байгууллагуудад үлгэр жишээ болохуйц ач холбогдолтой арга хэмжээ болсон байна.

**1.2.** Хугацаат цэргийн албан хаагчдын орчны ариун цэвэр, эрүүл ахуйн хэрэгслийн хангамжийн байдлыг санал асуулгаар авч, дүгнэж газар дээр нь үзэж шалгасан болно. Отряд, застав, харуулын байр нь эрүүл ахуйн шаардлага хангасан орчин нөхцөлтэй, бие засах газар нь бүгд гадаа байрлалтай, нүүр гар угаах болон хувцас хэрэгслээ угаах тусгай зориулалтын өрөөтэй байна. Хугацаат цэргийн албан хаагчдад тэдний өдөр тутмын хэрэгцээнд зориулж хүн тус бүрд сард:

- Оо 1 ширхэг,
- Алчуур 1 ширхэг, / улиралд олгох/
- Сойз 1 ширхэг, / улиралд олгох/
- Барааны саван 1 ширхэг,
- 00 цаас 1 ширхэг,
- Нүүр гарын саван 1 ширхэг,
- Гутлын тос 1 ширхэг,
- 1 удаагийн сахлын татуурга 1 ширхэг
- Гутлын сойз 3 цэргийн дунд 1 ширхэгийг/ улиралд олгох/ тус тус тавьж олгодог нормтой байна.

Хилийн застав болон харуулын байраар явж шалгахад эдгээр зүйлүүдээр хангадаг болох нь харагдаж, батлагдаж байв.

Санал асуулгын хуудсаар болон халуун усны байрны бүртгэлээр цэргүүд 7 хоногт 1 удаа усанд ордог хэмээн тэмдэглэсэн байв.

Халуун усны хувьд отряд дээр нийтийн халуун усны газартай, зарим застав болон харуулууд дээр цэрэг, ажилчидад зориулсан сауна, душ ажиллаж байлаа.

Ор дэрний даавуу, дотуур хувцасыг Цэргийн албаныг зохион байгуулах зааврын нийтийн болон хувийн ариун цэврийн талаарх заалтын дагуу цэргийн албан хаагч 7 хоногт 1 удаа сольж угаалгад шилжүүлнэ гэсэн ба энэ заалт нь 0311 дүгээр ангиас бусад анги, застав, харуул дээр хэрэгждэг байна.

*Жишээ нь : 0311 дүгээр ангийн угаалгын байрны бүртгэлийн дэвтэр дээрээс харахад ор дэрний даавуу, дотуур хувцасыг 14 хоногт 1 удаа угаадаг байна.*

## **2. Хоол хүнс, хувцасны хангалт**

**2.1.** Цэргийн албаныг зохион байгуулах зааварт цэргийн гал тогоо нь хооллох бүрэлдэхүүний тооноос хамаарч тодорхой хэмжээний зай багтаамж бүхий ажлын байр, өрөөтэй байна гэж заажээ. Үүнээс үзэхэд :

0311 дүгээр ангид Халуун хоол боловсруулах өрөө нь сав хэрэглэл угаах, хатаах хадгалах өрөөтэйгээ хамт, мах бэлтгэх өрөө, ногоо бэлтгэх өрөө, гурил бэлтгэх өрөө нь нийт 96 м кв талбайтай нэг бэлтгэлийн өрөө байсан.

Хүнс хуурай хэрэглэл хадгалах өрөө, талх хадгалах, тавьж олгох өрөө байхгүй зөвхөн талх барих өрөөтэй байсан. Ахлах тогоочийн буюу гал тогоонд ажиллагчдын бэлтгэл, сургалтын өрөө, гал тогооны жижүүр, ээлжийн тогооч, бэлтгэгч нарын өрөө, хувцас хэрэглэл хадгалах өрөө нь нэг дор байв. Бүх өрөө чийгшилт ихтэй, нилэнхүүдээ мөөгөнцөртэй, тааз нуралттай байсан.

Хоолны заал нь 135м кв талбайтай, 120 хүн хооллох багтаамжтай гэж үзэж байгаа боловч ширээ сандлын хүрэлцээ, хоолны ширээ засахад ширээн дээр тавигдах зүйлүүд /хувин, данхны тавиур, давс, перецны сав, давхарлан тавьсан таваг, хувингийн халбага, цайны аяга, халбага, цөцгийн тос, элсэн чихэртэй сав, хоол цайны үлдэгдэл хийх сав гэх мэт/ хангалтгүйгээс хоёр ээлжээр цэргийн албан хаагчдыг хооллодог. Хооллох заал нь гэрэлтүүлэг муу, чийгшилт ихтэй, тааз хөлөрсөн байв. Цэргийн албан хаагчдад өдөрт 1 хүнд:

- Мах 550 г
- Гурил 100 г
- Талх 650 г
- Цагаан будаа 80 г
- Хөц будаа 40 г

- Шар будаа 40 г
  - Каша 40 г
  - Гоймон 50г
  - Төмс 300 г
  - Байцаа 150 г
  - Хүрэн манжин 30 г
  - Луван 30 г
  - Вареньө 30 г
  - Ургамалын тос 10 г
  - Цай 8 г
  - Давс 25 г
  - Сүү 200 г
  - Айраг 500 г
- Сонгино 30 г-аар болж хоолыг нэр төрөл, өтгөн шингэний байдал, амт чанар, илчлэг хуваарилалт, хүрэлцээ зэргийг харгалзан үзэж, хоолны нэр төрлийг давхардуулахгүйгээр 7 хоногээр хоолны хуваарь гарган мөрддөг байна.

**Хоолны нормыг хэвсрэлт хүснэгтээр үзүүлэв**

Санал асуулгын хуудсыг 84 цэргийн албан хаагчдаас авч нэгтгэхэд өлсдөг гэж 1, заримдаа өлсдөг гэж 9, өлсдөггүй гэж 74 цэрэг хариулсан байна. Харин хоолны амт чанарын талаарх санал асуулгад хоол хүнсний чанарын байдал, амт чанарын талаарх санал асуулгад хариулсан байна.

Хоолны норм, хэмжээ, санал асуулгын дүнгээс харвал цэргийн албан хаагчдын хоол хүнсний хангамж боломжийн хэмжээнд байна гэж үндэстэй байна.

2.2. 0245 дугаар ангийн хоол хүнсний хангамжийн нөхцөл байдал дээрх ангитай төстөй байв. Хооллох ерөөний болон сандал ширээний хүрэлцээ хангалтгүй байгаагаас шалтгаалан цэргүүдийг 4 ээлжээр хооллодог байна.

Хоол хүнсний хангамж, хүрэлцээний байдлын талаар 113 цэргээс авсан санал асуулгын хуудасны нэгтгэлээс үзэхэд: 5 цэрэг өлсдөг, 7 цэрэг заримдаа өлсдөг, 101 цэрэг өлсдөггүй гэсэн бол хоол хүнсний чанарын байдлыг 100 цэрэг сайн, 13 цэрэг дунд хэмээн хариулсан байна.

Хоолны хүрэлцээ, амт чанарын талаар цэргүүдийн өрсөн санал асуулгад хоол хүнсний нөхцөл байдал боломжийн байгаагаар харгалзах боловч, зарим ярилцлага, санал асуулгын хуудсанд бичигдсэн санал анхаарлыг татаж байна. Тухайлбал: зарим цэрэг санал асуулгын хуудсанд гэдэс дотроо хоол их хийдэг, хоол амт муутай байдаг, хоол нэмэх бололцоогүй байдаг, талх түлхий байдаг гэсэн санал гаргасан байна.

Тус анги нь 7,8,9, дүгээр саруудад цэргийн хүнсэнд зориулж амьд хонь худалдан авч нийлүүлсэн. Нийлүүлсэн хонь нь 8-15 кг татаж байсан ба нядалгаа хийж орлого авахдаа 26 кг-аас дээш бодож ав гэж дарга нар үүрэг өгсөн. 10 кг татаж байгаа хонийг 26 кг-аар орлого авахад цаана нь зарим үед цэргийн хоол хүрэлцэхгүй тохиолдол их гарч байсан. Заасан жинд нь хүргэж орлого аваагүй бол төлбөр тооцооны асуудал гарна /хилийн заставуудад/. Зун нь шим багатай мал авч /турж эцсэн, үхэх шахсан мал/ дээрхи байдлаар хүнсэнд хэрэглэж, намар нь тэмээний мах авч зогсоо зайгүй өгсөн, шээс алдуулж, өвөлжингөө тэр чигтээ баастай гэдэс цувдай идэж жилийг өнгөрөөнө. Хүйтэн сэрүүний улиралд тэмээний мах их идэх нь эрс тэс уур амьсгалтай газар ер нь зохидоггүй. Адууны цувдай /элэг, уушиг/ хүний иддэггүй зүйлийг идүүлж, илжирч муудсан цувдай харуул дээр очдог. Засгаас хангалттай хэмжээний хүнсээр хангаж байгаа гэх боловч, нэг ч удаа эрүүл мэндэд нийцсэн хүнс идэж үзсэнгүй. Иддэг хоол ийм байхад хилд үүрэг гүйцэтгэж байгаа цэрэг, харуулын дарга нарын бие болон сэтгэл санаа ямархуу байх вэ?

**/Харуулын даргатай хийсэн ярилцлагаас/**

Эдгээр тэмдэглэл, ярилцлагаас үзвэл хоол хүнсэнд хэрэглэж байгаа махан бүтээгдэхүүний чанар, нэр төрөл төдийлөн сайн биш байдаг байна гэсэн дүгнэлтийг хийж болохоор байна. Иймд цэргүүдийн хоол хүнсэнд хэрэглэж байгаа хүнсний бүтээгдэхүүний чанар нэр төрөлд анхаарах хэрэгтэй болох нь харагдаж байна.

**2.3.** Хувцасны хангалтыг өвөл, зуны улиралд жилд хоёр удаа тавьж олгодог байна.

Санал асуулгын дүнгээс үзэхэд гутал, хувцасны хангалтын талаар бүгд 59 хуучин цэрэг санал асуулгад хамрагдсанаас хувцасны хангалт сайн гэж 54, дунд гэж 5 цэрэг байна. Харин хувцасны хангалтын талаар дутагдалтай зүйл байна уу гэсэн асуултанд цэргийн хувцас 2 ээлж байвал зүгээр, гутлын ул чийг их татдаг учир бөөр өвдөх асуудал гардаг, хөлний ороолт жижиг, хүрэм томддог гэж хариулсан байна.

Цэргийн анги, хилийн застав, харуулууд дээр алба хааж байгаа цэргүүдийн өмсөж байгаа гутал хувцасны хангамжтай танилцаж үзэхэд өвлийн улирлын хувцас нь ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлага хангахаар байна. Цэргүүд нь өвлийн улиралд өмсөх 2 төрлийн / үстэй дээл, хилчин дээл/ дээлтэй чихтэй малгайтай байна.

Харин дийлэнхи цэргүүд хуучин өмсөж хэрэглэж байсан хувцастайгаа халагдах хүсэлтэй байгаагаа илэрхийлжээ. Халагдсан цэргүүдийн өмсөж хэрэглэж байсан хувцасыг дараагийн ээлжийн цэргүүдэд дамжуулан хэрэглүүлдэг, ажилд өмсөгдөг гэж хуучин цэргүүд тайлбарлаж байсан боловч чухам ямар журмаар хэрэглүүлдэг нь тодорхой бус байна.

Түүнчлэн хилчин үстэй дээл, өвлийн үстэй малгай зэрэг хувцасыг ариутгал цэвэрлэгээнд оруулахгүйгээр дараагийн цэргүүдэд шууд хэрэглүүлдэг нь энэ хувцаснаас цэргүүдэд арьс өнгөний өвчин дамжин халдварлах магадлал их байна гэж үзэж байна. Застав болон харуулууд дээр уулзсан цэргүүдийн дунд үлд болон хатигтай цэрэг нилээд байгаа нь анхаарал татаж байв.

саяа, харуулаар тараадаг, тус ангийн 7 застав, 18 харуулын хэсэг зурат үзэх номноос бусад нь мэргэжлийн номууд байна. 11 төрлийн сонин захиалж, анги, номтойгоос 108 боть монголын утга зохиолын шилдэг түлвэр, Н.Энхбаярын 8 боть төлөвлөгөөний дагуу зохион явуулдаг. Тус анги нь 150 төрлийн 870 ширхэг Соёл хүмүүжил, сурталчилгаа мэдээллийн ажлыг сар, долоо хоногээр сургалт зохион байгуулсан.

guys" төвтэй хамтран 1 удаа 46 хүнд, "Гал голомт" хөдөлгөөнтэй гурван удаа заах сургалтыг ирэх жилийн төлөвлөгөөндөө оруулахаар тусгасан байна. "Happy Бичиг үсэгтэй 26 цэрэг тус ангид татагдаж ирсэн буюу эдгээр цэргүүдэд бичиг үсэг байна. Мэдээлэл, соёл хүмүүжлийн ажлыг тусгай төлөвлөгөөр явуулдаг. сонин, Монголын мэдээ гэсэн гурван төрлийн сонин захиалж уншдаг өрөөнүүдэд зурат үзэх, сонин унших зориулалтаар ашигладаг байна. Өдрийн Амралт соёлжилтын танхим, соёл урлагийн танхимын өрөөнүүдтэй бөгөөд эдгээр өөр зүйлгүй байна.

зааснаас зөвхөн 1 гүйлтийн зам, 1 массажны ор, давсан зам, 1 гарын татуураанаас дасгал хийх сандал, штанг зэргийг цэргийн албаныг зохион байгуулах зааварт гангаль, гимнастикийн хана, дүүжин, авиралтын олс, толь, гэдэсний бүлчингийн ээлжинд 6 хүн орж хичээллэх боломжтой. Энд хүчний иж бүрэн аппарат, тухай, Эрүүл мэндийн үйлчилгээний буюу физик амьжиргээний өрөө 36 м кв талбайтай, 1 хэдий ч хол тойрогт шидэхээр байгуулаагүй, стандартын бус байна.

савлуур, саадын зурвастай, гранатын талбай нь тэгш гадаргуу дээр байгуулагдсан талбай, спорт тоглоомын талбайтай байна. Гимнастикийн хотхон нь дүүжин, суга тамрын сургалтын талбайтай, гимнастикийн хотхон, саадын зурвас, гранатын Үний зэрэгцээр тус анги нь 80x35 м хэмжээтэй гадаа засаж тохижуулсан биеийн кетнээс өөр хувцас хэрэглэлий байв.

хэрэглэх хувцас хангамжийг, зөвхөн нийтийн зориулалтаар хэрэглэх 12 хос зориулсан тусгайлагдсан өрөөнүүдгүй, цэргийн албан хаагчдад спортоор хичээллэхэд Харин хувцас тайлах, спортын хэрэглэл хадгалах, биеийн тамрын багшид шүршүүрийн өрөөтэй, гэрэлтүүлэг сайтай, агааржуулалтын 2 хоолойтой байна.

бөмбөг тоглох зэрэг спортын тэмцээн наадам, дасгал сургуулилт явуулах боломжтой, ханандаа гимнастикийн шаттай, төннис, шатар, даамны ширээтэй, Тус анги нь 800 м кв талбаатай биеийн тамир, спортын заалтай, буюу сарс, гар явуулах нөхцөл бололцоо нь 0311 дүгээр ангийг бодвол харьцангуй бэхжсэн байна. 3.1. 0245 дугаар анги нь харьцангуй эрт байгуулагдсан учир соёл хүмүүжлийн ажил

**3. Соёл, хүмүүжлийн арга хэмжээний талаар**

26

боломжтой, мөн заставууд соёл хүмүүжлийн танхимтай байв. Отрядын номын сан нь сард нэг удаа застав, харуулуудаар нүүдлийн номын санг ажиллуулдаг.

Харин хилийн харуулууд дээр ном сонин байгаа эсэхийг лавлаж үзэхэд цөөн төрлийн ихэвчлэн 2-5 ширхэг хуучин, хуучин онуудын цөөн тооны сонин, 10 ширхэг мэргэжлийн ном байсан нь цэргийн анги дээр байгаа ном хэвлэлийг застав болон харуулуудаар түгээх, хангах ажил сайн биш байна.

Соёлын танхим нь 4.5 сая төгрөгийн техник хэрэгсэлтэй. Үүнээс: ямаха 1000 даралтат хөгжим, DVD тоглуулагч, өсгөгч, чанга яригч, ком үлээвэр хөгжим, гитар, баянхуур хөгжим, 13 ширхэг компьютер байгаа нь тус анги соёл хүмүүжлийн ажил явуулах боломж нөхцөл хангагдсан байна.

0311 дүгээр анги нь 2001 онд байгуулагдсан шинэ цэргийн анги учир соёл хүмүүжлийн ажил явуулах боломжийн хувьд 0245 дугаар ангиасаа харьцангуй доогуур гэж үзэхээр байв.

Тус ангид биеийн тамирын спортын заал одоогоор байхгүй, хуучин оросын цэргийн ангийн ашиглаж байсан агуулхын байрыг өөрчлөн засварлаж спорт заал байгуулахаар төлөвлөж байгаа тухайгаа тус ангийн удирдлага танилцуулсан. Харин гаднах биеийн тамирын талбай нь тэгш задгай газарт байгуулж, 2 эгнээ гүйлтийн зам, биеийн тамирын талбайдаа дүүжин, суга савлуур, модон морь, хөлийн тээглүүр бүхий урт сандлуудтай бөгөөд уг талбай нь 75x15 хэмжээтэй байна.

Соёл хүмүүжлийн ажлын танхим нь жижигхэн, 70 гаруй сандалтай, ямаха хөгжим, бөмбөр, чанга яригчтай, үлээвэр хөгжмүүд зэргүүд нь хуучирч хэрэгцээ хангахаа больсон байв.

Амралт соёлжилтын танхим нь гурван урт модон сандал, 1 ширээ, зурагт, хөгжим, шатар даамтай, энд чөлөөт цагаа өнгөрүүлдэг тухайгаа ярьж байв.

Цэргийн байрандаа 10 ширээ 20 сандал бүхий сургалтын байртай, ширээ сандал хүрэлцээгүйгээс 6 байлдагч газар сууж хичээл сонсож байсан, мөн ширээ сандал хүрэлцээгүйн улмаас байнга гал тогооноос зөөдөг.

Сургалтын техник хэрэгсэл огт байхгүй /компьютер, LCD, проектор г.м/. Самбар, принтер, канонтой боловч хор нь дууссан ашиглах боломжгүй. Номын сан нь 4 ширээ 2 сандалтай, 600 гаруй номноос 150 нь уран зохиолын ном байна.

Тус ангийн Дөрөөгийн заставд ороход сард 1 удаа явуулын номын сан ирдэг гэж тайлбарлаж байсан ба Яргайтын харуул дээр 3 ширхэг ном хуучин оны хэдэн сонингоос өөр ном хэвлэлгүй байв.



Шалгалтанд хамрагдсан застав, харуулууд нь тус бүр биеийн тамирын талбайтай уг талбайдаа дүүжин, суга савлуур, модон морьтой, бие бялдраа хөгжүүлэх өөр техник хэрэгсэл байхгүй болох нь ажиглагдаж байв.

Санал асуулгад хамрагдсан цэргүүдээс бичиг үсэг сурахаас гадна амьдралын ухаанд суралцах, спортоор хичээллэх, салаад хооронд спорт урлагийн тэмцээн зохион байгуулах хэрэгтэй гэж үзсэн байна. Бид зун аж ахуйн ажил ихтэй байдаг, өвөл чөлөөт цаг их байдаг боловч байранд дасгал сургууль хийх орчин нөхцөл байдаггүйгээс зурагт үзэх, ном унших, бие биетэйгээ ярих, захны давуугаа хадах зэргээр ихэвчлэн унтаж амарч чөлөөт цагаа өнгөрүүлдэг хэмээн хариулсан. Иймд чөлөөт цагаа зөв боловсон үр ашигтай өнгөрүүлэх, бие бялдраа хөгжүүлэх орчин нөхцлийг бүрдүүлэхэд ангийн зүгээс тодорхой ажил зохиох шаардлагатай байна.

#### **4. Эрүүл мэндийн үйлчилгээ**

Цэргийн байгууллагын эмнэлгийн алба нь цэргийн ангийн нийт бие бүрэлдэхүүн, ажилчдын эрүүл мэндийн байдалд эрүүл мэндийн хяналт тавих, эмнэлгийн үзлэгт тогтмол хамруулах, эрүүл мэндийг нь хамгаалах, урьдчилан сэргийлэх үүрэгтэй боловч эмнэлгийн ажилтны орон тоо дутуу, тоног төхөөрөмж, эм тарианы хүрэлцээгүйгээс шалтгаалан энэ үүргээ хэрэгжүүлэхэд ихээхэн хүндрэлтэй байдаг болох нь эмч, эмнэлгийн ажилтнуудтай хийсэн ярилцлага, ажиглалтаас харагдаж байна.

0311 дүгээр ангийн тухайд 2 их эмч ажиллах ёстой боловч 1 их эмч, 1 бага эмч, 4 сувилагчтай, 8 ортой эмнэлгийн салбар ажиллаж байв.

0245 дугаар ангийн тухайд 2 их эмч, 1 бага эмч, 3 сувилагчтай 5 ортой эмнэлгийн салбар ажиллаж байна.

Застав болон хилийн харуул дээрх цэргийн албан хаагчид өвчилж яаралтай тусламж шаардагдсан тохиолдолд газар дээр нь эмнэлгийн анхан шатны яаралтай тусламж үзүүлэх, хүндээр өвчилсөн, бэртсэн, гэмтсэн цэргийн албан хаагчдыг эмнэлэгт яаралтай хүргэх амь насыг хамгаалах, болзошгүй эрсдэлээс хамгаалахад анхаарах шаардлагатай байна.

Жинхэнэ хилийн манааны үүрэг гүйцэтгэж хил дээр ажиллаж буй застав болон харуулын цэргүүдэд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх боломж нөхцөл хязгаарлагдмал байна. Зөвхөн хилийн цэргийн отрядууд дээр эмнэлгийн салбар ажилладаг боловч хилийн застав дээр мэргэжлийн эмч, мэргэжилтэн байхгүй байгаа нь яаралтай тусламж шаардагдсан тохиолдолд ихээхэн хүндрэл гарахаар, мөн хилийн отряд, хилийн заставууд хоорондоо хол байрлалтай, зам бартаа ихтэй зэрэг нь нөлөөлөхөөр байна.

Хилийн застав дээр ариун цэврийн зааварлагч хэмээх орон тоо байдаг ба энэ орон тоон дээр эмнэлгийн мэрэгжлийн бус хүн ажилладаг бөгөөд өөр бусад аж ахуйн ажил хавсран гүйцэтгэдэг, эмнэлгийн анхан шатны яаралтай тусламж үзүүлэх мэдлэг муутай хүмүүс ажиллаж байна. Тэдэнд эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх заавар, журам, гарын авлага, эмийн жагсаалт, эмийн заавар байхгүй буюу застав болон харуулууд дээрхи эм тарианы хангамж харилцан адилгүй байна. Зарим харуулууд дээр зайлшгүй шаардлагатай хөвөн, бинт, нэг удаагийн тариур байхгүй байгаа нь эмийг юунд уудаг талаар асуухад цэргүүд ямарч мэдлэггүй байгаа болох нь харагдаж байв.

Эмнэлгийн үзлэгт ордог эсэх талаар нийт 59 хуучин цэргүүдээс авсан санал асуулгын дүнгээс харахад эмнэлгийн үзлэгт ордог гэж 50 цэрэг, ордоггүй гэж 2 цэрэг, заримдаа ордог гэж 7 цэрэг, эм тарианы хангамжийн талаар асуухад хангалттай гэж 32 цэрэг, хангалтгүй гэж 27 цэрэг тус тус хариулжээ.

Шалгалтын явцад цэргийн ангиудад байгаа эм тариатай танилцаж үзэхэд хугацаа хэтэрсэн буюу хэтрэх дөхөж байгаа эм тарианы нөөц нилээд байна. Тухайлбал: 0311 дүгээр ангийн үл хөдлөх эмийн хайрцагнаас 2006 оны 9 сард хугацаа нь дууссан 1 хайрцаг eufillin, яаралтай тусламжийн цүнхнээс 2006 оны 10 сард хугацаа дууссан 1 ширхэг вишиневский түрхлэг, 0245-р ангийн үл хөдлөх эмийн хайрцагнаас 2006 оны 10 сард хугацаа дууссан өвчин намдаах тайвшруулах үйлчилгээтэй дроперидал тариа, энэ онд хугацаа нь дуусах хэд хэдэн эм гарсан байна.

Хилийн цэргийн 0311 дүгээр ангид 2006 онд гэхэд гэмтэл бэртлийн улмаас 2 байлдагч амь насаа алдсан ноцтой дутагдал гарсан байна.

*Жишээ нь: 0311 дүгээр ангийн заставын байлдагч Тэгшбаярын Нямхишиг /22 настай/ 2006 оны 7 дугаар сарын 20-ны өдөр морьтой явж байгаад, духаараа мод мөргөж эмнэлгийн тусламж авалгүй 3 хоноод, малчин айлд очиж, бариачид бариулсан боловч толгойны нь өвчин дарагдаагүй тул тус отрядад ирсэн Төрийн Тусгай Албан Хаагчдын эмнэлгийн эмч Сэргэлэнд үзүүлж эм авч ууж, Хүн эмнэлгийн албаны эмч Н.Нарангаравыг ажилдаа ороход нь 7 дугаар сарын 25-нд эмнэлэгт хэвтэж, 8 дугаар сарын 5 хүртэл эмчилгээ хийлгэсэн байна. Тэрээр бие нь сайжраагүй учир 8 дугаар сарын 5-ны өдөр Улаангол хотын Эмнэлгийн мэс заслын эмч Батсүх авч явжээ. Улаангом хотын эмнэлэгт 2 хоноод Улаанбаатар хот руу онгоцоор авч явахад ухаан алдаж, ТТАХНЭ-т хэвтсэн боловч ухаан оронгүй байсаар нас барсан байна. Эмнэлгийн дүгнэлтээр тархиндаа цус харвасан болох нь нотлогджээ.*

*Мөн онд энэ анги дээр нэг цэргийн албан хаагч бүтэн харвалт өгч нас барсан мэдээлэл байгаа боловч энэ тухай баримт байхгүй байна.*

**Хүн эмнэлгийн өвчний түүхээс**

Цэргийн ангиудын эмнэлгийн байгууллагын төсөв, хөрөнгө хүрэлцээгүй байгаагаас албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, өвчтөнийг эмчлэхэд хүндрэлтэй байдаг талаар эмнэлгийн ажилтнууд тайлбарлаж байв.

Тухайлбал: 0245 ангийн тухайд эмнэлгийн нэг оронд сард эрүүл мэндийн даатгалын сангаас 14000 төгрөг төсөвлөгдөж, жилдээ 4.0 сая төгрөгний төсөвтэйгээр эмнэлгийн салбар үйл ажиллагаагаа явуулдаг, төсөв хаанаа ч хүрдэггүй, 5 ор маань зөвхөн бэртэл гэмтэл авсан яаралтай өвчтөнүүддээ зориулагддаг. Гэтэл ангийн төсвөөс хүн эмнэлэгт төсөвлөгдсөн мөнгө хүн эмнэлэгт ордоггүй. Манай анги 560 гаруй ажилтантай, миний хийсэн судалгаагаар бие бүрэлдэхүүний 78 орчим хувь нь хүйтэн нөхцлөөс шалтгаалсан бөөрний үрэвсэл, архаг хууч өвчтэй гэж гарсан, эдгээр архаг хууч өвчтэй хүмүүсийг амбулатороор эмчлэх ямарч боломжгүй байдаг тухай хүн эмнэлгийн албаны их эмч өгүүлсэн байна.

Гал тогоо, талх барих газар, усан хангамжийн объект, халуун ус, угаалгын газрын ажилчид 7 хоногт нэг удаа эмнэлгийн үзлэгт орно хэмээн цэргийн албаны дотоод дүрэмд заагдсан боловч эдгээр ажилчид эмнэлгийн шинжилгээнд улиралд нэг удаа хамрагддаг байна. Цэргийн албан хаагчиг эмнэлгийн үзлэгт хамруулдаг боловч эрүүлжүүлэх арга хэмжээ авахад төсөв хөрөнгийн хүрэлцээ сөргөөр нөлөөлдөг байна.

Түүнчлэн шинээр цэргийн албанд татагдан ирсэн байлдагч нар янз бүрийн архаг, суурь өвчтэй байдаг нь байдлыг улам хүндрүүлдэг байна.

2006 оны цэрэг татлагаар цэрэг татлагын хариуцлагагүй үйл ажиллагааны улмаас сүрьеэ, тэмбүү, заг хүйтэн, бэлгийн замын үү зэрэг халдварт өвчинтэй, өрөөсөн нүд нь хараагүй зэрэг цэргүүд татагдан ирж байсан байна. Энэ нь цэрэг бүрдүүлэлтийг хангах улмаас эдгээр суурь өвчтэй хүмүүсийг цэрэгт татах нийтлэг хандлага газар авч байгаагийн илрэл хэмээн дүгнэхэд хүргэж байна.

## **5. Дүрмийн бус харьцаа**

Цэргийн удирдах албан тушаалтан, офицерууд удирдлагадаа байгаа цэргийн албан хаагчдад хүч хэрэглэх, дарамтлах дүрмийн бусаар харьцах харьцаа нь цэргийн байгууллага дахь хүний эрхийн хамгийн ноцтой зөрчил гэж үздэг тул ийм харьцаа байгаа эсэхийг тодруулах зорилгоор цэргийн албан хаагч, байлдагч нараас санал асуулга авах, ярилцлага хийх, эмнэлгийн баримт бичигтэй танилцах, иргэдээс мэдээлэл авах зэрэг ажил зохион байгуулав.

Шалгалтанд хамрагдсан 2 цэргийн ангид алба хааж буй цэрэгт татагдаад 3-4 хонож буй 138 байлдагч, хуучин цэрэг буюу энэ оны 5 сард татагдсан 59 байлдагчаас санал асуулгын хуудсаар хүч хэрэглэх, зодох, дэглэх зэргээр дүрмийн бусаар харьцах харьцаа байгаа эсэхийг судалж үзэхэд ийм харьцаа байдаг гэж шинэ цэргүүдээс нэг нь ч хариулаагүй байна. Харин 59 хуучин цэргүүдээс 22 цэрэг нь буюу санал асуулгад хамрагдагсдын 37.0 хувь нь цэргийн байгууллагад ийм

харьцаа ямар нэгэн хэмжээгээр байдаг гэдгийг хүлээн зөвшөөрсөн байгаа нь дүрмийн бусаар харьцах зөрчил бага бус байгааг харуулж байна.

Ийм зөрчлийг хэний зүгээс гаргаж байгааг судалж үзэхэд офицеруудын зүгээс гаргадаг гэж 2 хүн, ахлагч нарын зүгээс гаргадаг гэж 3 хүн, түрүүч нарын зүгээс гаргадаг гэж 14 хүн, байлдагч нарын зүгээс гаргадаг гэж 31 хүн хариулсан байна. Асуулгад оролцогсодоос ялгавартай ханддаг гэж 9 хүн, айлган сүрдүүлж дарамталдаг гэж 7, мөнгө эд зүйл шаарддаг гэж 7, зодож хүч хэрэглэдэг гэж 13, үг хэлээр доромжилдог гэж 6, дүрмийн бус шийтгэл хүлээлгэдэг гэж 7 тус тус хариулсан нь дүрмийн бус харьцааны ямар хэлбэрүүд ихэвчлэн гардгийг харуулж байна.

Үүнээс үзэхэд дүрмийн бус харьцааг ихэвчлэн хугацааны цэргүүдийн хооронд тухайлбал: түрүүч байлдагч нарын хооронд, байлдагч нарын хооронд буюу хуучин шинийн хооронд ихэвчлэн гардаг гэж үзэх үндэстэй байна. Харин ийм дүрмийн бус харьцаа байдаг бол өөрт чинь тохиолдсон тодорхой тохиолдлыг зүй бусаар харьцсан хүний нэр албан тушаалтай нь бичнэ үү? гэсэн асуултанд нэг ч хүн ямарч хариулт бичээгүй нь анхаарал татаж байна. Бусдад зодуулж бэртэл гэмтэл авч эмнэлэгт хэвтсэн 3 цэрэг ч хэнд зодуулсан талаараа огт хэлэхийг хүсэхгүй байна.

Эндээс дүгнэхэд цэргийн дунд байгаа дүрмийн бус харьцаа нь маш нууцлагдмал, ил гаргаж тавих боломж, нөхцөл бүрдээгүй, зохих журмын дагуу гомдол гаргаж шалгуулдаггүй байдал хэвшил болсон гэж үзэх үндэстэй байна.

Шалгалтын явцад өргөдөл, гомдол гаргах боломжтой юу гэж асуухад 59 байлдагчаас 49 байлдагч боломжтой, 10 байлдагч боломжгүй гэж хариулсан байна. Харуулын ахлагчаа буудаж амь насыг нь хохироосон Байлдагч Эрдэнэдалайгийн эрүүгийн хэргийн шүүх хурал дээр хохирогчийн эцэг Д "... гэмт хэрэг гарахад ахлагч нарын буруутай үйл ажиллагаа нөлөөлсөн гэдэгтэй санал нийлэхгүй байна. Үнэхээр Эрдэнэдалай цэргийн албаа хааж чадахгүй хэмжээнд хүртлээ дарамтлуулж байсан юм бол нэг ч удаа ангийн удирдлагадаа хэлж байгаагүй, ийм баримт хавтаст хэрэгт байхгүй байна." гэж хэлж байсан байна.

Иймээс цэргийн албан хаагчид, байлдагч нараа дээд тушаалынхаа хүний хууль бус үйл ажиллагааны талаар цаг тухайд нь удирдлагадаа гомдол гаргадаг, түүнийг шуурхай шалгаж холбогдох арга хэмжээг авдаг журам тогтоох шаардлагатай байна. Хилийн цэргийн 0245 дугаар ангийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй байлдагч Ч.Даваадоржийн өвчний түүхтэй танилцаж үзэхэд 3 дугаар заставын харуулын дарга Ууганбаярт толгой руугаа цохиулж, 2006 оны 3 дугаар сарын 25-ны өдөр 10.00 цагт ангийн эмнэлэгт ирж хэвтсэн. Хэвтэх үеийн зовиур нь толгой өвдөнө, бөөлжис цутгана, огиулна, чих шуугина, хоолонд дургүй, шилэн хүзүү хөшиж, ууц

нуруу руу дагаж өвдөнө гэсэн биеийн зовиур бичигдсэн байна. Байлдагч Даваадорж нь ангийн эмнэлэгт 2 удаа хэвтэж, 21 хоног эмчилгээ хийлгэж 61120 төгрөгний эм тариаг хийлгэсэн байна.

0245 дугаар ангийн байлдагч нь Б.Идэрбүрдийн өвчний түүхэнд 2006 оны 11 дүгээр сарын 14-нд хэвтсэн. Баруун чихний мөгөөрс хугарч, шингэн хурсан. 2006 оны 9 дүгээр сарын эхээр жагсаалын дарга Уламбаярт зодуулсны улмаас баруун чих хавдаж томорсон гэж бичигдсэн.

Тус ангийн байлдагч Н.Жарантай 2006 оны 11 дүгээр сарын 15-нд хэвтсэн. Онош: Варикоцель буюу төмсөг томорч хавдсан. Цэрэгт татагдахдаа варикоцель илрээгүй, иймд гэмтлийн гаралтай, төмсөг рүүгээ хүчтэй өшиглүүлсэн байж болзошгүй хэмээн эмч нар нь дүгнэж байгаа хэдий ч байлдагч Н.Жарантай шалтгааныг хэлэхээс татгалзсан байна.

Түүнээс гадна 2005 онд дүрмийн бус харьцаанаас үүдэн хүн амины хэрэг 2 удаа гарсан нь хамгийн ноцтой зөрчил юм.

2005 оны 5 дугаар сард 0245 дугаар ангийн Цахирын 5 дугаар заставын Уулын харуул дээр байлдагч Н.Алтанхуяг, Ч.Энхамар, Д.Отгоншишиг нар заставын орлогч, харуулын даргаа буудаж, амь насыг хохироогоод Оросын Холбооны Улсын хилийг давж зугтаж, ОХУ-ын хуулиар шийтгүүлсэн ба ОХУ тэдгээрийг Монголд шилжүүлэхээс татгалзаж байгаа учир одоо хүртэл энэ хэргийн учир шалтгаан тодроогүй байна.

2005 оны 11 дүгээр сард 4 дүгээр заставын Боголтын харуул дээр байлдагч Эрдэнэдалай харуулын ахлагч, ахлагчийн гэр бүлийн хүн, хамт байсан байлдагчийгаа буудаж, ахлагч нь газар дээрээ амь насаа алдаж, ахлагчийн гэр бүл дахир дутуу болж, буудуулсан байлдагч нь зүүн гараа тайруулж цэргийн албанаас халагдсан байна. Энэ нь харуулын ахлагч захирагдагчтайгаа дүрмийн бусаар харьцаж эрх чөлөөнд нь халдаж, 2 удаа шанаан тус газар нь цохиж авснаас шалтгаалан өширхөж ийм ноцтой хэрэг гарахад хүрсэн байна. Энэ нь харуулын ахлагчаас үүдэлтэй дарамт шахалт байлдагчдаа үзүүлсэн, харьцааны доголдлоос шалтгаалсан байна. Түүний хэрэг шүүхээр хянагдан эцэслэн шийдвэрлэгдээгүй байна.

Мөн 2006 онд ч хүн амины ноцтой хэрэг нэг удаа гарсан байна.

Ийм ноцтой хэргүүд гарах болсон шалтгаан нөхцлийг нарийвчлан тогтоож, хэрэг гарах болсон шалтгаан нөхцлийг арилгах, дахин ийм хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх талаар Хил Хамгаалах Ерөнхий Газар болон цэргийн анги, застав онцгой анхаарах, тодорхой ажил зохиох шаардлагатай байна.

Цэргийн байгууллага дахь дэглэлт, дүрмийн бус харьцаа нь ужгирч хэт лавширвал ямар үр дагаварт хүргэдгийг сүүлийн жилүүдэд гарсан зарим ноцтой гэмт хэргүүд харуулж байна. Иймээс цэргийн байгууллага дахь дүрмийн бус харьцаа, дэглэлтээс урьдчилан сэргийлэх талаар онцгой анхаарах шаардлагатай байна.

## **6. Энгийн ажилчдын эрхийн хэрэгжилт**

Увс аймаг дахь хилийн цэргийн 0245 дугаар ангид хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй 28 ажилтнаас хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтийн байдлын талаар нь ярилцлага хийж, санал асуулга авч дүнг нэгтгэхэд дараахь нөхцөл байдал тодорхойлогдов.

Санал асуулгад оролцсон 28 хүний 75 хувь нь эмэгтэй, 25 хувь нь эрэгтэй бөгөөд насны хувьд 25 хувь нь 20-30 насны, 37.5 хувь нь 30-45 насны, 37.5 хувь нь 45-60 насны ажилчид байв.

Санал асуулгын хуудаснаас харахад тус ангид ажилчдын эрх ашгийг төлөөлсөн үйлдвэрчний байгууллага байдаггүй, хамтын гэрээ хэлэлцээр, хамтын гэрээний талаар ойлголт байхгүй байна.

Харин санал асуулгад оролцогсод бүгд хөдөлмөрийн гэрээ байгуулж, гэрээний нэг хувийг танилцаж авсан байна. Хөдөлмөрийн гэрээтэй холбоотой санал гомдлоос харахад санал асуулгад оролцогсдын 91.7 хувь нь гэрээнд заасан хугацаанаас илүү цагаар тушаалын дагуу ажиллуулдаг гэсэн байна. Мөн сахилгын шийтгэл оногдуулдаг тогтолцоо хууль болон гэрээнд зааснаас өөр байдаг. Жишээ нь, сануулахгүй цалинг хэт өндөр хувиар хасахыг эрхэмлэдэг, тодорхой шалтгаангүйгээр цалин хөлснөөс хасаж шийтгэдэг, офицер, ахлагч нар энгийн ажилчид хамаардаг, дандаа дарамталж, загнаж тушааж ажиллуулдаг, зарим харуулын дарга нар 3-4 сар гэртээ харилгүй харуулд гардаг, гэр орон эхнэр хүүхдээ үзэлгүй 3-6 сар харуулд гарах нь жирийн үзэгдэл болдог, 3-7 сар гэр орондоо ирэлгүй ажилладаг зэрэг гомдлыг санал асуулгад дурдсан байна.

Тус байгууллагаас ажилчдынхаа цалин хөлсийг ажилласан цагаар тооцож олгодог гэж 80.7 хувь нь хариулсан.

Санал асуулгад оролцогсдын дийлэнх буюу 63.6 хувь нь адил хөдөлмөр эрхэлж байгаа эрэгтэй, эмэгтэй хүнд адил цалин хөлс олгодоггүй гэж хариулсан байна.

Байгууллагаас олгох нэмэгдэл хөлсний хувьд асуулгад оролцогсдоос саналыг авахад 74.1 хувь нь ажлын үр дүнгийн нэмэгдэл хөлс олгодоггүй, 81.5 хувь ажил албан тушаал хавсран гүйцэтгэсний нэмэгдэл хөлсийг олгодоггүй, 96 хувь нь ажлын байрны тодорхойлолтод заагаагүй ажил үүрэг гүйцэтгэсний нэмэгдэл хөлс олгодоггүй, 81.5 хувь нь шөнө ажилласны нэмэгдэл хөлс олгодоггүй, 84 хувь нь илүү

цагаар ажилласны нэмэгдэл хөлс олгодоггүй, 95.8 хувь нь нийтээр амрах баярын өдөр ажилласны нэмэгдэл хөлс олгодоггүй, 95.8 хувь нь 7 хоногийн амралтын өдөр ажилласны нэмэгдэл хөлс олгодоггүй гэж тус тус хариулсан байна. Мөн 90.9 хувь нь мэргэжлийн зэргийн нэмэгдэл олгодоггүй, 91.7 хувь нь хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл олгодоггүй гэж хариулсан байна.

Хөдөлмөрийн тухай хуульд заасан олговол зохих олговрын хувьд сул зогсолтын үеийн олговор, өөр орон нутагт ажиллахаар шилжих үед олгох олговор, байгалийн гамшиг, осол тохиолдох болон бусад хүндэтгэн үзэх шалтгаанаар ажилдаа ирээгүй үеийн олговор, ажилтныг эрүүл мэндэд нь харшлахгүй өөр ажилд шилжүүлсэн үед цалингийн зөрүүний олговор, буруу халсан буюу шилжүүлсэн үеийн олговор олгодоггүй гэж тус тус хариулжээ.

Тус хилийн цэргийн ангиас шилжин томилогдох, бэлтгэлээр халагдах үед олгогдох ёстой оршин суух газарт нь хүргэхтэй холбоотой хөлсний 54.5 хувийг олгодог, 45.5 хувь нь олгодоггүй гэжээ. Тус ангид ажиллагсад ээлжийн амралтаа цаг тухайд нь эдэлдэг, ажлын байрны хэвийн нөхцөлд ажилладаг гэж санал асуулгад оролцогсдын дийлэнх хувь нь хариулсан байна.

Хөдөлмөр хамгааллын хувьд хөдөлмөрийн нөхцөл, ажил үүрэгт тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангадаг гэж дийлэнх хувь нь хариулсан боловч цаг уурын тааламжгүй нөхцөлд задгай газар, халаалтгүй байранд ажиллаж байгаа тохиолдолд амрах, дулаацах, хоргодох ахуйн байр байгуулаагүй, хөдөлмөрийн хэвийн бус орчинд ажилладаг ажилтанд хор саармагжуулах бодис, хүнсний бүтээгдэхүүн олгодоггүй, эрүүл мэндийн үзлэгт жилд нэг буюу түүнээс дээш удаа оруулдаггүй, хөдөлмөр хамгааллын зааварчилгаа өгөх, ажлын байран дээр сургалт зохион байгуулдаггүй, буруу халсан буюу шилжүүлсэн үеийн олговор олгодоггүй гэсэн зөрчлүүд санал асуулгын хуудаснаас харагдаж байна.

Жирэмсэн эмэгтэй, 8 хүртэлх насны хүүхэдтэй ганц бие эх, ганц бие эцгийг өөрөө зөвшөөрөөгүй тохиолдолд шөнийн буюу илүү цагаар, түүнчлэн албан томилолтоор ажиллуулдаг гэж санал асуулгад оролцогсдын дийлэнх хувь хариулсан байна.

Жирийн ажлын өдөр нялх хүүхэдтэй эх, ганц бие эцэгт хүүхэд асрах нэмэлт чөлөө олгодоггүй гэж санал асуулгад оролцогсдын 75 хувь хариулсан байна.

Танай байгууллагад хөдөлмөрийн хамтын маргаан гарч байсан уу гэсэн асуултад 92.9 хувь нь үгүй гэж хариулсан ба гарч байсан хөдөлмөрийн маргааныг хэрхэн шийдвэрлэдэг вэ гэсэн асуултын хариултаас үзэхэд хөдөлмөрийн маргаан гаргах нөхцөлгүй, ажил олгогчтой хэрэв маргавал гадуурхан шууд тушаал гаргаж халдаг зөрчил ажиглагдаж байна. Түүнчлэн танай байгууллагад хөдөлмөрийн маргаан таслах комисс бий юу 73.7 хувь нь байхгүй гэж хариулжээ.

Санал асуулгын хуудасны сахилгын шийтгэл оногдуулдаг хэлбэрийг асуусан хариултаас нотлогдож байна. Санал асуулгад оролцогсод 100 хувь нь ажлаас халах хэлбэрийн сахилгын шийтгэлийг оногдуулдаг гэсэн байна.

Санал асуулгад оролцсон хүмүүс тухайн байгууллагад доод тал нь 3 сар, дээд тал нь 26 жил ажилласан, 60000-80000 төгрөгийн цалин авдаг хүмүүс байсан.

Өдөрт дунджаар хэдэн цаг ажилладаг вэ гэсэн асуултын хариултаас харахад дийлэнх нь 8 цагаас дээш, асуулгад оролцогсдын 19 хувь нь 24 цаг гэж хариулснаас үзэхэд илүү цагаар их хэмжээгээр ажиллуулдаг нь харагдаж байна. Илүү цагаар, хагас бүтэн сайнгүй, амралт чөлөөгүй ажиллуулснаас нэг мужаан хөрөөнд гараа авахуулсан осол гарсан байна.

Сүүлийн 5 жил үйлдвэрлэлийн осол гарч байсан уу гэсэн асуултын хариултаас харахад тус ангид буу зэвсгийн осол байнга гардаг, тэрчлэн үүнээс болж 2006 онд л гэхэд 4 хүний амь эрсэдсэн том зөрчил гарсан байна.

Түүнчлэн хүүхэд төрүүлэх, асрахтай холбоотойгоор чөлөө олгодоггүй, 0-2 насны хүүхэдтэй эхэд хуульд заасан чөлөөг нь олгодоггүйгээр барахгүй илүү цагаар хүртэл ажиллуулдаг, мөн эрүүл мэндийн эмчийн үзлэг хяналтад байж чаддаггүй талаар бичсэн байна.

II. Увс аймаг дахь хилийн цэргийн 0311 дүгээр ангид хөдөлмөр эрхэлж буй 17 ажилтнаас хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтийн байдалд нь шалгалт хийж, санал асуулга авч дүнг нэгтгээд дараахь байдлыг тодорхойлов. Үүнд:

Санал асуулгад оролцсон 17 хүний 25 хувь нь эмэгтэй, 75 хувь нь эрэгтэй ба насны хувьд 25 хувь нь 20-30 насны, 50 хувь нь 30-45 насны, 25 хувь нь 45-60 насны ажилчид байлаа.

Хамтын гэрээ хэлэлцээр, хамтын гэрээний хувьд 0245 дугаар ангитай адил ойлголт байхгүй, харин хөдөлмөрийн гэрээг 100 хувь байгуулж, дийлэнх нь гэрээний нэг хувийг танилцаж авсан гэж хариулжээ.

Цалин хөлсийг цагаар тооцож, бэлнээр олгодог байна.

Адил хөдөлмөр эрхэлж байгаа эрэгтэй, эмэгтэй хүнд адил цалин хөлс олгодог гэж санал асуулгад оролцогсдын 83.3 хувь нь хариулжээ.

Байгууллагаас олгох нэмэгдэл хөлсний хувьд асуулгад оролцогсдоос саналыг авахад албан тушаал хавсран гүйцэтгэсний нэмэгдэл хөлс, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй ажил үүрэг гүйцэтгэсний нэмэгдэл хөлс, шөнө ажилласны нэмэгдэл хөлс, илүү цагаар ажилласны нэмэгдэл хөлс, нийтээр амрах баярын өдөр ажилласны нэмэгдэл хөлс, 7 хоногийн амралтын өдөр ажилласны нэмэгдэл хөлс олгодоггүй гэж тус тус хариулсан байна. Мөн дийлэнх хувь нь



мэргэжлийн зэргийн нэмэгдэл олгодоггүй, хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл олгодоггүй гэж хариулсан байна.

Хөдөлмөрийн тухай хуульд заасан олговол зохих олговрын хувьд сул зогсолтын үеийн олговор, байгалийн гамшиг, осол тохиолдох болон бусад хүндэтгэн үзэх шалтгаанаар ажилдаа ирээгүй үеийн олговор, ажилтныг эрүүл мэндэд нь харшлахгүй өөр ажилд шилжүүлсэн үед цалингийн зөрүүний олговор олгодоггүй гэж тус тус хариулжээ.

Шилжин томилогдох, бэлтгэлээр халагдах үед олгогдох ёстой оршин суух газарт нь хүргэхтэй холбоотой хөлсийг 100 хувь буюу бүгд олгодог гэж хариулжээ.

Илүү цагаар, тушаалын дагуу ажилладаг гэж санал асуулгад оролцогсдын дийлэнх хувь нь хариулжээ.

Ээлжийн амралтаа цаг тухайд нь эдэлдэг. Ажлын байрны хэвийн нөхцөлд ажилладаг гэсэн байна.

Хөдөлмөр хамгааллын хувьд дийлэнхи хувь нь тийм буюу хөдөлмөр хамгааллын арга хэмжээг тус ангиас сайн хангадаг гэсэн байна.

Мөн жирэмсэн эмэгтэй, 8 хүртэлх насны хүүхэдтэй ганц бие эх, ганц бие эцгийг өөрөө зөвшөөрөөгүй тохиолдолд шөнийг буюу илүү цагаар, түүнчлэн албан томилолтоор ажиллуулдаггүй гэж 83.3 хувь нь хариулсан байна.

Жирийн ажлын өдөр нялх хүүхэдтэй эх, ганц бие эцэгт хүүхэд асрах нэмэлт чөлөө олгодог гэж санал асуулгад оролцогсдын 80 хувь нь хариулжээ.

100 хувь нь ажлаас халах хэлбэрийн сахилгын шийтгэлийг оногдуулдаг гэж хариулсан байна.

Санал асуулгад оролцсон хүмүүс тухайн байгууллагад доод тал нь 1 жил, дээд тал нь 11 жил ажилласан, 58000-70000 төгрөгийн цалин авдаг гэж хариулсан байна.

Тэд өдөрт дунджаар 8-10 цаг ажилладаг гэж ихэнх нь хариулсан байна.

Танай байгууллагад сүүлийн 5 жил үйлдвэрлэлийн осол гарч байсан тохиолдол бий юу? Ийм тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байсан уу? Үйлдвэрлэлийн осол гарсан тохиолдолд байгууллагаас ямар арга хэмжээ авсан бэ? гэсэн асуултуудад хариулт өгөөгүй байсан.

Танай байгууллагад ямар тохиолдолд сахилгын шийтгэл оногдуулдаг вэ гэсэн асуултад ялимгүй зүйлд цалингийн хувиар торгох маягаар шийтгэдэг гэж 1 хүн хариулсан бусад хүмүүс хариулт өгөөгүй.

Илүү цагаар цалин хөлсгүй ажиллуулдаг зөрчил санал асуулгаас ажиглагдсан.

Санал асуулгаас харахад тус ангийн удирдах албан тушаалтан, ажилтнуудын хоорондын харилцаа харьцангуй нөгөө ангиасаа гайгүй, зөрчил бага байгаа нь ажиглагдаж байна.

## **7. ДҮГНЭЛТ, САНАЛ, ЗӨВЛӨМЖ**

Шалгалтын явцад авсан санал асуулга, ярилцлага, ажиглалт, олж авсан мэдээллээс харахад Увс аймаг дахь Хил Хамгаалах Ерөнхий Газрын харьяа хилийн цэргийн отрядуудын хүрээнд цэргийн албан хаагчид захиргаандаа байгаа албан хаагчтай дүрмийн бусаар харьцах, хүч хэрэглэх зэрэг зөрчлүүд бага бус гардаг гэж үзэх үндэстэй байна.

Ялангуяа ийм зөрчил хилийн цэргийн 0245 дугаар ангийн харьяа застав, харуулууд дээр илүү гардаг гэж үзэх үндэстэй байна. Энэ ангийн хэмжээнд сүүлийн жилүүдэд хүн амины ноцтой хэрэг нэг бус удаа гарч, олон хүний амь эрсдэж, хүнд хор уршиг учирсан байна. Хилийн цэргийн 0311 дүгээр ангид гэмтэл бэртэл авсан, өвдсөн албан хаагч амь насаа алдсан тохиолдол гарсан байна.

Дарга, захирагчдаа зодуулж бие эрхтэндээ гэмтэл бэртэл авсан цэргүүд цэргийн эмнэлэгт удаа дараа хэвтэж эмчлүүлж, багагүй хохирол зардал гарсан байна. Санал асуулгад хамрагдсан хуучин цэргүүдийн нилээд хувь нь дүрмийн бус харьцаа байдаг гэдгийг хүлээн зөвшөөрсөн байна. Ийм зөрчлийг хил хамгаалах байгууллагын хүрээнд байж болшгүй зөрчил дутагдал гэж үзэхээс өөр аргагүй, энэ зөрчлийг юугаар ч зөвтгөх аргагүй гэж дүгнэж байна.

Цэргийн албан хаагчдын амрах, ажиллах, суралцах орон байрны хувьд хүрэлцээ муутай, ахуй нөхцөл шаардлагын хэмжээнд хүрээгүй, цэргийн албан хаагчид чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх ая тухтай нөхцөл бүрэн бүрдээгүй, цэргийн албан хаагчдын дунд соёл хүмүүжлийн болон бие бялдраа хөгжүүлэх ажил учир дутагдалтай байна.

Цэргийн ангид хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсадын хөдөлмөрийн харилцааг хөдөлмөрийн хуулийн хүрээнд зохицуулж, хөдөлмөрийн гэрээнийхээ заалтыг хатуу мөрдөж, хууль тогтоомж зөрчиж байгаа аливаа үйлдлийг зргсоох шаардлагатай байна. Шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, дахин гаргахгүй байх үүднээс дараах зүйлүүдийг санал зөвлөмж болгож байна.

1. Цэргийн албан хаагчдаас бусдынхаа амь насыг санаатайгаар бүрэлгэсэн, зарим албан хаагчид өвчний болон гэмтлийн улмаас нас барсан ноцтой зөрчилд дүгнэлт хийж, шалтгаан нөхцлийг судалж, шалтгаан нөхцлийг нь арилгах, цэргийн байгууллагад захирагч, захирагдагч, байлдагч нарын хооронд гарч байгаа аливаа дүрмийн бус харьцаа ялангуяа хүч хэрэглэх, дэглэх зэрэг ноцтой зөрчлүүдийг таслан зогсоох, офицер, ахлагч, түрүүч зэрэг удирдах тушаалын албан хаагчдын харьцааны соёлыг дээшлүүлэх,

зөвхөн хууль, цэргийн дүрмийн хүрээнд харьцаж, цэргийн сахилга, дүрэм зөрчсөн цэргийн албан хаагчид цэргийн дүрмийн хүрээнд сахилгын шийтгэл оноодог болгох талаар удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

2. Байлдагч нартай дүрмийн бусаар харьцсан, хүч хэрэглэсэн, дэгэлсэн, дүрмийн бус шийтгэл хүлээлгэсэн тохиолдол бүрийг судлан бүртгэж, гэм буруутай албан хаагчид зохих хариуцлага тооцож, нийт бие бүрэлдэхүүнээр хэлэлцүүлж, тодорхой арга хэмжээ авч хэвших.
3. Шалгалт явагдах үед эмнэлэгт хэвтэж байсан нэр бүхий хүмүүстэй дүрмийн бусаар харьцаж, эрх чөлөөнд нь халдаж, гэмтэл учруулсан тухай илтгэх хуудсанд дурьдагдсан албан хаагчдад хариуцлага тооцож хариу мэдэгдэх.
4. Цэргийн албан хаагчдын орон байрны ахуй нөхцлийг сайжруулах, отрядууд дээр шинээр цэрэг татагдан бэлтгэл сургуулилт хийх үед байлдагч нарын амьдрах ахуй нөхцлийг дээшлүүлэх, цэрэг бүрийг ор дэвсгэрээр хангах, унтаж амрах нөхцлийг нь бүрдүүлэх, хоол хүнсний хангамж, чанарын доголдлыг арилгаж, цэргийн албаа нэр хүндтэй хаах нөхцлийг нь дээшлүүлэх.
5. Цэргийн албан хаагчдын эрүүл мэндийн үйлчилгээнд гарч буй зөрчил дутагдлыг арилгаж, эмнэлгийн үйлчилгээг хил хамгаалах үндсэн нэгж болох хилийн харуул, заставт ойртуулах, заставыг эрүүл мэндийн анхны тусламж үзүүлэх боловсон хүчнээр хангах, байлдагч, ахлагч нарт эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлэх, байгаа эм, тарилгыг юунд яаж хэрэглэх талаар анхны мэдэгдэхүүн олгох талаар анхаарч ажиллах.
6. Хил хамгаалах үүрэг бүхий офицер, ахлагч, байлдагч нар чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх ахуй нөхцлийг сайжруулж, бие бялдраа хөгжүүлэх, бие хамгаалах урлагт суралцах, спортоор хичээллэхэд шаардагдах тоног төхөөрөмжөөр хангах, ажлын ачаалал, стрессээ тайлах, харилцааны ёс зүйн талаар сургалт явуулах талаар системтэй ажил зохион байгуулах.
7. Цэргийн анги отрядын эмнэлгийн албыг бэхжүүлэхэд байгаа нөөц бололцоогоо дайчлан, албан хаагчдыг эрүүлжүүлэх, ажиллах нөхцөл бололцоог нь дээшлүүлэх, орон байраар хангах чиглэлээр тодорхой ажил зохиох.
8. Хилийн цэргийн байгууллагын хэмжээнд байлдагч болон цэргийн албан хаагчид захирагч /дээд албан тушаалтан/-хаа хууль бус харьцаа, үйл ажиллагаанд гомдол санал гаргах уур амьсгалыг бүрдүүлэх, ингэснийх нь төлөө аливаа дарамт шахалт үзүүлдэггүй байх нөхцлийг бүрдүүлэх

9. Цэргийн байгууллагад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй энгийн ажилчдын хөдөлмөрийн харилцааг хөдөлмөрийн хууль бусад хуулийн хүрээнд зохион байгуулж, илүү цагаар амралт чөлөөгүй ажиллуулах, хөдөлмөрийн гэрээнд зааснаас өөр ажил гүйцэтгүүлэх, хууль бусаар цалин хөлснөөс нь суутгах, хууль бус шийтгэл хүлээлгэх зэрэг зөрчлийг арилгаж ажиллах.

Шалгалтын тайлан бичсэн

Ж.Дашдорж  
А.Саруул  
Ж.Цолмон  
З.Өнөржаргал



## ХХЕГ-ЫН ХАРЬЯА ХИЛИЙН ЦЭРГИЙН АНГИУДАД ХИЙСЭН ШАЛГАЛТЫН ИЛТГЭХ ХУУДАС

ХХЕГ-ын харьяа Дорноговь аймгийн нутаг дэвсгэрт орших хил хамгаалах анги салбаруудад Комиссын даргын баталсан удирдамжийн дагуу 2006 оны 11 дүгээр р сарын 15-наас 11 дүгээр сарын 21-ны өдрүүдэд шалгалт хийлээ.

Шалгалтыг Дорноговь аймгийн Сулинхээрийн хилийн цэргийн 0168-р отряд, хилийн 0108-р застав, Ханги Мандлын хилийн боомт, Замын-Үүдийн хилийн цэргийн 0108-р отряд, хилийн застав, хилийн харуул, хилийн Шалган нэвтрүүлэх боомт, Улаан-Уулын хилийн 0129-р отряд, хилийн заставуудын үйл ажиллагаа явуулж байгаа байрлал, байрууд, хилийн цэрэгт алба хааж буй дайчдын байр, эмнэлэг, сахилгын байр, хил зөрчигчийн түр орогнох байр зэргээр нэгбүрчлэн орж хилийн цэргийн офицер, ахлагч болон энгийн ажиллагсад, хугацаат цэргийн алба хааж буй байлдагч нараас нэг бүрээс тусгай санал асуулгын хуудсаар судалгаа авч, шаардлагатай зарим дүрс, зургийг фото зургийн хальснаа буулгаж, холбогдох мэдээ, судалгааг гаргуулж, дүн бүртгэл, нууцын зэрэглэлтэйгээс бусад анги байгууллага дээр мөрдөгдөж байгаа тушаалууд болон өргөдлүүдтэй нэгбүрчлэн танилцаж, дүгнэлт хийх замаар шалгалтыг явууллаа.

Шалгалтын явцад нийт хугацаат цэргийн 230 албан хаагч, 130-аад ахлах дунд шатны офицер, 47 энгийн албан хаагч нартай уулзаж, нийт 5 застав, 3 хилийн харуул тус бүрээр орж хугацаат цэргийн алба хааж байгаа болон тэнгд ажиллаж байгаа албан хаагч нартай уулзаж, санал хүсэлтийг нь сонсож тэмдэглэл хөтлөн, зарим хүмүүсийн гаргасан санал хүсэлтийг газар дээр нь шийдвэрлүүлсэн болно. Захиргааны албан хэрэг хөтлөлтийн хувьд бүх ангиуд дээр ангийн захирагчийн зүгээс гарган мөрдөж байгаа тушаал шийдвэрүүд нь холбогдох хуулийн заалтыг удирдлага болгон хэрэглэдэггүй, тушаал, хурлын тэмдэглэл, илтгэх хуудсуудаа хооронд нь хольж гаргадаг, хуулинд байхгүй үг хэллэгийг ихээр хэрэглэн тушаал шийдвэрүүд гарган мөрдүүлдэг зэрэг дутагдал нийтлэг байна.

Мөн цэргийн албан хаагч, иргэдээс гаргаж буй өргөдөл гомдлын шийдвэрлэлт нь тодорхой бус, хуулийн заалтыг зөрчин иргэдээс өргөдөл гомдол хүлээн авдаг, тодорхой нэр, хаяггүй өргөдлүүд ирсэн өргөдөлийн дийлэнхи хувийг эзэлж байна. Нөгөөтэйгүүр бүх ангиуд дээр мөн адил мэргэжлийн хяналтын холбогдох газруудаар орон байрны чийглэг болон хоолны килокалорийг тогтоолгох ажил огт хийгдээгүй байна.

### **Нэг.Орон байрны нөхцөл байдлын талаар**

1.1 Дорноговь аймгийн Хатанбулаг сумын нутагт орших Хилийн цэргийн 0168-р ангийн хугацаат цэргийн албан хаагчдын байрлах орон байрны нөхцөл байдалд шалгалт хийлээ. Шалгалтыг хийхдээ Хил хамгаалах ерөнхий газрын даргын 2002 оны А/16 тоот тушаалаар батлагдсан “Хилийн тусгай анги, салбарын цэргийн албаны зохион байгуулалтын заавар”-ыг удирдлага болгосон болно. Шалгалт хийх үед тус ангид нийт 4 салааны 120 хугацаат цэргийн албан хаагч алба хааж байсан. ХЦАХ-ын унтлагын 3 байр, 1 угаалгын өрөө, 1 усанд орох өрөө, үсчин, угаалгын газар, ахуйн үйлчилгээний зориулалтаар ашигладаг өрөө болон гадаа бие засах газар шалгалтанд хамрагдлаа.

Сулинхээрийн хилийн цэргийн отряд дээр үйл ажиллагаа явуулж буй штаб, эмнэлэг болон бусад байрууд нь анх 1973 онд ашиглалтанд орсон гэх бөгөөд түүнээс хойш өөрсдийн хүчээр урсгал засварын ажил хийгдэж ашиглагдаж байна. Тэнд ашиглагдаж байгаа эмнэлэгийн байр нь гэхэд л гэрэлтүүлэг маш муутай, намхан таазтай эмнэлэгийн зориулалтаар ашиглах ямар ч боломжгүй байранд өнөөдрийн байдлаар ангийн эмнэлэг үйл ажиллагаагаа явуулж байна.

Орон байрны нөхцөлд хийсэн шалгалтын дүнд дараах зүйлс тогтоогдож байна.

А.Унтлагын байр:

- 1-р салааны унтлагын байр 10x16 м<sup>2</sup> талбайтай. Салааны нийт цэргийн тоо 30. Орны тоо 34. Уг байранд ХЦАХ-тай хамт 1 ахлагч байрлаж байлаа. 1 хүнд ноогдох талбайн хэмжээ 5.16 м<sup>2</sup> байгаа нь зааварт заасан талбайн хэмжээг хангаж байна. Унтлагын байранд 4 салхивчаар механик агааржуулалт хийдэг. 2x1 м<sup>2</sup> хэмжээтэй 8 цонхтой. Байгалийн гэрэлтүүлэг хангалттай. 100 ваттын 3 чийдэнгээр зохиомол гэрэлтүүлэг хийдэг. Халаалт хэвийн олгогдож байсан.

Тасалгааны дулааныг хэмжиж хэмжүүр байхгүйн улмаас дулааны хэмийг нарийвчлан тогтоогоогүй. 2 цэргийн дунд 1 тумбочка тавьж олгосон.

- 2-р салааны унтлагын байр 10x13 м<sup>2</sup> талбайтай. Салааны нийт цэргийн тоо 30. Орны тоо 32. 1 хүнд ноогдох талбайн хэмжээ 4.06 м<sup>2</sup> байгаа нь зааварт заасан талбайн хэмжээг хангаж байна. Унтлагын байранд 25x25 см<sup>2</sup> хэмжээтэй 6 салхивчаар механик агааржуулалт хийдэг. 2x1 м<sup>2</sup> хэмжээтэй 6 цонхтой. Байгалийн гэрэлтүүлэг хангалттай. 100 ваттын 4 чийдэнгээр зохиомол гэрэлтүүлэг хийдэг. Халаалт хэвийн. 2 цэргийн дунд 1 тумбочка тавьж олгосон.
- 3, 4-р салаа ангийн спорт зааланд байрладаг. Талбайн хэмжээ 280 м<sup>2</sup>. Зориулалтын бус байранд байрласан учраас агааржуулалт, гэрэлтүүлэг стандартын шаардлагыг хангаагүй. Халаалт тавьсан боловч дулааны хэм 20<sup>0</sup>-аас бага байгаа нь илэрхий байсан. Тасалгааны дулааныг хэмжиж хэмжүүр байхгүйн улмаас дулааны хэмийг нарийвчлан тогтоогоогүй. 4 цэргийн дунд 1 тумбочка олгосон.
- Ор, дэрний цагаан хэрэглэлийн хангалтын байдал ангийн хэмжээнд ижил. ХЦАХ-д зааварт заасан ор, дэрний цагаан хэрэглэл, хөнжил, орны бүтээлэг, 1 дэр, 2 эсгий гудсыг тавьж олгосон байлаа. Хангалтаар олгосон ор дэрний цагаан хэрэгслийн чанар хангалтгүй. Орны бүтээлэг, хөнжил, гудсыг 7 жил ашиглаж байгаа гэсэн боловч зааварт заасны дагуу ашиглалтанд орсон хугацааг заагаагүй. 1 ХЦАХ-д 2 гудас тавьж олгох ёстой боловч 2 эсгий давхарлагатай 1 гудас тавьж олгосон. Гудасны хэмжээ жижиг, чанарын шаардлага хангаагүй. Хөнжил, дэр нимгэн. Цагаан хэрэгслэлийг шинээр тавьж олгосон байв.

#### Б.Ариун цэвэр, ахуйн үйлчилгээний зориулалт бүхий өрөө

- Ахуйн үйлчилгээний зориулалт бүхий өрөөг зааврын дагуу тохижуулаагүй. Индүүдлэг хийх, үс засах зориулалтын тусгай өрөөтэй. Индүүдлэгийн 1 тавцан, 1 индүү, үсчний 1 суудалтай. Гутал засах, оёдол хийх зориулалтын өрөөгүй. Гутал засах тоног төхөөрөмж байгаа гэх боловч тухайн үед ашиглах боломжгүй, бэлэн бус байлаа. Дашрамд дурдахад 7 хоногийн өмнө тавьж олгосон цэргийн гутал ханзарсан байгаа нь хангалтын хувцас, хэрэглэлийн чанар муу байгааг илтгэж байна. Байнгын ашиглалтанд байдаг эсэх нь тодорхой бус. Ахуйн үйлчилгээний мөрдөх журам, хувиар, аюулгүй ажиллагааны зааварчилгааг ашиглаж буй өрөө тасалгаанд байрлуулаагүй.

- 1, 2-р салааны байранд байрлах гар нүүр угаах 1 цэгийг нийт ХЦАХ ашигладаг. 8 угаалтууртай, 2 нь огт ажиллагаагүй, 2 угаалтуур гэмтэлтэй, ус гоожихдоо муу. Зааварт заасны дагуу тус ангид хамгийн багадаа 18 угаалтуур байх ёстой бөгөөд бодит нөхцөл байдал стандартаас нэн доогуур байна. Хөл угаах онгоц тус ангид байхгүй. Гар угаах өрөөний агааржуулалт хэвийн. Цэвэрлэгээг өдөр тутам цэргүүд хийдэг. Өрөөнд толь байрлуулсан, 2% хлорын уусмал тавьж олгосон байлаа. Стандартын дагуу өрөөний ханыг шаазан хавтангаар өнгөлөөгүй.
- Ангийн хэмжээнд ХЦАХ-д зориулсан 7 душ, офицер, ахлагчдад зориулсан тасалгаа бүхий 5 душтэй усанд орох өрөөтэй. 7 хоногийн амралтын өдрүүдэд ангийн бие бүрэлдэхүүнд усанд орох боломжтой. Ариутгал цэвэрлэгээг усанд орсны дараа долоо хоногт нэг удаа хийдэг. Ариутгал, цэвэрлэгээний хэрэгсэл, бодис бэлэн үзүүлэхээр байгаагүй.
- Тус анги гадна байрлалтай нэгдсэн бие засах газартай. Бие засах газрын нэг хана задгай, тавцангуудын хооронд тусгаарлалтгүй. Нийт 9 тавцантай. Тавцангийн тоог ангийн нийт бие бүрэлдэхүүний тоотой харьцуулахад стандартад зааснаас /Тус ангид хамгийн багадаа 15 суудал бүхий бие засах газар байх ёстой/ бага байна. Хариуцсан албан тушаалтны ярьснаас долоо хоног бүрийн Лхагва гараг бүр ариутгал хийдэг гэх боловч бодит байдал дээр сүүлийн 1 сар орчимд ариутгал хийгээгүй байдал ажиглагдаж байлаа. /Шалгалтыг Пүрэв гарагт хийсэн./

#### В.Уулзалтын байр

Цэргийн албан хаагчийн ар гэрээс эргэлт, уулзалт ирэх тохиолдолд ангийн Зочид буудалд хүлээн авдаг. Ангийн зочид буудалд 2005 онд их засвар хийсэн, тохижилт сайн. Хоолны заал, хоол бэлтгэх өрөө, ариун цэврийн өрөө болон 9 ор бүхий 3 унтлагын өрөөтэй. Цэргийн албан хаагчийн ар гэрт төлбөргүй үйлчилж байгаа нь сайшаалтай байна.

#### Г.Сахилгын байр

Тус ангид сахилгын байр байхгүй. Хууль тогтоомж, дүрэм журмын дагуу цэргийн албан хаагчид арга хэмжээ авах тохиолдолд стандартад заасан өрөө байр байхгүй байгаа нь анхаарал татаж байна.

УИЧ.МН  
СУДАЛГААНЫ САН



1.2 Замын-Үүд сумын нутагт орших Хилийн цэргийн 0108-р ангийн хугацаат цэргийн албан хаагчдын байрлах орон байрны нөхцөл байдалд шалгалт хийлээ. Шалгалтыг хийхдээ Хил хамгаалах ерөнхий газрын даргын 2002 оны А/16 тоот тушаалаар батлагдсан “Хилийн тусгай анги, салбарын цэргийн албаны зохион байгуулалтын заавар” болон “Цэргийн сахилгын дүрэм”-ийг удирдлага болголоо. ХЦАХ-ын 2 заставын унтлагын байр, угаалгын өрөө, ахуйн үйлчилгээний зориулалт бүхий өрөө, усанд орох өрөө, угаалгын газар, гадна бие засах газар болон сахилгын байр үзлэгт хамрагдлаа.

Орон байрны нөхцөлд хийсэн шалгалтын дүнд дараах зүйлс тогтоогдож байна.

А.Унтлагын байр:

- 1-р заставын цэргийн албан хаагчийн унтлагын байр 16x14 талбайтай. Заставын нийт цэргийн тоо 38. Орны тоо 38. 1 хүнд ноогдох талбайн хэмжээ 5.8 м<sup>2</sup> байгаа нь зааварт заасан талбайн хэмжээг хангаж байна. Унтлагын байранд 2 салхивчаар механик агааржуулалт хийдэг. 2x1.5 м<sup>2</sup> хэмжээтэй 8 цонхтой. Байгалийн гэрэлтүүлэг хангалттай. 60 ваттын 9 чийдэнгээр зохиомол гэрэлтүүлэг хийдэг. Халаалт тавьсан боловч дулааны хэм 20<sup>0</sup>-аас бага байгаа нь илэрхий байсан. Тасалгааны дулааныг хэмжиж хэмжүүр байхгүйн улмаас дулааны хэмийг нарийвчлан тогтоогоогүй.
- 2-р заставын цэргийн албан хаагчийн унтлагын байр 13x15 талбайтай. Заставын нийт цэргийн тоо 27. Орны тоо 24. Заставын цэргүүд ээлжээр хилийн харуул дээр ажилладаг /Нэг удаа 5 цэрэг 3 хоногоор харуул дээр байрлаж ажилладаг./ бөгөөд орны тоо дутагдалтай байгааг цэргүүдийн ээлжээр ажиллах үүрэгтэй холбон тайлбарлаж байлаа. Тус байранд 1 хүнд ноогдох талбайн хэмжээ 7 м<sup>2</sup> орчим байгаа нь зааварт заасан талбайн хэмжээг хангаж байна. Унтлагын байранд 25x50 см<sup>2</sup> хэмжээтэй 1 салхивчаар механик агааржуулалт хийдэг. 2x1 м<sup>2</sup> хэмжээтэй 8 цонхтой. Байгалийн гэрэлтүүлэг хангалттай. 100 ваттын 4 чийдэнгээр зохиомол гэрэлтүүлэг хийдэг. Халаалт хэвийн. Тасалгааны дулааныг хэмжиж хэмжүүр байхгүйн улмаас дулааны хэмийг нарийвчлан тогтоох боломжгүй байлаа.

- Ор, дэрний цагаан хэрэглэлийн хангалтын байдал ангийн хэмжээнд ижил. ХЦАХ-д зааварт заасан ор, дэрний цагаан хэрэглэл, хөнжил, орны бүтээлэг, 1 дэр, 2 эсгий гудасыг тавьж олгосон байлаа. Орны бүтээлэг, хөнжил, гудсыг 2 жил ашиглаж байгаа гэсэн боловч зааварт заасны дагуу ашиглалтанд орсон хугацааг заагаагүй. Гудас, хөнжил, дэрний чанар харьцангуй сайн. Цагаан хэрэгслийг шинээр тавьж олгосон байв.

Б.Ариун цэвэр, ахуйн үйлчилгээний зориулалт бүхий өрөө

- Ахуйн үйлчилгээний зориулалт бүхий өрөөг завтавын байр тус бүрт зааврын дагуу тохижуулсан байна. Өрөөнүүдийг байнга ашиглах боломжтой. Ахуйн үйлчилгээний мөрдөх журам, хувиар, холбогдох стандартуудыг ашиглаж буй өрөө тасалгаанд байрлуулсан. Ахуйн үйлчилгээний хэрэгслүүдтэй ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгааг бүрэн хийж байрлуулаагүй байна.
- 1-р заставын гар нүүр угаах цэг 4 угаалтууртай. Шалгалт хийх үед 1 угаалтуурт ус ирээгүй байсан. Зааварт заасны дагуу тус заставт хамгийн багадаа 6 угаалтуур байх ёстой бөгөөд бодит нөхцөл байдал стандартаас доогуур байна. 2-р заставын гар нүүр угаах цэг бүрэн ажиллагаатай 4 угаалтууртай. Хөл угаах онгоц тус ангид байхгүй. Гар угаах өрөөнүүдийн агааржуулалт хэвийн. Цэвэрлэгээг өдөр тутам цэргүүд хийдэг. Өрөөнд толь байрлуулсан, 0.2% хлорын уусмал тавьж олгосон байлаа.
- Ангийн хэмжээнд ХЦАХ-д зориулсан 4 душ, офицер, ахлагчдад зориулсан 2 душтэй усанд орох өрөөтэй. 7 хоногийн амралтын өдрүүдэд ангийн бие бүрэлдэхүүнд усанд орох боломжтой. Ариутгал цэвэрлэгээг усанд орсны дараа тухай бүр хийдэг.
- Тус анги гадна байрлалтай нэгдсэн бие засах газартай. Нийт 7 тавцантай. Тавцангийн тоог ангийн нийт бие бүрэлдэхүүний тоотой харьцуулахад стандартад зааснаас /Тус ангид хамгийн багадаа 15 суудал бүхий бие засах газар байх ёстой/ бага байна. Бие засах байрны ариутгал халдваргүйжүүлэлт хангалтгүй. Бие засах газраас гарч буй үнэр орчинд тархсан. Нийтийн бие засах газар болон хогийн цэгийн дэргэд гахайны байр байрлаж байгаа нь хог хаягдал орчинд тархах нөхцлийг бий болгож байна.

### В.Уулзалтын байр

Тус ангид цэргийн албан хаагчийн ар гэрээс эргэлт, уулзалт ирэх тохиолдолд оруулах тусгай тохижуулсан байр байхгүй. Сургалт хүмүүжлийн танхимыг уулзалтын байрны зориулалтаар ашиглаж байгаа нь хүний тохь тухтай орчинг бүрдүүлж чадахгүй байна.

### Г.Сахилгын хорих байр

Тус анги нь 8 камер бүхий сахилгын хорих байртай. Сахилгын хорих байрны өрөөнүүдийн талбайн хэмжээг үзүүлбэл:

№	Камерын дугаар	Талбайн хэмжээ
1	1-р камер	1.5x2
2	2-р камер	1.5x2
3	3-р камер	2x2
4	4-р камер	2x2
5	5-р камер	2x3
6	6-р камер	2x3
7	7-р камер	6x2
8	8-р камер	4x6

Сахилгын хорих байрны камер бүрт 25x40 см хэмжээтэй цонхоор механик агааржуулалт хийдэг. Камерт зохиомол гэрэлтүүлэг байхгүй. Сахилгын хорих байрны камеруудын цонх болон 25x25 см хэмжээтэй хянах цонхоор байгалийн гэрэл тусдаг. Сахилгын хорих байранд газраас 40 см өндөртэй, модон наар байрлуулсан. Сахилгын хорих байр бүрт саатуулагч нарыг салхинд гаргахад зориулсан 2 м-ээс доошгүй өндөр, битүү хашаа байна гэсэн дүрмийн заалт хэрэгждэггүй. Саатуулагдсан этгээдийг салхилуулах боломж нөхцөл муу. Сахилгын хорих байранд 2 суудал бүхий бие засах газартай. Тус байранд стандартад заасан дараах өрөөнүүд байхгүй.

- Саатуулагдагчийн байцаах тусгай өрөө
- Харуулын байр
- Хооллох өрөө

- Саатуулагч нарын хувийн зүйл хадгалах тавиур бүхий өрөө
- Гар нүүр угаах өрөө

Тус ангид 2006 онд нийт 7 хүн сахилгын хорих байранд саатуулагджээ. Тус байр стандартын шаардлага хангахгүй байгаа байдлыг саатуулагчийн эрхийг зөрчих нөхцөл байдал үүссэн байна гэж дүгнэж байна.

#### Д.Дүрвэгсдийг саатуулах байр

0108-р ангид 2006 оны 1-р сард НҮБ-ын Дүрвэгсдийн Дээд Комиссарын Монгол дахь төлөөлөгчийн газрын санхүүжилтээр дүрвэгсдийн байрыг барьж ашиглалтанд оруулсан байна. Тус байр нь хүний амьдрах орчин нөхцлийг бүрэн хангасан байгаа нь сайшаалтай байна. Шалгалт хийх үед тус байранд БНАСУ-ын харъяат гэх 21 эмэгтэй, 3 эрэгтэй саатуулагдаж байлаа. Саатуулах байр 20 ортой байгаа нь саатуулагдсан хүний тооноос бага байна. Сахилгын хорих байр дараах зориулалт бүхий өрөөнүүдтэй.

- Эрэгтэй, эмэгтэй унтлагын байр /Эрэгтэй байр 5x10, эмэгтэй байр ..../
- Хоол бэлтгэх өрөө
- Хооллох заал
- Байцаалт авах өрөө
- Хувцас угаах өрөө
- Ариун цэврийн өрөө
- Харгалзагчийн өрөө

Саатуулагчдын үйлдэлд байнгын хяналт тавих боломжгүй, саатуулагчийн биедээ авч байж болох эд зүйлсийг нэрлэн тогтоогоогүй нь аюулгүй нөхцөл байдлыг хангаж чадахгүй байна. Түүнчлэн ангийн удирдлагаас шинээр баригдсан дүрвэгсдийг саатуулах байранд зөвхөн БНАСУ-ын харъяат гэх хүмүүсийг, дээр дурдсан сахилгын хорих байранд БНХАУ-ын харъяат гэх хүмүүсийг тус тус байлгах зориулалттай гэж тайлбарлаж байгаа нь хүнийг үндэс угсаагаар нь алагчилж байгаа хэлбэр мөн гэж үзэх үндэслэлтэй.

**1.3** Эрдэнэ сумын нутагт орших Хилийн цэргийн 0129-р ангийн хугацаат цэргийн албан хаагчдын орон байрны нөхцөл байдалд шалгалт хийлээ. Шалгалт хийхдээ Хил хамгаалах ерөнхий газрын даргын 2002 оны А/16 тоот тушаалаар батлагдсан "Хилийн тусгай анги, салбарын цэргийн албаны зохион байгуулалтын заавар"-ыг

удирдлага болголоо. Шалгалтанд тус ангийн бэлтгэл заставын цэргийн унтлагын байр, угаалгын өрөө, ахуйн үйлчилгээний зориулалт бүхий өрөө, усанд орох өрөө, угаалгын газар, гадна бие засах газар зэрэг объектууд үзлэгт хамрагдлаа.

Орон байрны нөхцөлд хийсэн шалгалтын дүнд дараах зүйлс тогтоогдож байна.

А.Унтлагын байр:

- Бэлтгэл заставын цэргийн албан хаагчийн унтлагын байр 2005 онд ашиглалтанд орсон, 25x18 м<sup>2</sup> талбайтай. Тус байранд байрлах нийт цэргийн албан хаагчийн тоо 116. /Хугацаат цэргийн албан хаагч 100, офицер, ахлагч 16 хүн байрлаж байлаа./ Орны тоо 116. 1 хүнд ноогдох талбайн хэмжээ 3.8 м<sup>2</sup> орчим байгаа нь зааварт заасан талбайн хэмжээг хангаж байна. Унтлагын байр орчин үеийн стандартын 1.8x1.4 м<sup>2</sup> хэмжээтэй 8 цонхтой, цонх тус бүр 25x50 см хэмжээтэй салхивчтай. Байгалийн гэрэлтүүлэг хангалттай. 60-80 ваттын 9 чийдэнгээр зохиомол гэрэлтүүлэг хийдэг. Шалгалт хийх үед тасалгааны хэм 19<sup>0</sup> байгаа нь зааварт заасан хэмжээг хангаж байна. Ор, дэрний цагаан хэрэглэлийн хангалтын хэвийн, чанар сайн. Орны бүтээлэг, хөнжил, гудас зэрэг удаан жил эдлэгдэх хэрэглэгдэхүүний ашиглалтанд орсон хугацааг заагаагүй.

Б.Ариун цэвэр, ахуйн үйлчилгээний зориулалт бүхий өрөө

- Ахуйн үйлчилгээний зориулалт бүхий өрөөг зааврын дагуу бэлтгэж тохижуулсан байна. Өрөөнүүдийг байнга ашиглах боломжтой. Тус анги нь үсчин, оёдолчин, угаагч, индүүлэгч, халуун ус хариуцсан ажилтан зэргийг цалинжуулан ажилуулж, мэргэшүүлэн сургахад анхаарч ажиллаж байгаа нь цэргийн албан хаагч ая тухтай байх орчин нөхцлийг бүрдүүлэхэд сайнаар нөлөөлж байна.
- Тус ангийн гар нүүр угаах цэг 16 угаалтуур, 2 хөл угаах онгоцтой. Нүүр угаах газрын усыг цагийн хувиарын дагуу тавьж олгодог. /Өдөрт 4 удаа 20-30 мин орчим хугацаанд ус шахдаг./ Гар угаах өрөөнүүдийн агааржуулалт хэвийн. Цэвэрлэгээг цэргүүд ээлжээр хийдэг. Өрөөг стандартын дагуу засч тохижуулсан байлаа.

- Ангийн хэмжээнд ХЦАХ-д зориулсан 12 душтэй усанд орох өрөөтэй. Түүнчлэн офицер, ахлагчдад зориулсан 5 душ бүхий тасалгаатай усанд орох өрөөтэй. 7 хоногийн амралтын өдрүүдэд ангийн бие бүрэлдэхүүнд усанд орох боломжтой. Ариутгал цэвэрлэгээг усанд орсны дараа тухай бүр хийдэг. Усанд орох өрөө стандартад заасан шаардлагад нийцэж байсан.
- Тус анги гадна байрлалтай нэгдсэн бие засах газартай. Нийт 17 тавцантай. Бие засах байрны ариутгал халдваргүйжүүлэлт хэвийн.

#### В.Уулзалтын байр

Тус ангид цэргийн албан хаагчийн ар гэрээс эргэлт, уулзалтын тусгай тохижуулсан байр одоогоор байхгүй. Эргэлт уулзалтын өрөө болон сахилгын хорих байрыг шинээр барьж байгаа бөгөөд хараахан ашиглалтанд ороогүй. Эргэлт ирэх тохиолдолд ангийн буудалд байрлуулах боломжтой. 0129-р ангийн буудал 2006 онд ашиглалтанд орсон. Хоолны заал, хоол бэлтгэх өрөө, ариун цэврийн өрөө болон 6 ор бүхий 3 унтлагын өрөөтэй.

#### Г.Сахилгын хорих байр

Тус ангид сахилгын хорих байр одоогоор байхгүй. 2007 оны 1-р улиралд ашиглалтанд орох шинэ байранд сахилгын хорих өрөөнүүдийг барьж байсан. Баригдаж буй өрөөнүүд нь тус бүр 1х1.40 м хэмжээтэй, 5 тасалгаатай. Өрөөний хаалгыг төмөр сараалжаар хийхээр төлөвлөж бөгөөд байгалийн гэрэлтүүлэг орох болон агааржуулалт хийхэд зориулсан ойролцоогоор 25х40 см хэмжээтэй гадна цонхтой. Зохиомол гэрэлтүүлгийг камерын гадна талд байрлуулсан. Сахилгын хорих байрыг стандартад нийцүүлэн тоноглох тал дээр цаашид туслалцаа үзүүлэх, хамтран ажиллах хүсэлтийг ангийн удирдлагын зүгээр тавж байлаа.

#### **Хоёр.Гал тогоо, хоолны хангамжийн талаар**

Сулинхээрийн 0168-р ангид халуун хоол боловсруулах өрөө нь тусдаа боловч тоног төхөөрөмжийнх нь ашиглагдах хугацаа нь дууссан, гурил бэлтгэх, ногоо бэлтгэх, хүнс, хуурай хэрэглэл хадгалах өрөөтэйгээ хамт, мах бэлтгэх өрөө нэг

байсан. Талх барих, талх хадгалах, тавьж олгох өрөө нь хамдаа байсан. Ахлах тогоочийн буюу гал тогоонд ажиллагчдын бэлтгэл, сургалтын өрөө, гал тогооны жижүүр, ээлжийн тогооч, бэлтгэгч нарын өрөө, хувцас хэрэглэл хадгалах өрөө нь нэг дор байв. Сав хэрэглэл угаах, хатаах, хадгалах өрөө байхгүй хоолны залны буланд байрлуулсан байв. Хоолны заал нь 220 м кв талбайтай, 120 хүн хооллох багтаамжтай ширээ сандлын хүрэлцээ хангалтай байсан. Хооллох заал нь нэмэлт салхивч байхгүй, хоолны ширээ засахад ширээн дээр тавигдах зүйлүүд /хувин, хувингийн халбага, үлдэгдэл хийх сав гэх мэт/ тавигдаагүй байсан. Хоолны ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл хангалтгүй, боловсруулсан бүтээгдэхүүн /хоол, хүнс/ сөрөг урсгал үүсгэхээр байлаа.

Замын-Үүдийн 0108-р ангид мах бэлтгэх, ногоо бэлтгэх өрөөтэйгээ хамт байсан. Талх барих, талх хадгалах, тавьж олгох өрөө нь хамтдаа байсан. Ахлах тогоочийн буюу гал тогоонд ажиллагчдын бэлтгэл, сургалтын өрөө, гал тогооны жижүүр, ээлжийн тогооч, бэлтгэгч нарын өрөө, хувцас хэрэглэл хадгалах өрөө нь нэг дор байв. Бусад стандартад заасан өрөөнүүд тус тус даа байсан болно. Хоолны заал нь 120 м кв талбайтай, 60 хүн хооллох багтаамжтай ширээ сандлын хүрэлцээ хангалтай байсан. Хооллох заал нь гэрэлтүүлэг сайтай боловч нэмэлт салхивч байхгүй, хоолны ширээ засахад ширээн дээр тавигдах зүйлүүд /хувин, хувингийн халбага, үлдэгдэл хийх сав гэх мэт / тавигдаагүй, хоолны ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл хангалттай, боловсруулсан бүтээгдэхүүн /хоол, хүнс/ сөрөг урсгал үүсгэхээргүй байв.

### **Гурав. Соёл хүмүүжлийн ажлын талаар**

#### **3.1 Биеийн тамирын заал, талбай, танхимын албаны зохион байгуулалт**

Хилийн цэргийн ангийн төвд биеийн тамир, спорт сургалт явуулах шаардлага хангасан спортын заал, биеийн тамирын талбай, гимнастикийн хотхон, ерөнхий цэргийн болон олон төрөл мэргэжлийн саадын зурвас, гранатын болон спортын тоглоомын талбай, эрүүл мэнд чийрэгжүүлэлтийн танхим, цэргийн байранд биеийн тамирын танхим буюу булантай байна гэсэн шаардлагын дагуу ажиллаж байгаа отряд алга байна.

- Сулинхээрийн 0168-р ангид спортын заал байх боловч энэ зориулалтынхаа дагуу ашиглагддаггүй, гадна талын эгэрлтүүлэг болон агааржуулалтын байдал хангалтгүй байна. Үүнээс гадна тус анги дээр чийрэгжүүлэлтийн танхим огт байхгүй байна..
- Замын-Үүдийн 0108-р ангид спортын заал огт байхгүй сумын хэмжээнд ганцхан спорт заал байдаг байна.
- Улаан-уулын 0129-р ангид спортын зориулалтын заалыг шинээр барьж ашиглалтанд оруулсан байна.

### *1.2 Соёлын төв, соёл амралтын танхимын албаны зохион байгуулалт*

Амралт,соёлжилтын танхим нь бие бүрэлдхүүн чөлөөт цагаа зөв зохистой өнгөрүүлэх,алжаал тайлах, тэдний оюуны болон соёлын өдөр тутмын хэрэгцээг хангах тохитой орчинг бүрдүүлсэн,хамтач нөхөрсөг харилцааг бэхжүүлэх төв байх ёстой.

- Сулинхээрийн 0168-р ангид сургалтын төв байх боловч гэрэлтүүлэг,агааржуулалт туйлын хангалтгүй,тохигүй орчинтой, огт хэрэглэгддэггүй танхим байсан.Шалны будаг их хэмжээгээр ховхорсон засвар үйлчилгээ огт хийгдээгүй,нэг жижиг ширээтэй, суух сандалгүй огт байхгүй.Сургалтын төвийн техник хэрэгслэл ерөнхийдөө гайгүй боловч нэг зурагтыг 40 цэргийн албан хаагч үзэж хэрэглэдэг байна.
- Замын-үүдийн 0108-р ангийн сургалтын төвийн гэрэлтүүлэг муутай,агааржуулалт муутай байна.
- Улаан-уулын 0129-р ангийн сургалтын төв нь шинээр баригдсан байр учраас хангалттай байна.

### *Дөрөв.Эмнэлгийн үйлчилгээний талаар*

Шинээр ирсэн хугацаат цэргийн албан хаагч нарыг тогтмол эмнэлэгийн үзлэг хамруулж байгаа боловч өвдсөн тохиолдолд эмнэлэгийн анхан шатны тусламж дэмжлэг үзүүлэх, эм тарианы хангалт хадгалалтын талаар хангалтгүй байна.



- Сулинхээрийн0168-р ангийн эмнэлэг нь дээд мэргжлийн 3 эмчтэй, сувиллагч асрагч нарын бүрэлдхүүнитэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Цэргийн алба хаахаар ирсэн цэргүүдийн эрүүл мэндийн үзлэгт оруулсан эмнэлэгийн хуудас хангалтгүй бүртгэгдсэн байсаэн төдийгүй хэрэглэдэг эм тарианы хангалтанд үзлэг хийхээр олон тооны эм, эмийн бүтээгдхүүнүүд 2-3 жилийн өмнө хугацаа нь дууссаныг хэрэглэдэг эм тариатайгаа хамт хадгалан хэрэглэж байгаа дутагдал илэрсэн. Үүнд:-

Хугацаа дууссан тариа:

1. Эуфилин 10 ширхэг хугацаа 2006.09-н сард дууссан
2. Эуфилин 1 ширхэг хугацаа 2005.12-р сард дууссан
3. Сибазол 9 ширхэг хугацаа 2004.01-р сард дууссан
4. Контрикал 5 ширхэг хугацаа 2005.10-р сард дууссан
5. Кординамин 10 ширхэг хугацаа 2004.11-р сард дууссан
6. Репологлекин 2 ширхэг хугацаа 2004. 12-р сард дууссан
7. Панангин 2 ширхэг хугацаа 2005. 05-р сард дууссан, 1 ширхэг хугацаа 2002. 11-р сард дууссан, 1 ширхэг 2000.08-р сард дууссан
8. Aminocaproic acid injection 2 ширхэг хугацаа 2004.04 –р сард дууссан
9. Строфантин-К 3 ширхэг хугацаа 2002.04-р сард дууссан
10. Прогестерон 30 ширхэг хугацаа 2006.09-р сард дууссан
11. Аминазин 4 ширхэг хугацаа 2003.04-р сард дууссан
12. Раствор Лидокаина 16 ширхэг хугацаа 2003.02-р сард дууссан
13. Diageram 9 ширхэг хугацаа 2005. 11-р сард дууссан
14. Раствор Магнита 400 мл 1 ширхэг хугацаа 2006. 02-р сард дууссан
15. Кислота Аскорбиновая 2 ширхэг хугацаа 2005. 08-р сард дууссан
16. Раствор Окситоцина 2 ширхэг хугацаа 2005. 10-р сард дууссан
17. Cefuroxime 2 ширхэг хугацаа 2002.01-р сард дууссан
18. Ceftazidime 1гр. 2 ширхэг хугацаа 2002.01-р сард дууссан
19. Benzathine Penicillin 2 ширхэг хугацаа 2003.06-р сард дууссан
20. Цифозалин 1 ампул хугацаа 2006.06-р сард дууссан
21. Преднизлон 2 ширхэг хугацаа 2005.10-р сард дууссан, 2 ширхэг хугацаа 2005.10-р сард дууссан
22. Йодын уусмал 11 ширхэг хугацаа 1983.05-р сард дууссан

23. Охујосin injection 2 ширхэг хугацаа 2003.09-р сард дууссан
24. Никотины хүчил 3 ширхэг хугацаа 2005.05-р сард дууссан
25. Кофеин-бензоат 1 ширхэг хугацаа 2004.05-р сард дууссан
26. Преднизлон Никомед 2 ширхэг хугацаа 2006.07-р сард дууссан
27. Морфин 1мл, 5 ширхэг хугацаа 2003.11-р сард дууссан

Эм:

1. Imdomethosin 210 ширхэг хугацаа 2005 онд дууссан
2. Эритромицин 300 ширхэг хугацаа 2006.04-р сард дууссан
3. Контроприл 30 ширхэг хугацаа 2005 онд дууссан
4. Мезим форте 20 ширхэг хугацаа 2004.06-р сард дууссан
5. Деклофенон 60 ширхэг хугацаа 2006.02-р сард дууссан
6. Ампиполон 100 ширхэг хугацаа 2006.05-р сард дууссан
7. Деокарб 7 ширхэг хугацаа 2005.04-р сард дууссан
8. Сольбутамол 10 ширхэг хугацаа 2006.03-р сард дууссан
9. Ciprofloxacin 10 ширхэг хугацаа 2006.03-р сард дууссан

Бусад:

Дуслын систем 51 ширхэг

Мэс заслын утас 17 ширхэг тус тус байсныг устгалд оруулав.

Бусад 2 ангийн хувьд эмнэлэгийн үйлчилгээ үзүүлж байгаа байдал, эм тарианы хангалт, хугацааны хувьд гарч, илэрсэн дутагдал байхгүй хэвийн үйл ажиллагаа явуулж байна.

### **Санал дүгнэлт**

1. Сулинхээрийн отрядын одоо үйл ажиллагаа явуулж ашиглаж байгаа байрны хувьд хуучирч муудсан ажиллах нөхцөл хүнд байгааг зайлшгүй анхааралдаа авах шаардлагатай байна. Тэнд ажиллаж амьдарч байгаа цэргийн албан хаагч офицер ахлагч нарын хүүхдүүдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилт маш хүндрэлтэй. Ихэнх албан хаагч нарын хүүхдүүд УБ хотод төрөл садан, найз нөхдийнх нь гэрт амьдарч ойролцоох суругуульд нь хамрагддаг. Нөгөөтэйгүүр хил дээр алба хааж байгаа албан хаагч нар нь томилолтын журмаар ажилладаг байна оршин суудаг

UIH.MN  
ЦСДАН ААНХЛАН

газар байхгүй учраас хаягийн бүртгэл маш их өөрчлөгддөгтэй холбоотойгоор хүүхдүүдээ УБ хотод хүссэн сургуульд нь оруулж суралцуулж чаддаггүй байна.

2. Цэргийн албан хаагч нарын хувьд өмчлөх эрхийн асуудлыг анхааралдаа цаг болсон байна.Тэд өөрийн хүссэн хот суурин газартаа суурьшсан үедээ өмчилж авах газрын асуудал маш хүндрэлтэй байдаг байна. Иймд тухайн байгууллагын удирдлагуудын зүгээс эдгээр хүмүүсийг тэтгэвэртээ гарах үед нь амьдрах нөхцөл бололцоог хангах үүднээс газар эзэмших эрхийн асуудал дээр анхаарал хандуулах шаардлагатай байна.

3.Офицер,ахлагч нарын хөдөлмөрлөх нөхцөл, ажлын цаг тогтоосон байдал дээр анхаарах хэрэгтэй байна.

Замын-Үүдийн 0108-р ангийн хилийн шалган нэвтрүүлэх боомтын офицер ахлагч нар нь Монгол улсын хөдөлмөрийн хуулийн заалтуудыг зөрчиж бүтэн 7 хоног ямар нэгэн амралтгүй болон ээлжгүйгээр өглөө 8-22 цаг хүртэл ажиллаж байна. Тэгэхдээ ажлын 22 өдрөөр тооцож цалингаа бодуулж авдаг бөгөөд илүү цаг ажилласан, амралт баяр ёслолын үеэр ажилласан нэмэгдлүүд огт олгогддоггүй байна. Энэ талаар ангийн удирдлагууд тайлбарлахдаа “Монгол-Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай Монгол улсын Засгийн газар,БНХАУ-ын засгийн газар хоорондын хэлэлцээр”ийн 9-р зүйлд заасны дагуу ...боомт нь олон улсын шинжтэй, байнгын ажиллагаатай,Бямба Ням гаригуудад хэвийн ажиллана.... гэсэн заалтын дагуу ажилладаг хэмээн тайлбарлаж байлаа.

Иймд шалган нэвтрүүлэх боомт дээр ажилладаг албан хаагч нарын тоог нэмэгдүүлэх болон ээлжээр ажилладаг болгон ажилтан албан хаагчдын ажил амралтын цагийг зөв зохицуулах талаар шийдвэр гаргах.

4.Монгол улсын Төрийн албаны тухай хуулийн 16.2.3-т заасан ...албан үүргийн хувьд нэг нь нөгөөдөө захирагдах буюу шууд хяналт тавих албан тушаалтантай гэр бүл, төрөл садангийн хүн нь тухайн ажлын албаны нэгжид хамт ажиллахаар бол ... гэсэн заалтыг зөрчин эхнэр, нөхөр, эгч дүүс нэг анги байгууллага дээр удирдах удирдуулах албан тушаалыг зэрэг хашин ажиллаж байна.Энэ талаар цаашид судалгаа хийж холбогдох байгууллахгуудаар шийдвэрлүүлэх.

5.Анги салбарууд дээр хэдийгээр сургалт хариуцсан албан тушаалтныг 7 сараас эхлэн томилсон хэдий боловч цэргийн албан хаагч нар болон хугацаат цэргийн албан хаагч нарт зориулсан сургалтын тусгай хөтөлбөр байхгүй, сургалтын ажил нь ерөнхийдөө урсгалаараа явагддаг байдал Замын-Үүдийн 0108-р ангиас бусад ангиуд дээр ажиглагдсан.Иймд сургалтын хөтөлбөрийг зорилтот бүлгүүдэд ангилалтайгаар боловсруулан гаргаж хэвшүүлж ажиллах шаардлагатай байна.

## ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 013-Р АНГИД ШАЛГАЛТ ХИЙСЭН ТУХАЙ

### ИЛТГЭХ ХУУДАС

2006.11.20

ХЭҮК-ын гишүүн Г.Далайжамц, референт Г.Нарантуяа, Ж.Цолмон нарын бүрэлдэхүүнтэй баг 2006 оны 12-р сарын 13-ны өдөр Улаанбаатар цэргийн хүрээний 013-р ангид шалгалт хийлээ.

Шалгалтын хүрээнд удирдамжид заасны дагуу объектуудад үзлэг хийх, цэргийн албан хаагчид, энгийн ажилчдаас санал асуулга авах, офицер, ахлагчид, цэргийн албан хаагчидтай ярилцах болон ангийн захирагчийн тушаал, тус ангид мөрдөгдөж буй дүрэм, журамтай танилцах ажлыг зохион байгууллаа. Шалгалтын дүнд дараах нөхцөл байдал тогтоогдож байна. Үүнд:

#### **Нэг. 013-р ангийн талаарх товч мэдээлэл**

Улаанбаатар цэргийн хүрээний 013-р анги нь Зэвсэгт хүчний Жанжин Штабын хээрийн ангиудын холбооны удирдлагын үүрэг гүйцэтгэдэг. 1929 онд байгуулагдсан, 1939 болон 1945 оны чөлөөлөх дайнуудад оролцож байсан түүхтэй. Ангийн захирагч, хурандаа Л.Чимэддорж. Ангийн нийт бие бүрэлдэхүүний тоо 400 орчим. Үүнээс хугацаат болон гэрээт цэргийн албан хаагч 57.5% орчим, цэргийн албан тушаалтан 25% орчим, энгийн ажилчид 17.5% орчим хувийг тус тус эзэлдэг. Тус анги нь сүүлийн таван жилд 2004 оны Командлалын шалгалтаар Армийн тэргүүний анги, 2006 оны ЗХЖШ-аас зарласан сахилгын зөрчилгүй хамт олон болох тухай уралдаан 2-р байранд орсон амжилтыг үзүүлжээ.

Ангийн барилга байгууламж 1983 онд ашиглалтанд оржээ.

#### **Хоёр. Цэргийн албан хаагчдын ахуй нөхцөл**

Тус анги нь цэргийн албан хаагчийн унтлагын 4 байртай. Унтлагын байрны нэг цэрэгт ноогдох талбайн хэмжээ, орны тоо, гэрэлтүүлэг, агааржуулалт, дулаан стандартын шаардлага хангаж байна. Цэргүүд ор, дэрний цагаан хэрэглэл, ариун цэврийн хэрэгслээр бүрэн хангагдсан. Санал асуулгад оролцсон цэргийн 77.3% нь ариун цэврийн хэрэгсэл хангалтай гэж хариулжээ. Ор дэрний цагаан хэрэглэлийг 9-р сард тавьж олгосон гэх боловч хуучирсан, материал үрэлтэж, бөөгнөрсөн байсан. Удаан эдлэгдэх ор дэрний хэрэглэлийн ашиглалтанд орсон хугацааг заагаагүй байлаа.

Ахуйн үйлчилгээний зориулалт бүхий өрөөг унтлагын байрны давхар бүрд зааврын дагуу бэлтгэж тохижуулсан бөгөөд байнгын ашиглалтад байдаг.

Тус ангийн цэргийн байрнуудын давхар бүрт байрлах гар нүүр угаах, бие засах газрыг төхөөрөмжилсөн байдал стандартад нийцэж байгаа боловч цэвэрлэгээ, ариутгал хангалтгүй байна. 8 душ бүхий усанд орох газарт долоо хоног бүрийн хагас сайн өдөр цэргийн албан хаагчид халуун усанд ордог. Санал асуулгад оролцогч цэргүүд 100% долоо хоногт 1 удаа буюу сард 4-5 удаа усанд ордог гэж хариулсан байна. Усанд орох газрын ариутгал цэвэрлэгээ тогтмол хийгдэж байна.

Ангийн харуулын байрны хойд жигүүрт эргэлт, уулзалтын өрөөг гаргасан боловч тохижилт муу, эргэлт уулзалтын үед ярианы нууцлал хадгалагдах ямар ч боломжгүй байгаа нь анхаарал татаж байна. Цэргүүдтэй хийсэн ярилцлагаас

эргэлт уулзалтын байрны нөхцөл байдал нь тус ангид гардаг дүрмийн бус харьцааг нууц, далд байлгах нэг хүчин зүйл болж байгаа нь харагдаж байлаа.

А: Ар гэрийнхэн чинь энэ талаар мэддэг үү?

Х: Яаж мэдэхэв дээ. Уулзалтын байранд 2 хал байнга сахиж байгаа болохоор юу ч дуугарч чадахгүй.

*Ярилцлагын тэмдэглэлээс...*

Ангид сахилгын хорих байр байхгүй. ЦАХ-д сахилгын арга хэмжээ авах тохиолдолд Улаанбаатар цэргийн хүрээний хэв журам сахиулах ангид хүргүүлдэг. 2006 онд тус ангиас 8 цэрэг сахилгын хорих байранд хоригдох шийтгэл авсан тухай ангийн захирагчийн тушаал гарсан байна.

Тус ангийн гал тогоо байрлах барилга хуучирсан, хананы будаг, таазны шохой нь ховхорсон, ууранд тааз нь чийгшиж мөөгөнцөртсөн байлаа. Халуун ус байхгүйн улмаас усаа халааж ариутгал, цэвэрлэгээ хийдэг бөгөөд ариутгал цэвэрлэгээний бодисын хангалт муу байгаа нь ажиглагдаж байсан. Өрөө, тасалгааны хувьд стандартад заасан цэргийн гал тогоонд байвал зохих өрөөнүүд бүгд байна. Цахилгаан хэрэгсэл галын аюулгүй байдлыг хангажээ.

Цэргийн албан хаагчийн хооллох заал ойролцоогоор 720м<sup>2</sup> талбайтай. Сандал ширээ хүрэлцээтэй. 7 хоногт 12 нэр төрлийн хоолоор цэргүүдэд үйлчилдэг бөгөөд хоолны илчлэгийг ангийн ахлах тогооч, ар тал хариуцсан орлогч, эмч, хүнсний албаны дарга нар 7 хоног бүр тогтоодог. Хоолны норм, илчлэгт ангийн эмч өдөр тутам хяналт тавьдаг. Шалгалт хийх өдрийн хоолны амт, чанар хэвийн байв. Санал асуулгад нийт цэргийн албан хаагчдын 74.4% нь өлсдөггүй, 62.7% нь хоолны чанар сайн гэж хариулжээ.

Ангид зориулалтын биеийн тамирын заал байгаа боловч талбайн хэмжээ стандартад зааснаас бага, хана, шалны будаг, плита нь хуурсан, заалны гадаад үзэмж, тохижилт муу байна. Хувцас тайлах, спортын хэрэглэл хадгалах өрөө, шүршүүрийн өрөө болон агааржуулагч хоолой байхгүй. Зохиомол гэрэлтүүлэг, цэвэрлэгээ, ариун цэврийн байдал хангалтгүй байлаа. Шалгалт хийх үед уг зааланд хүмүүс гадуур хувцастайгаа тоглож байсан.

Биеийн тамирын талбайг задгай газар байгуулж, стандартын дагуу төхөөрөмжилсөн боловч ихээхэн хуучирч муудсан, зарим тоноглол эвдэрсэн, арчилгаа шаардлагатай байгаа нь ажиглагдсан. Биеийн тамирын талбайд гимнастикийн хотхон байгуулсан бөгөөд зарим тоног төхөөрөмж дутуу, шинэчлэн засварлах шаардлагатай нь харагдаж байлаа.

Ангид тусгайлан зассан чийрэгжүүлэлтийн өрөө байгаа боловч өрөөний талбай бага, анги өөрсдийн хүчээр бялдаржуулах хэрэгслийг хий, өрөөг тоноглогсон нь аюулгүй ажиллагааны шаардлага хангаагүй байна. Чийрэгжүүлэлтийн өрөөний тоног төхөөрөмж аюулгүй ажиллагааны горимд нийцээгүй учир тогтмол ашигладаггүй тухай хариуцсан албан тушаалтан ярьж байлаа. Цэргийн албан хаагчдын 79.0% нь бие бялдраа хөгжүүлэх боломжтой гэж санал асуулгад хариулжээ. Түүнчлэн тус ангид давсан зам, шарлагын төхөөрөмж, массажны ор бүхий физик эмчилгээний тусгай өрөө байдаг бөгөөд өрөөний тохижилт харьцангуй сайн байна.

Амралт-соёлжилтын танхим цэргийн албан хаагчдын байрладаг давхар бүрт байдаг бөгөөд тохижилт сайн, зай талбайн хэмжээ стандартын шаардлагыг хангаж байна.

Цэргийн албан хаагчийн мэдээлэл, соёл хүмүүжлийн ажлын төлөвлөгөөг жил, улирал, сар, долоо хоногээр гаргаж, хэрэгжүүлдэг. 7000 гаруй нэр төрлийн номтой номын сантай, уг номын санд 11 төрлийн сонин захиалдаг байна. Сүүлийн үеийн шинэ ном, товхимлын хангалт муу байгаа ажиглагдсан. 6 компьютер интернэтэд холбогдсон 8 компьютер бүхий компьютерийн танхимтай боловч түүгээр цэргүүд тэр бүр үйлчлүүлэх боломжгүй, зарим албан тушаалтанд хүртэл хүртэж чаддаггүй тухай хариуцсан албан тушаалтан ярьж байлаа.

Чөлөөт цагаа хэрхэн өнгөрүүлдэг тухай санал асуулгад хариулсан байдлаар харахад телевизор үздэг гэж 80 цэрэг, спортоор хичээллэдэг гэж 45 цэрэг, ном, сонин уншдаг гэж 25 цэрэг (гэхдээ ном сонин хомс байдаг гэж 1 цэрэг хариулсан), шатар, даам тоглодог гэж 15 цэрэг, компьютер тоглодог гэж 13 цэрэг, хөгжим, радио сонсдог гэж 10 цэрэг, хувийн бэлтгэлээ базаадаг гэж 9 цэрэг тус тус хариулсан байна. Харин энэ асуултанд тэр өдрийн түрүүч нарын ааш мэднэ, зодуулж, дэглүүлдэг, гунигтай өнгөрөөдөг гэдэг хариултыг өгсөн нь анхаарал татаж байна.

Чөлөөт цагийн ямар арга хэмжээ зохиох шаардлагатай байгаа тухай асуултанд гадаад хэлний сургалтанд хамрагдах сонирхолтой гэж 7 цэрэг, спортын тэмцээн, АСТ уралдаан зохиомоор байна гэж 5 цэрэг, сэтгэлзүй, ёс суртахуун, харилцааны лекц сонсох гэж 2 цэрэг, компьютерийн сургалтанд хамрагдах гэж 2 цэрэг хариулсан байгаа цэргүүд өөрсдийгөө хөгжүүлэх эрмэлзлэлтэй байгааг харуулж байна.

Тус анги нь 2 эмч, 4 сувилагч, 1 үйлчлэгчийн орон тоотой, амбультор, стационар, эмийн сан бүхий эмнэлэгтэй. Эмнэлэгийн ариутгал, цэвэрлэгээ орчин нөхцөл хэвийн, үйлчлүүлэгсдийн бүртгэлийг бүрэн хөтөлдөг. Харин тус ангид цэргийн албан хаагчидтай дүрмийн бусаар харьцах, үүний улмаас ил, далд бэртэл гэмтэл авах тохиолдол түгээмэл гарч байхад ангийн эмнэлэг тэр бүр мэдээгүй байгаа урьдчилан сэргийлэх үзлэг хангалтгүй байгааг харуулж байна.

2006 онд тус эмнэлэгт 56 цэргийн албан хаагч хэвтэж эмчлүүлжээ.

... 2006 онд Цэрэндолгорын Цэндзүсэм /ДЭ-87021011/ гэдэг цэрэг “тархины цус хуралт” оноштойгоор хэвтэж эмчлүүлжээ. 1-р ээлжийн цэрэгт зодуулснаас ийм гэмтэл авсан бөгөөд гэмтэл авснаас хойш 1 сарын дараа бие нь муудсанаар эмнэлэгийн тусламж авахад хүрсэн. 2 сар онош нь тодрохгүй явж, 4 удаа эмнэлэгт хэвтсэний дараа зодуулсан гэдгээ хэлсэн. Энэ болтол хэн ч мэдээгүй байсан.

... Жамбуугийн Галхүү /СО-85122014/ гэдэг цэрэг зуны кино зураг авалтаар Өвөрхангай аймгийн 0256-р ангийн офицер Цогтсайхан санамсаргүй ташуурдсанааснүдний торлог бүрхэгч гэмтэж, сул хараатай болсон.

*/Эмнэлэгийн бүртгэл болон эмчийн ярианаас.../*

Бүртгэлээс харахад тус ангид гонеррай, олгой, хатиг, арьсны өвчин их гардаг бөгөөд ялангуяа арьсны өвчин гарч буй шалтгааныг ангийн эмч нар судлаж, арга хэмжээ аваагүй байгаа нь тэмдэглүүштэй байна. Шалгалтын үед бсирёз өвчтэй нэг цэрэг хэвтэж эмчлүүлж байсан бөгөөд цэргийн албанд ийм өвчтэй хүнийг татсан нь хариуцлагагүй үйлдэл болжээ.

Ангийн эмийн хангалт хугацаат болон гэрээт цэргийн албан хаагчийнхаар төсөвлөгддөг. Дараах хугацаа нь хэтэрсэн эмийг хэрэглэж байсан. Үүнд:

- Викасол /Дуусах: 2006.11/
- Lemcapril25 түрхлэг /Дуусах: 2005.04/
- Преднизоланы мазь /Дуусах: 2005.12/
- Диарекс /Дуусах: 2006.12/

2006 онд Болд-Эрдэнэ гэдэг байлдагч зодуулж, гэмтсэн тухай цэргүүд ярьж байсан боловч эмнэлэгт энэ тухай бүртгэл мэдээлэл огт байхгүй байв. Мөн эмнэлэгт хэвтэж байсан Баяртөгсийг зодуулж гэмтэл аваад эмчлүүлж байгаа гэсэн мэдээллийг цэргүүд өгсөн боловч эмнэлэгийн эмч болон байлдагч Баяртөгс нар арьсны өвчний учир хэвтэж байгаа гэж тайлбарласан.



### Гурав. Цэргийн албан хаагчийн дүрмийн бус харьцаа

Тус ангид цэргийн албан хаагчидтэй дүрэмд зааснаас гадуур шийтгэл оногдуулах, залхаан цээрлүүлэх тохиолдол гарч байна. Цэргийн албан хаагчид энэ талаар ярих, мэдэгдэхээс эмээдэг боловч нэлээд газар авсан нь санал асуулгад хариулсан байдал, цэргүүдтэй хийсэн ярилцлагаас тодорхой харагдаж байна.

Санал асуулгад хариулсан байдлыг нэгтгэж үзвэл ялгавартай хандах, айлган сүрдүүлэх, мөнгө эд зүйл шаардах, зодох, хүч хэрэглэх, үг хэлээр доромжлох, дүрмийн бус шийтгэл хүлээлгэх, өөр бусдаар зодуулах зэрэг дүрмийн бус харьцааг офицер, ахлагч, түрүүч, байлдагчдын зүгээс гаргадаг тохиолдлыг дараах байдалтай байна гэж дүгнэсэн байна.

	Субъект	Маш их	Хааяа гардаг	Огт гардаггүй	Хариулаагүй
1.	Офицер	15	13	117	27
2.	Ахлагч	9	17	114	32
3.	Түрүүч	18	11	116	29
4.	Байлдагч	6	9	117	42

*Дүрмийн бус харьцааны байдлыг санал асуулгаар ийнхүү дүгнэжээ.*



Зөрчлийн байдлаар нэрлэвэл офицеруудын зүгээс айлган сүрдүүлэх, мөнгө, эд зүйл шаардах, ахлагч нарын зүгээс айлган сүрдүүлэх, дүрмийн бус шийтгэл хүлээлгэх, түрүүч нарын зүгээс мөнгө, эд зүйл шаардах, зодох, хүч хэрэглэх, бусад

байлдагч нарын зүгээс мөнгө, эд зүйл шаардах, зодох, хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх тохиолдол их байдаг гэж хариулсан байна. Байлдагч нарын зүгээс ямар дүрмийн бус харьцаа гаргадаг вэ гэсэн асуултанд хариулаагүй цэргийн тоо бусад үзүүлэлтүүдэд хариулагдаагүйгээс их байгаа нь дүрмийн бус харьцаа байгааг хүлээн зөвшөөрч байгаа боловч энэ тухай бичихээс эмээж байгааг илэрхийлж байна гэсэн таамаглал төрүүлж байна.

Санал асуулгын “Хүч хэрэглэсэн, дарамтласан, зүй бус харьцсан тохиолдол бий бол энэ тухай дэлгэрэнгүй бичнэ үү?” гэсэн асуултанд 15 цэрэг ахлах дэслэгч Баасанхүүгийн зүй бус үйлдлийн талаар мэдээлжээ. Ахлах дэслэгч Баасанхүүгийн талаар холбогдох газар нь уламжилж арга хэмжээ авахуулахыг ХЭҮК-оос хүссэн байна. Түүнчлэн ахлах ахлагч Отгонжаргал, ахлагч Зандансүрэн нарын талаар гомдол гаргасан байна.

Ахлах дэслэгч Баасанхүү дурдсан зөрчлийг цөмийг нь байнга гаргадаг. А/д Баасанхүү түрүүч, байлдагч нараас байнга мөнгө нэхдэг, эргэлтээр гараад ирэхээр кармаа нэгжээд мөнгө авчихдаг. А/д Баасанхүү 2006 оны 12-р сарын 10-нд шөнө 23.00 цагаас зогсоож, 3 цаг хүртэл зодсон. А/д Баасанхүү биднийг зодож архины мөнгө нэхдэг.

*/Санал асуулгын хуудаснаас.../*

Дээрх асуултанд бүх салбарын дэд түрүүч нар дандаа зоддог гэж 5 цэрэг, хал байлдагч нар байнга дарамтладаг, мөнгө нэхдэг, нэхсэн зүйлийг өгөхгүй бол зоддог гэж 6 цэрэг, 57-гоор цогонд цохиулдаг, тэр зүйлийг авч нуумаар байна гэж 3 цэрэг, өөрт нь таалагдахгүй бол ер нь хэцүү, зөрөх юм бол дүрэмддэг, зоддог, нэг хүний өмнөөс нийтээрээ шийтгэгддэг, өргөдөл өгсөн хүнийг мэдчихдэг, нууц хадгалагдахдаа муу болохоор хэцүү тэр тус бүр нэг цэрэг хариулсан байна. Харин “Ийм зүйл байхгүй, ер нь ганц нэг байхад зүгээр шүү дээ. Муу юм болохгүй биз дээ” гэж 1 цэрэг хариулжээ.

Тус ангийн цэргийн албан хаагчид дараах төрлийн дүрмийн бус шийтгэлийг хүлээлгэдэг байна.

- Элэгдэх
- Тогоор цохиулах
- Мөнгө эд зүйл шаардах
- Цээжин дээр АКА буу цэнэглэх
- Шумуулд хазуулах

Энэ талаар ярилцлагын тэмдэглэлд авагдсан зүйлээс товчилбол:

... Бакалддаг. Тонгойлгож байгаад элэг уруу өшиглөдөг. Ялангуяа хоол идсэний дараа бакалдахад элэг уруу аймаар ордог. Гар дээр сунналгаж байгаад элэг уруу өшиглөнө. Заримдаа бүүр ухаан балартдаг. Хаана байгаагаа мэдэхээ болино. Дээр би өшиглүүлсэн нэг мэдсэн чинь хогийн саван дээр тэгнүүрдээд хэвтэж байсан.

... Цээжин дээр АКА цэнэглэдэг. АКА-г маш хүчтэй газар дэвсэж цэнэглэдэг. Гэтэл хүний цээжин дээр цэнэглэхээр аймаар өвддөг.

.. Бас ТУ-57 ч билүү нэг станц байдаг. Утсыг нь чигчий хуруунд оосорлож байгаад дамрыг нь эргүүлж, тогонд цохиулдаг. Эргүүлж байхад нь гар өөрийн эрхгүй нөгөө станцаа зуураад байдаг, хаяж болдоггүй. Бас дээр 2 цэргийг хамраас нь холбож байгаад тогоор цохиулсан. Хоёр тийшээгээ үсрээд явчихдаг юм байна лээ.

... Шумууланд хазуулна гэж байдаг. 00-ын өрөөнд оруулж байгаад табчик гартаа угтаад шанааддаг. Шанаадуулсаар байгаад амны дотор тал шүдэндээ цохигдоод язарчихдаг. Хоол идэж, юм уухад маш хэцүү байдаг.



Цэргийг дэглэх, дүрмийн бус шийтгэл хүлээлгэх явдал тус ангид түгээмэл байдаг байна.

Тэр, энэ гэхгүй халууд, түрүүч нар бүгд л тэгдэг юм. Бид нар ч тэр нь их зодуулсон гэхээр юм байхгүй. Бүгд л зодуулна, хэн дуртай нь зодно...

Түүнчлэн цэргийн албан хаагчаас мөнгө, эд зүйл нэхэх зөрчил их гардаг байна. Санал асуулгад 21 цэрэг офицер, 9 цэрэг ахлагч, 19 цэрэг түрүүч, 9 цэрэг байлдагч мөнгө, эд зүйл нэхдэг зөрчлийг маш их гаргадаг гэсэн нь бусад зөрчлийг дүгнэсэн байдалтай харьцуулахад их байна.

Байнга мөнгө нэхдэг. Чөлөөгөөр явсан хүмүүсээс мөнгө заавал авдаг. Эргэлтээр ирсэн хүмүүсээс сайн уу ч гэхгүй мөнгө байна уу л гэж асуудаг болсон. Эргэлтийн байранд шалганд гарч байгаа 2 халд эхлээд мөнгө өгнө. Дараа нь ангийн жижүүр уулзах уу? гэдэг. Уулзана гэхгүй бол алуулна. Уулзана гэдэг нь мөнгө өгнө гэсэн үг. Сая тангарагийн баяр болоход орлогч бид нараас тийм юм авмаар байна гэж шаардсан. Хэрвээ өгөхгүй бол тангарагийн баярыг чинь тамын баяр болгоод өгнө шүү гэсэн. Хагас бүтэн сайнд халууд зэсэнд гардаг. Тэгэхлээрээ жинхэнэ мөнгө шаналгадаг. Удахгүй шинэ жил болно. Жинхэнэ дарамтанд орох байх даа.

Харин энэ талаар ангийн удирдлага төдийлөн мэдээлэлгүй, эмч нараас нууц байдаг тухай цэргүүд ярьж байлаа.

... Хэлэхгүй ш дээ. Ханиад хүрсэн, халуурсан, гэдэс өвдсөн бол эмчид хэлнэ. Хөхөрсөн, хавдсан бол мэдэгдэх ч үгүй. Ер нь армид оргосон цэрэг, олон цэрэг сайнаа үздэггүй хуультай.

... Офицеруудтай жаахан л үг ярьж байгаа харагдах юм бол юу ярьсан гээд зүгээр байлгахгүй. Ер нь бид нар энэ тухай мэдэгдэхээс айдаг.

... Танай авсан санал асуулгаар ч гэсэн аягүй бол бүгд зүгээр л гэнэ. Би ч гэсэн тэгж бичсэн. Биднийг энд ийм юм ярьсныг мэдвэл ална.

Цэргийн албан хаагчдаар хувийн ажил хийлгэдэг бөгөөд ихэвчлэн газар, шороо ухах, нүх малтах, юм зөөх, барилга, байшин барих, гэр барих, дулаалах, цемент, шавар зуурах ажлыг хийдэг байна. Ийм ажил хийхдээ хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгсэл тэр бүр өгдөггүй гэжээ. 2006 онд үйлдвэрлэлийн осол гарч байгаагүй боловч гар хуруугаа эсгэх, тулгах зэрэг жижиг бэртэл гэмтэл гарч байжээ. Санал асуулганд оролцогчдын 5% нь маш их, 33% нь хааяа цэргийн албан тушаалтны ар гэр, найз нөхдийн ажлыг хийдэг гэсэн байна.

#### **Дөрөв. Цэргийн албан тушаалтны (офицер, ахлагч нарын) эрхийн хэрэгжилт**

Цэргийн албан хаагчдын хувцасны хангалт хэвийн боловч цаг хугацаандаа тавигддаггүй, чанар тааруу, хүнийхээ биенд тэр бүр тохирохгүй бэрхшээл байдаг байна. Өдөрт 500 төгрөгөөр үйлчилдэг хоолоо үнэндээ таарсан, хангалттай чанартай гэж үнэлж байлаа.

Анги хотод байрладаг учраас мэдээлэл хүлээн авах боломжтой. Харин мэргэжлээрээ цаашид боловсрох, курс дамжаанд сурахад эмэгтэй цэргийн албан хаагчид ялгавартай ханддаг байна.

Цалин хугацаандаа олгогддог бөгөөд өөрийн нөхцөл байдлаасаа шалтгаалан удаан жил ажилласны, цолны, зэргийн болон онцгой нөхцлийн нэмэгдлүүдийг авдаг. Илүү цагаар ажилладаг боловч цэргийн байгууллагын ажилласан жил тооцох журам үйлчилдэг учраас илүү цагийн талаар санал гомдол байхгүй гэж байв.

Харин хортой нөхцөлд ажиллаж байгаа хүнд хөдөлмөр хамгааллын хувцас, хор саармагжуулах бүтээгдэхүүн олгодоггүй бөгөөд ангийн зүгээс ажилтнуудын нийгмийн хамгааллын талаар авч байгаа арга хэмжээнд сэтгэл дундуур байдаг гэв. Сүүлийн 5 жил тус ангид үйлдвэрлэлийн осол гарсан тохиолдол байхгүй.

Ангийн эмэгтэй офицер, ахлагч нар Хөдөлмөрийн хуулинд заасан хүүхэд төрүүлэх, асрахтай холбоотой эдлэх амралт, хөнгөлөлтөө зохих ёсоор эдэлж байна.

#### **Тав. Энгийн албан хаагчдын хөдөлмөрлөх эрхийн байдал**

013-р ангийн энгийн албан хаагчаас авсан санал асуулгад нийт 20 хүн оролцсон байна. Санал асуулгад оролцогсдын 63.2% нь 45-60 насны, хүйсийн хувьд 86.7 хувь нь эмэгтэй хүмүүс байлаа.

Тус ангид ажилчдын эрх ашгийг төлөөлсөн байгууллага байхгүй, хамтын гэрээ, хэлэлцээр байгуулаагүй. Хөдөлмөрийн гэрээ байгуулсан боловч 78%-д нь хөдөлмөрийн гэрээний нэг хувийг танилцуулж, олгоогүй байна.

Ажилчид сард 64000-79800 төгрөг авдаг бөгөөд нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг байгууллагаас хуулийн дагуу төлдөг. Ажлын үр дүнгийн нэмэгдэл хөлсөөс бусад төрлийн нэмэгдэл хөлсийг тогтмол олгодоггүй байна. Ялангуяа мэргэжлийн зэрэг, хөдөлмөрийн нөхцөл, нийтээр амрах өдөр ажилласны болон илүү цаг ажилласны нэмэгдэл хөлсийг олгохгүй байгааг ажилчид шударга бус гэж үздэг байна.

Ажилчдын 56% нь ажлын ачааллаас болж илүү цагаар ажилладаг. Ээлжийн амралтаа цаг тухайд нь эдэлж (100%), ажлын байрны хэвийн нөхцөлд ажилладаг гэж 85.7% нь хариулжээ.

Хөдөлмөрийн нөхцөл, ажил үүрэгт тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл (73.3%), хөдөлмөрийн хэвийн бус орчинд ажилладаг ажилтанд хор саармагжуулах бодис, хүнсний бүтээгдэхүүн олгодоггүй (77.8%) байна. Эрүүл мэндийн үзлэгт жилд 2 удаа оруулдаг бөгөөд хөдөлмөр хамгааллын зааварчилгаа, ажлын байран дээрх сургалт зохион байгуулдаг гэсэн байна.

Илүү цагийн мөнгө олгохгүй байгаатай холбоотой хамтын маргаан гарч байсан бөгөөд илүү цагийн нэмэгдэл, ур чадварын нэмэгдлийн аль нэгийг нь өгдөг байна.

Хөдөлмөрийн маргаан таслах комисс байгүй. Архи уусан, ажил тасалсан, танхайрсан тохиолдолд сануулахаас эхлээд цалин хасах, ажлаас халах шийтгэл оногдуулдаг байна.

## ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 015-Р АНГИД ШАЛГАЛТ ХИЙСЭН ТУХАЙ

### ИЛТГЭХ ХУУДАС

2006.12.21

ХЭҮК-ын референт Г.Нарантуяа, Ж.Цолмон нар 2006 оны 12-р сарын 14-ний өдөр Хужирбулан дахь 015-р ангид шалгалт хийлээ.

Шалгалтын хүрээнд удирдамжид заасны дагуу объектуудад үзлэг хийх, цэргийн албан хаагчид, энгийн ажилчдаас санал асуулга авах, офицер, ахлагчид, цэргийн албан хаагчидтай ярилцах болон ангийн захирагчийн тушаал, тус ангид мөрдөгдөж буй дүрэм, журамтай танилцах ажлыг зохион байгууллаа. Шалгалтын дүнд дараах нөхцөл байдал тогтоогдож байна. Үүнд:

#### **Нэг. 015-р ангийн талаарх товч мэдээлэл**

Хужирбулан дахь 015-р анги нь Зэвсэгт хүчний Жанжин Штабын зэвсэг техникийг хадгалах, хамгаалах үүрэг гүйцэтгэдэг. 1921 онд байгуулагдсан. Ангийн захирагч, хурандаа Д.Батболд. Ангийн нийт бие бүрэлдэхүүний тоо 80 орчим. Үүнээс хугацаат болон гэрээт цэргийн албан хаагч 52.2% орчим, цэргийн албан тушаалтан 33.3% орчим, энгийн ажилчид 14.5% орчмыг тус тус эзэлдэг.

Ангийн штаб, цэргийн байр, эмнэлэг хамтдаа байрлах бөгөөд 2003 онд ашиглалтанд орсон. Бусад барилга байгууламжийн хувьд 1930, 1960-аад онд ашиглалтанд оржээ.

#### **Хоёр. Цэргийн албан хаагчийн ахуй нөхцөл**

Тус анги нь цэргийн албан хаагчийн унтлагын 1 байртай. Байрны 2 жигүүр 1, 2-р ээлжийн цэргийн байрлах талбайг тусад нь зассан. Унтлагын байрны нэг цэрэгт ноогдох талбайн хэмжээ, орны тоо, гэрэлтүүлэг, агааржуулалт, дулаан стандартын шаардлага хангаж байна. Цэргүүд ор, дэрний цагаан хэрэглэл, ариун цэврийн хэрэгслээр бүрэн хангагдсан. Санал асуулгад оролцсон цэргийн 77.3% нь ариун цэврийн хэрэгсэл хангалтай гэж хариулжээ. Ор дэрний цагаан хэрэгсэлийг чанар харьцангуй сайн. Удаан эдлэгдэх ор дэрний хэрэглэлийн ашиглалтанд орсон хугацааг заагаагүй байлаа.

Ахуйн үйлчилгээний зориулалт бүхий өрөөг бэлтгэж тохижуулсан бөгөөд байнгын ашиглалтад байдаг.

Цэргийн байрны гар нүүр угаах, бие засах газрыг төхөөрөмжилсөн байдал стандартад нийцэж байгаа боловч цэвэрлэгээ, ариутгал хангалтгүй байна. Долоо хоног бүрийн Баасан гарагт цэргийн албан хаагчид халуун усанд ордог. Санал асуулгад оролцогч цэргүүд 100% долоо хоногт 1 удаа буюу сард 4-5 удаа усанд ордог гэж хариулсан байна. Усанд орох газрын ариутгал цэвэрлэгээ тогтмол хийгдэж байна.

Ангийн харуулын байрны нэг хэсгийг эргэлт, уулзалтын үед ашиглахаар тохижуулсан боловч энэ байдал нь уулзаж буй хүмүүсийн хувьд таатай, тохитой орчинг бүрдүүлж чадахгүй байна.

Ангид сахилгын хорих байр байхгүй. ЦАХ-д сахилгын арга хэмжээ авах тохиолдолд Улаанбаатар цэргийн хүрээний хэв журам сахиулах ангид хүргүүлдэг. 2006 онд тус ангиас 1 цэрэг сахилгын хорих байранд хоригдох шийтгэл авсан тухай ангийн захирагчийн тушаал гарсан байна.

Тус ангид биеийн тамирын заал байхгүйгээс өвлийн улиралд биеийн тамир, спортын төрлийн сургалт явуулах боломжгүй байдаг. Цэргүүдээс авсан санал асуулганд биеийн тамирын заалгүйгээс спортын уралдаан тэмцээн зохион байгуулж, чөлөөт цагаараа сагс, валејбол тоглож чаддаггүй гэжээ. Биеийн тамирын талбайг задгай газарт байгуулж, тохижуулсан нь стандартад нийцэж байна. Гимнастикийн хотхон байгуулсан боловч тоноглол, хэрэгслийн хангалт муу, засвар үйлчилгээ хийх шаардлагатай. Цэргүүдээс авсан санал асуулгаар 66.6% нь бие бялдраа хөгжүүлэх, спортоор хичээллэх боломжтой, 22.2% нь боломж муутай, 11.1% нь хариулаагүй байна. Эрүүл мэнд-чийрэгжүүлэлтийн танхим байгуулсан боловч техник хэрэгсэл дутагдалтай, бие бялдар хөгжүүлэх техник байхгүй байна. Тус танхимыг шинэчлэн засварлаж байлаа.

Амралт-соёлжилтын танхимыг цэргийн байранд байгуулж, хэвийн ажиллуулж байна. Тохижилт, техник хэрэгслийн хангалт хэвийн боловч караоке зэрэг зарим техник эвдэрсэн ашиглагдах боломжгүй байна.

Мэдээлэл, соёл хүмүүжлийн ажлыг тусгай төлөвлөгөөний дагуу зохион байгуулдаг боловч харилцаа, ёс заншил болон бусад мэргэжлээс гадуур боловсрол олгох сургалт зохион байгуулагддаггүй. Цэргүүд зурагт үзэх, ном сонин унших, амрах, хувийн бэлтгэлээ хангах зэргээр чөлөөт цагаа өнгөрүүлдэг гэж санал асуулгад хариулжээ.

Ангийн номын сан 4000 гаруй нэр төрлийн номын фондтой гэх боловч сүүлийн үеийн ном товхимолын хангалт муу байгаа нь ажиглагдсан. 2006 онд нэг цэрэг карт нээлгэж, үйлчлүүлсэн байсан нь номын сангийн үйлчилгээ төдийлөн хүртээмжтэй байж чадахгүй байгааг харуулж байна. Соёлын төвд Ямаханаас өөр зэмсэг байхгүй. Микрофон, өсгөгч зэргийг 1983 онд акталснаас хойш хангалтаар ирээгүй байна.

Гал тогоонд байх ёстой өрөө, тасалгаануудаас хүнс, хуурай хэрэглэл хадгалах өрөө байхгүй, ариутгал, цэвэрлэгээ хэвийн. Харин орон тооны угаагч байхгүй, угаалгын бодисын хангалтын төсвийг хассан нь энэ ажлыг хариуцсан ажилтнуудад хүндрэлтэй байна. Гал тогооны цахилгаан хэрэгсэл нь галын аюулгүй байдлыг хангасан байна. Хооллох заалны цэвэрлэгээ, тохижилт хэвийн. Байгууламжийн хувьд 1960-аад онд баригдсан учраас тааз, хана чийгшилтэй, шаардлага хангаагүй.

Долоо хоногт 24 нэр төрлийн хоолоор үйлчилдэг. Хоолны илчлэгт ангийн эмч тогтмол хяналт тавьдаг бөгөөд илчлэг дунджаар 3464.2 ККл байна. Цэргүүдээс авсан санал асуулгаар 91.6% нь өлсдөггүй, 86.1% нь иддэг хоолоо чанартай гэж дүгнэсэн байна.

Тус анги нь 1 эмч, 1 сувилагчийн орон тоотой, амбулитортой. Хэвтүүлж эмчилдэг стационар байхгүй. Цэргүүдэд 14 хоног бүр урьдчилан сэргийлэх үзлэг хийдэг бөгөөд бүртгэл, судалгаа хангалттай. Эмийн хангалт хэвийн. 2006 оны 12 сард ашиглах хугацаа дууссан Маннат 400 мл-ийн шингэнээс өөр хугацаа хэтэрсэн эм, тариа байхгүй байсан. Харин 2007 оны 1 сард хугацаа нь дуусах 5-6 нэр төрлийн эм, тариа хадгалагдаж байсныг анхааруулсан. Түүнчлэн тус ангид 18 хайрцаг, хайрцаг тус бүртээ 144 ширхэгтэй бэлгэвчийг нэг бүрийг нь 30 төгрөгөөр тооцон ЗХЖШ-аас худалдсан бөгөөд бэлгэвчийг ангийн эмнэлэг авсан үнээрээ

худалдан борлуулж байгаа нь үнэ төлбөргүй тараагдах ёстой тусламжийн зүйлээс ашиг хонжоо олж байгаа зөрчил байж болзошгүй байна. Ийм байдал 013-р ангид ч мөн байсан болно.

2006 онд тус ангид 4 цэрэг сүрьеэ өвчнөөр өвджээ. Эрдэнэт хотоос татагдан ирсэн Гантулга гэдэг цэрэг сүрьеэгийн халдвар тээгч байж, улмаар өвчин бусад 3 цэрэгт халдварласан нь цэрэг татлагын комиссын эмнэлэг дүгнэлт, шинжилгээ хариуцлагагүй явагдаж байгааг харуулж байна.

### **Гурав. Цэргийн албан хаагчдын дүрмийн бус харьцаа**

Цэргүүдтэй хийсэн ярилцлага болон санал асуулгын хуудаснаас харахад тус ангид цэргийн албан хаагчидтай дүрмийн бус харьцах ноцтой зөрчил дутагдал гардаггүй байна. Тухайлбал, санал асуулгад 2006 оны 1-р ээлжинд татагдан ирсэн цэргүүд 100% дүрмийн бус харьцаа гардаггүй гэж хариулжээ. Харин 2-р ээлжийн цэргүүдээс офицер айлган сүрдүүлэх, дарамтлах, үг хэлээр доромжлох зөрчил гаргадаг гэж 1 цэрэг, ахлагч ялгавартай ханддаг гэж 1 цэрэг, үг хэлээр доромжилдог гэж 2 цэрэг, түрүүч ялгавартай ханддаг, айлган сүрдүүлдэг, үг хэлээр доромжилдог гэж тус бүр 2 цэрэг хариулжээ. Мөн байлдагч нарын хооронд ялгавартай ханддаг гэж 1 цэрэг, айлган сүрдүүлдэг гэж 3 цэрэг, зоддог гэж 1 цэрэг, үг хэлээр доромжилдог гэж 3 цэрэг хариулсан байна. Гэхдээ эдгээр зөрчлийг бүгд хааяа гардаг гэсэн байна.

Цэргийн дүрмийн бус харьцааг таслах талаар ангийн зүгээс тодорхой арга хэмжээ авч байгаа нь үр дүнтэй болж байна. Тухайлбал, тус ангийн 2-р ээлжийн цэргийн унтлагын байрыг ангийн жижүүрийн постоос ил харагдах байдлаар, шилэн ханаар тусгаарлан тохижуулсан нь тэнд болж буй зүйлд хяналт тавих боломжтой болгосон байна. Мөн тус ангид ангийн захирагчийн тушаалаар “Ах, эгч, дүүгийн холбоо”-г байгуулсан бөгөөд энэ нь шинээр ирсэн цэрэг бүрд халамжлан хүмүүжүүлэх 1 офицер, 1 энгийн ажилтан, 1 хуучин цэрэг томилогдон цэргийн эрдэм сурах, цэргийн амьдралд дасахад нь туслалцаа үзүүлэх үүрэг хүлээдэг ажээ. Эмнэлгийн үзлэгийг тогтмол зохион байгуулж, цэргүүдэд нүцгэн биеийн үзлэг хийж байгаа нь дүрмийн бус харьцаа гарахгүй байхад сайн нөлөө үзүүлж байна. Түүнчлэн тус ангийн цэргийн тоо харьцангуй цөөн байгаа нь удирдах ажилтнууд цэрэг нэг бүртэй тулж, анхаарч ажиллах нөхцлийг бий болгож байна.

.. Манай ангийн дарга, жагсаалын дарга ер нь тийм зүйлд их дургүй. Цэргүүдийг дэглэх юм бол яриад байх зүйл байхгүй шүү гэж байнга сануулдаг. Бид нарыг хувцсыг байн байн тайлуулж үзлэг. Жаахан шалбархай, хөх байх юм бол энэ яасан юм гээд сүйд болдог. Заримдаа бид нар юм шүргээд ч юм уу биеэ хөхрүүлчихвэл бараг айдаг. Энэнээс болж халуудыг та нар ингэсэн, нуугаад байна гээд бөөн юм болдог болохоор хүнд гай чирээд яахав гэж боддог...

*/Ярилцлагын тэмдэглэлээс.../*

Урьд нь энэ ангид гардаг байсан дүрмийн бус харьцаа дарга өөрчлөгдсөнөөр байхгүй болсон тухай цэргүүд санал асуулгын хуудсанд тэмдэглэжээ. Цэргийн албанд татагдан ирсэндээ цэргүүд сэтгэл хангалуун байдаг бөгөөд 2006 оны 1-р ээлжний цэргүүдийн 50% нь албаа хааж дуусаад ангидаа ахлагчаар үлдэх хүсэлтээ ангийн удирдлагад хүргүүлсэн байна.

### **Дөрөв. Цэргийн албан тушаалтан, офицер, ахлагчийн эрхийн хэрэгжилт**

Хувцасны хангалт хугацаандаа тавигддаггүй, захиалгын тоо дутуу ирдэг болон чанар муу байдаг талаар тус ангийн офицер, ахлагч нар ярьж байлаа. Мөн өдөрт 500 төгрөгөөр үйлчилдэг хоолоо үнэндээ таарсан, хангалттай чанартай гэж үнэлж байна.

Манай ангийн 10 гаруй хүний өвлийн хувцасны хугацаа дуусаад жил гаруй болж байгаа боловч одоо болтол нөхөн хангалт хийгээгүй байна. 310-р ангид оёсон хувцасыг хөдөөний ангиудаараа тараана гэдэг. Ер нь цэргийн хувцасны Бөртэ үйлдвэр бараг сул зогсоод, орон тоогоо цөөрүүлээд байхад бидний хувцсыг оёулахдаа тендэр зарлаад хувийн оёдлын кампанид захиалга өгөөд байгаад ойлгохгүй байна.

Төрөл бүрийн эх сурвалжаас мэдээлэл хүлээн авах боломжтой боловч сурч боловсрох боломж нөхцлийн талаар ахлагч, офицеруудын зүгээс шүүмжлэлтэй хандаж байна.

... Гэхдээ армид эмэгтэй хүнийг цаашид дэмжиж, сургалтанд хамруулахдаа муу. Би л гэхэд 5 удаа англи хэлний сургалтанд явах өргөдөл өгсөн, гэтэл бодлогоор эрэгтэй хүнийг дэмжинэ гээд хүлээж авдаггүй. Түвшин тогтоох шалгалтанд нь өчнөөн орж, тэнцсэн. Хэрвээ ингэж юм бол яах гэж анх 1990-ээд оны сүүлчээр армид шинэчлэл хийнэ гэж эмэгтэй цэргийн албан хаагчдыг бэлтгэх болсон юм бэ.

... Ер нь удирдах газар танил талгүй хүн гадаадад явна гэж бараг байхгүй. Манайхан Ирак, Сьерра Леоне гээд олон газар явдаг боловч журмын дагуу өргөдлөө гаргасан хүмүүс тэр бүр хамрагдаж чадахгүй байгаа. Гадаад хэлний гэх мэт сургалтанд хамрагдахад ч гэсэн танил тал хэрэгтэй. Ангийн захирагч энэ тал дээр ямар ч нөлөө байхгүй.

*/Ярилцлагын тэмдэглэлээс.../*

Цалин хугацаандаа олгогддог бөгөөд энэ талаар ямар нэг санал гомдолгүй. Харин хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэл, хэрэглэгдэхүүнийг олгож байгаа байдал, нийгмийн хамгааллын арга хэмжээ, цэргийн албан хаагчийг урамшуулах бодлого дутагдалтай байна.

... Хөдөлмөрийн хамгааллын арга хэмжээ муу. Ялангуяа манай ангийн цацрагт зэвсэгтэй ажилладаг хүмүүс хор саармагжуулах бүтээгдэхүүн хэрэглэж баймаар байна.

... Ер нь цэргийн хүн томилолтоор ажилладаг болохоор хүүхэд, гэр бүлийнхэнд нь их хүнд тусдаг. Бид бизнес эрхлэж болохгүй. Гэтэл 30 гаруй жил хөдөө ажиллаад ангийн мэдлийн байр дамжиж амьдарсаар байгаад өөрийн гэсэн байргүй, тэтгэвэрт гарахдаа хөдөөнөөс бараг л чемодантайгаа ирдэг. Цэргийн албанаас чөлөөлөгдөхөд 36 сарын цалинтай тэнцэх хэмжээний олговор өгдөг, энэ нь нийт 4-5 сая төгрөг болно. Гэтэл энэ мөнгөөр Улаанбаатар хотод олигтойхон хашаа, байшин ч авахгүй шүү дээ. Дүрмээрээ бид хэвлэл мэдээлэлд үг хэлж, жагсаал цуглаан хийж болохгүй учраас энэ талаар хий хоорондоо ярьж бухимдаж байгаад өнгөрдөг.

... Шагнал ч гэсэн эзнээ олохгүй байна. Цэргийн байгууллагын төв аппаратад ажилладаг хүн ажилласан жилээсээ хамаараад баахан одон медаль авдаг. Гэтэл ангиудаас ганц, хоёр медаль тодорхойлолт өгөхөөр төв дээр очоод дарагдчихдаг ч юм уу, ер нь юм болдоггүй...

*/Ярилцлагын тэмдэглэлээс.../*

## **Тав. Энгийн албан хаагчдын эрхийн хэрэгжилт**

013-р ангийн энгийн албан хаагчаас авсан санал асуулгад нийт 20 хүн оролцсон байна. Санал асуулгад оролцогсдын 57.9% нь 45-60 насны, хүйсийн хувьд 75% нь эмэгтэй хүмүүс байлаа.

Санал асуулгын дүнгээс харахад тус ангид ажилчдын эрх ашгийг төлөөлсөн байгууллага байдаг бөгөөд хөдөлмөрийн гэрээг 1 хүнээс бусад нь байгуулж, гэрээнийхээ нэг хувийг танилцаж, авчээ.

Цалин хөлсний олголтын хувьд хэвийн боловч ажлын үр дүнгийн нэмэгдэл хөлсөөс бусад төрлийн нэмэгдэл хөлсийг тогтмол олгодоггүй байна. Ялангуяа

хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэлийг нийт ажилчдад, мэргэжлийн зэргийн нэмэгдлийг тал хувьд нь олгохгүй байгааг ажилчид шүүмжилжээ. Ажилчид ээлжийн амралтаа цаг тухайд нь эдэлж, ажлын байрны хэвийн нөхцөлд ажилладаг байна.

Хөдөлмөрийн нөхцөл, ажил үүрэгт тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах, хөдөлмөрийн хэвийн бус орчинд ажилладаг ажилтанд хор саармагжуулах бодис, хүнсний бүтээгдэхүүн олгох ажил хангалтгүй байна. Харин эрүүл мэндийн үзлэгт жилд 2 удаа оруулдаг, хөдөлмөр хамгааллын зааварчилгаа, ажлын байран дээрх сургалт зохион байгуулдаг гэжээ.

Тус ангид хөдөлмөрийн маргаан таслах комисс байдаг. Гэхдээ ангийн захирагчийн тушаал, шийдвэрээс харахад ажил олгогчийн талаар 5 хүнийг томилж хөдөлмөрийн маргаан таслах комиссыг байгуулсан нь хууль тогтоомжид нийцээгүй байна.

Сахилгын шийтгэл буруу ноогдуулсан тухай ямар нэг санал гомдол тус ангид байхгүй байна.

## ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБЫН 029 ДҮГЭЭР АНГИЙН ХАРУУЛЫН РОТОД ХИЙСЭН ШАЛГАЛТЫН ИЛТГЭХ ХУУДАС

2006 оны 12 дугаар сарын 7-ны өдөр Зэвсэгт Хүчний Жанжин Штабын 029 дүгээр ангийн харуулын ротын 10 байлдагч анги, байраа орхин оргосон мэдээллийн дагуу /Өнөөдөр сонины 2006 дугаар сарын 1-ний дугаар/ харуулын ротын орон байр, ахуй нөхцөл байдалтай танилцах, оргосон 10 байлдагч, ангийн удирдлагатай уулзах зорилгоор тус Комиссын референт А.Саруул, мэргэжилтэн З.Өнөржаргал нар уг анги дээр ажиллаж, ангийн удирдлага, тэдгээр байлдагчидтай биечлэн уулзан ярилцаж, тайлбар авсан болно.

### 1. Орон байр, ахуй нөхцөл

1.1 БХИС-ийн 029 дүгээр ангийн харуулын ротын нийт бие бүрэлдэхүүн 68 цэрэг байлдагчтай, үүнээс хуучин 32 байлдагч, шинэ 25 байлдагч, ахлагчийн курсийн 11 байлдагч, сонсогч байна.

Цэргийн байр нь 1917 онд баригдсан 2 давхар шавар байранд байрладаг бөгөөд тус байр нь хэдэн жилийн өмнө актлагдсан боловч анги орон байрны багтаамж муутай тул зохих хэмжээнд урсгал засвар хийж өнөөг хүртэл ашиглаж байгаа болно.

Орон байрны нөхцөл муу, хуучирч элэгдсэн байртай, цахилгааны монтаж нь хуучирсан, галын аюултай, цэргүүдийн амьдарч буй байр 3 тасагтай, ахуй үйлчилгээний өрөө нь тусдаа гар нүүр угаах, бие засах өрөө нэг дор байрладаг байна.

Тасаг өрөөнүүдийн халаалт муу, гэрлийн цахилгаан монтаж гэмтэлтэйгээс гэрлүүд байнга шатдаг, гэрэлтүүлэг муу, цонхнуудыг дулаалсан тул агаар оруулах боломжгүй, чийгшилт ихтэй тул арц хүж уугиулж чийгшилтийг арилгах арга хэмжээг авдаг байна.

- I тасаг – хэмжээ 45м кв, 27 байлдагч амьдардаг, өрөөний тохижилтийн хувьд толь, 8 тумбочка, хувцасны өлгүүр, орны тоо 2 давхар төмөр ор 14 ширхэг байв. Өрөө нь 2 халаалтын сүлжээтэй, гэрлийн цахилгаан сүлжээ 2 ба тус бүрд нь 3 салаа люстертэй боловч дөнгөж 1 салаа гэрэл нь асдаг, 3 цонхтой.
- II тасаг – хэмжээ 45м кв, 15 байлдагч амьдардаг, өрөөний тохижилтийн хувьд толь, зурагт, DVD тоглуулагч, хувцасны өлгүүр, 6 тумбочка, 2 сандал, шүүлтүүртэй ус буцалгагчтай, орны тоо 11 ширхэг 2 давхар төмөр ортой. Өрөө нь 2 халаалтын сүлжээтэй, гэрлийн цахилгаан сүлжээ 2 ба тус бүрд нь 3 салаа люстертэй боловч дөнгөж 2 салаа гэрэл нь асдаг, 3 цонхтой.



- III тасагт – хэмжээ 35м кв, ахлагчийн курсийн 11 байлдагч, сонсогч амьдардаг, өрөөний тохижилтийн хувьд 5 тумбочка, 1 толь, хувцасны өлгүүртэй, орны тоо 6 ширхэг 2 давхар, 1 дан төмөр ортой. Өрөө нь 3 халаалтын сүлжээтэй боловч халаат муу, гэрэлтүүлэг муу, 2 цонхтой гэрлийн цахилгаан сүлжээ 2 байгаа хэдий ч нэг нь л ажилладаг.
- Ахуйн үйлчилгээний өрөө - хэмжээ 21м кв, тус өрөөнд гутал оёх багаж, гутлын тос, алчуур, щётка, хувцас индүүдэх ширээ, үсчний ширээ, толь шүүгээ зэрэг нь нэг дор байдаг.
- Гар нүүр угаах болон бие засах өрөө нь угаалгын 3 тосгууртай, бие засах газар нь 2 тасалгаатай бөгөөд бохир, цэврийн нэгдсэн сүлжээтэй байв. Уг өрөөний нөхцөл хүнд, өмхий үнэр ихтэй, бие засах өрөөний суултуур тосгуур нь бөглөрсөн, ариутгал муу байлаа. Эмч, эмнэлгийн ажилтнууд 7 хоногт 1 удаа ариутгадаг хэмээн байлдагч нар тайлбарлаж байв.

Цэргүүдийн ор нь нилээн муудаж эвдэрсэн, орны бүтээлэг элэгдэж, урагдсан байдалтай харагдаж байлаа. Ротын байлдагч нар халаалт муу байдгаас шөнөдөө жиндүү, хүйтэн хонодог, даардаг хэмээн тэмдэглэж байв.

**1.2** Харуулын ротын цэргийн албан хаагчдын орчны ариун цэвэр, эрүүл ахуйн хэрэгслийн хангамжийн байдлыг санал асуулгаар авч, дүгнэж газар дээр нь үзэж шалгасан болно. Тэдний өдөр тутмын хэргэцээнд зориулж хүн тус бүрд сард:

- Оо 1 ширхэг,
- Алчуур 1 ширхэг, / улиралд олгох/
- Сойз 1 ширхэг, / улиралд олгох/
- 00 цаас 1 ширхэг /7 хоногт/ хангалт хийгдээгүй тул байхгүй байсан
- Нүүр гарын саван 1 ширхэг,
- Гутлын тос 1 ширхэг,
- 1 удаагийн сахлын татуурга 1 ширхэг
- Гутлын сойз 1 ширхэгийг/ улиралд олгох/ тус тус тавьж олгодог нормтой байна.
- Усанд орох саванг 7 хоногт 1 удаа усанд ороход нь өгдөг,
- Барааны саванг хувцас угаахад тусд нь олгодог байна.

Ор дэрний даавуу, дотуур хувцсыг Цэргийн албаныг зохион байгуулах зааврын нийтийн болон хувийн ариун цэврийн заалтанд: цэргийн албан хаагч 7 хоногт 1 удаа сольж угаалгад шилжүүлнэ гэсэн нь мөрдөгддөггүй болох нь дараахь байдлаас харагдаж байна. Нийтийн угаалгын газарт ор дэрний даавуу, нүүр гарын алчуураа 14

хоногт 1 удаа угаалгад өгдөг бол дотуур хувцсыг байлдагч нар өөрсдөө угаадаг гэж ярьж байлаа.

029 дүгээр анги дээр ангийн сахилгын хорих байр байхгүй ба ЗХЖШ-ын 032 дугаар ангийн сахилгын хорих байранд шилжүүлэн, тусгаарлан саатуулах сахилгын шийтгэлийг хүлээлгэдэг байна.

Цэргийн албан хаагчдын эргэлт уулзалтын байр байхгүй, шалган нэвтрүүлэх байрандаа уулзуулдаг байна.

## **2. Хоол хүнс, хувцасны хангалт**

**2.1.** Цэргийн албаныг зохион байгуулах зааварт цэргийн гал тогоо нь хооллох бүрэлдэхүүний тооноос хамаарч тодорхой хэмжээний зай багтаамж бүхий ажлын байр, өрөөтэй байна гэж заажээ. Үүнээс үзэхэд :

029 дүгээр ангийн хувьд стандартын дагуу байгуулагдаж, тохижуулагдсан байна. Халуун хоол боловсруулах өрөө, мах бэлтгэх өрөө, ногоо бэлтгэх өрөө, гурил бэлтгэх өрөө, хүнс хуурай хэрэглэл хадгалах өрөө, сав хэрэглэл угаах, хатаах хадгалах өрөөнүүдтэй, 1 ахлах тогооч, 2 ээлжийн тогооч, 1 ногоо бэлтгэгч, 1 махны бэлтгэгч, 1 үйлчлэгч, 1 сав угаагч гэсэн орон тооны ажилчидтай, талх барих цех нь тусдаа талх хадгалах, тавьж олгох өрөө, талх барих өрөөтэй, 4 хүн 2 ээлжээр ажилладаг байна.

Ахлах тогоочийн буюу гал тогоонд ажиллагчдын бэлтгэл, сургалтын өрөө, гал тогооны жижүүр, ээлжийн тогооч, бэлтгэгч нарын өрөө, хувцас хэрэглэл хадгалах өрөөнүүдтэй, ажиллах орчин нөхцөл хэвийн байна. Дээрх өрөөнүүд нь чийгшилт ихтэй, тааз хөлөрсөн, халаалт муу, засвар хийхээр болсон байв. Мах бэлтгэлийн өрөөний хөргөгчүүд ажилладаггүй, махаа өдөрт нь зоорьноос авч хүнсэндээ хэрэглэдэг тухай мах бэлтгэгч нь хэлсэн.

Хоолны заал нь 224 м кв талбайтай, 280 хүн нэг дор хооллох багтаамжтай, ширээ сандлын хүрэлцээ, хоолны ширээ засахад ширээн дээр тавигдах зүйлүүд /хувин, данхны тавиур, давс, перецны сав, давхарлан тавьсан таваг, хувингийн халбага, цайны аяга, халбага, цөцгийн тос, элсэн чихэртэй сав, хоол цайны үлдэгдэл хийх сав гэх мэт/ хангалт боломжийн, 4 ээлжээр цэргийн албан хаагчдыг хооллодог байна. Энэ нь үйлчлэгчийн орон тоо 1 байдаг учраас нэг дор нийт цэргийн албан хаагчдад үйлчлэх боломжгүйтэй холбоотой байна. Хооллох заалны гэрэлтүүлэг, дулаан дунд зэрэг байв. Цэргийн албан хаагчдад өдөрт 1 хүнд:

- Мах 420 г
- Гурил 100 г
- Талх 600 г

- Цагаан будаа 60 г
- Бусад будаа 40 г
- Элсэн чихэр 70 г
- Гоймон 40г
- Төмс 500 г
- Байцаа 100 г
- Манжин 20 г
- Лууван 40 г
- Варенье 30 г
- Ургамалын тос 10 г
- Өөхөн тос 25 г
- Цөцгийн тос 30 г
- Цай 4 г
- Давс 25 г
- Сонгино 30 г-аар бодож хоолыг нэр төрөл, өтгөн шингэний байдал, амт чанар, илчлэг хуваарилалт, хүрэлцээ зэргийг харгалзан үзэж, хоолны нэр төрлийг давхардуулахгүйгээр 7 хоногоор хоолны хуваарь гарган мөрддөг байна.

***/Хоолны нормыг хавсралт хүснэгтээр үзүүлэв/***

Санал асуулгын хуудсаар 28 цэргийн албан хаагчдаас судалгаа авч дүгнэхэд заримдаа өлсдөг гэж 16, өлсдөггүй гэж 12 цэрэг, ахлагч хариулсан байна. Харин хоолны амт чанарын талаархи санал асуулгад хоол хүнсний чанарын байдлыг сайн гэж 9, дунд гэж 18, муу гэж 1 цэрэг хариулсан байна.

Хоолны хүрэлцээ, амт чанарын талаар цэргүүдийн өгсөн санал асуулгад хоол хүнсний нөхцөл байдал дунд гэж нийт санал асуулга өгсөн цэргүүдийн 57.1 хувь нь үзжээ. Зарим ярилцлага, санал асуулгын хуудсанд бичигдсэн санал анхаарлыг татаж байна. Тухайлбал: зарим цэрэг санал асуулгын хуудсанд гэдэс дотроор хоёрдугаар хоолыг, ямааны махаар нэгдүгээр хоол их хийдэг, хоолны амт муу, илчлэг багатай, хоолны орц хэмжээндээ хүрдэггүй төмс гол төлөв муудсан байдгийг тэмдэглэсэн.

Эдгээр тэмдэглэл, ярилцлагаас үзвэл хоол хүнсэнд хэрэглэж байгаа махан бүтээгдэхүүний чанар, нэр төрөл төдийлөн сайн биш байдаг байна гэсэн дүгнэлтийг хийж болохоор байна. Иймд цэргүүдийн хоол хүнсэнд хэрэглэж байгаа хүнсний бүтээгдэхүүний чанар нэр төрөлд анхаарах хэрэгтэй болох нь харагдаж байна.

Тухайн үед цэргийн ангийн төмс хүнсний ногооны зоорины нярав байгаагүйгээс төмс ногооны хадгалалтын байдалд ажиглалт хийгээгүй болно.

**2.2** Хувцасны хангалтыг өвөл, зуны улиралд жилд хоёр удаа тавьж олгодог байна.

Санал асуулгын дүнгээс үзэхэд гутал, хувцасны хангалтын талаар бүгд 28 цэрэг санал асуулгад хамрагдсанаас хувцасны хангалт сайн 18, дунд 9, муу 1 гэсэн байна.

Харин хувцасны хангалтын талаар дутагдалтай зүйл байна уу гэсэн асуултанд захны даавуу, хөлийн жийрэг, дотуур хувцас /жипа цагаан/ зэргийг 2 ээлж байлгавал зүгээр байна, гутал /бакал/ нь дааруулдаг, зуны бакалтай гадаа жаахан удвал хөлдөөд хөл хайрдаг гэж хариулсан байна.

Цэргүүд харуулд гарахад 4 ээлжийн дах дээлийг ээлжлэн шинелийн гадуур өмсдөг бөгөөд эдгээр дээлийг энэ жил шинээр авсан, хуучин дээлүүдийг, халагдсан цэргүүдийн хувцастай хамт шатаасан, цэргүүдийн хувцасны хангалтыг одоо хийж байгаа тухай өгүүлсэн.

### **3. Соёл хүмүүжлийн арга хэмжээ**

Харуулын рот нь бие бялдаржуулах спорт заалгүй, байрны багтаамж, хүрэлцээ байхгүйгээс ямар нэгэн үйл ажиллагаа явуулах танхимгүй, мөн соёл хүмүүжлийн арга хэмжээг явуулах цаг хомс зэрэг нь эдгээр цэргийн албан хаагчдын цагаа зөв зохистой өнгөрүүлэх нөхцөл нь бүрдээгүй байв.

Соёл хүмүүжлийн арга хэмжээг явуулдаггүй болох нь санал асуулгын хуудас болон ярилцлагаас дүгнэгдэж байна. Тухайлбал: бэлтгэл хийх заалгүй, спортын хэрэгслүүдгүй, бидний амьдарч буй орчин нөхцөл муу, ротод спортын заалгүй учраас штабын зааланд хааяа очиж тоглодог, биеийн тамираар хичээлэх сонирхол их байдаг ч хичээллэж чаддаггүй гэжээ.

Түүнчлэн таны хүсэн хүлээдэг ямар ажил зохиох хэрэгтэй байна вэ? гэсэн асуултанд: биеийн тамирын тэмцээн уралдаан 7 хоногт нэг удаа зохиох, бие бялдар хөгжүүлэх орчин нөхцлийг бий болгох, сургалт сурталчилгаа, соёл хүмүүжлийн ажил зохиох, бусад цэргийн сургуулиудтай шифийн холбоотой хамтарч ажиллах, оюун ухаан сорьсон аст, тата тунга, би чадна гэсэн тэмцээн уралдаан зохиомоор байна хэмээн хариулсан байна.

### **4. Эмнэлгийн үйлчилгээ**

Эмнэлгийн албыг ахмад Цэгмэдсүрэн ахалж ажилладаг. 5 ортой, 2 их эмч, 1 бага эмч, 4 сувилагч, 1 асрагчтайгаар ээлжлэн ангийн нийт бүрэлдэхүүнд үйлчилдэг.

1 байлдагч жилд 22 400 ₮-ийн төсөвтэй, анги 400 байлдагчтай тул жилийн төсөв нийт 1 сая 600 мянган ₮-ийн төсөвтэй үйл ажиллагаа явуулдаг ба наад зах нь эмнэлгийн техник, тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээний мөнгө эмнэлгийн төсвөөс гардаг тул төсөв мөнгө хүрэлцдэггүй тухай эмч нар тэмдэглэж байсан.

1 сард эм таталтанд 100 000 ₮ төсөвлөгддөг нь хэрэгцээт эмийг авахад хүрэлцдэггүй тул улиралд 1 удаа эм татдаг /300 000 ₮/ байна.

Хүн эмнэлгийн “Ангийн эмнэлэгт хэвтэгсдийн жагсаалт”, “Гадуур эмнэлэгт хэвтэгсдийн журнал”, “Эм томилгооны жагсаалт” хэмээх бүртгэлийн дэвтэрүүдтэй танилцахад бүртгэлийг хангалтгүй тэмдэглэдэг байна. Тухайлбал: үйлчлүүлэгчийн овог нэр бүтэн бүртгэгдээгүй, өвчний шалтгаан тэмдэглэгдээгүй зөвхөн онош тавигдсан, дээрх бүртгэлүүдийн ихэнх нь гэмтэл бэртэлийн тэмдэглэлүүд байв.

Эдгээр гэмтэл бэртлийн шалтгааныг дүрмийн бус харьцаанаас үүдэлтэй байж болзошгүй хэмээн үзэн, эмч нараас асууж тодруулахад мэдэхгүй, мартсан гэсэн хариултыг өгч байсан.

Мөн эмнэлгээр үйлчлүүлэгсдийн дунд хатиг, үлд болон бөөр, ходоод болон хоол боловсруулах эрхтний өвчлөл түгээмэл байгаа нь анхаарал татаж байлаа.

Хүн эмнэлэгийн эм зүйч одоогоор эзгүй, сарын чөлөө авсан гэх шалтгаанаар эмийн сантай танилцах боломж олдсонгүй.

Яаралтай эмийн хайрцагнаас хугацаа нь 2007 оны 1 сард дуусах зүрх судас болон өвчин намдаах, тайвшруулах зориулалтын эм цөөнгүй байна. Тухайлбал: Лидокайн 2 мл, Аскорбиновая кислота 2мл гэх мэт. Хугацаа 2006 оны 9 дүгээр сард дууссан Ношпа 40 мл мөн цөөнгүй тоогоор гарсан болно.

Харуулын ротын ариун цэврийн зааварлагчаар мэргэжлийн бус ажилтан тус ангид алба хааж байгаа байлдагч, дэд түрүүч Ш.Бямбацогт ажиллаж, эмнэлэг ойрхон, эмнэлгийн тусламж үзүүлэх шаардлагатай тохиолдолд бүртгэлийн дэвтэртээ тэмдэглэн эмнэлэгт хүргэж өгдөг, цэргүүдийн жинг 7-14 хоногт нэг удаа хэмждэг, тус ротод жингийн алдагдалтай байлдагчид байхгүй байна гэсэн тайлбарыг өгч байсан.

## **5. Дүрмийн бус харьцаа**

Цэргийн удирдах албан тушаалтан, офицерууд удирдлагадаа байгаа цэргийн албан хаагчдад хүч хэрэглэх, дарамтлах дүрмийн бусаар харьцах харьцаа нь цэргийн байгууллага дахь хүний эрхийн хамгийн ноцтой зөрчил гэж үздэг тул ийм харьцаа байгаа эсэхийг тодруулах зорилгоор цэргийн албан хаагч, байлдагч нараас санал асуулга авах, ярилцлага хийх, хүн эмнэлгийн баримт бичигтэй танилцах зэргээр ажиллав.

Түүнчлэн хэвлэл мэдээллийн хэрэгслээр Зэвсэгт Хүчний Жанжин Штабын 029 дүгээр ангийн харуулын ротын 10 байлдагч анги, байраа орхин оргосон мэдээллийн дагуу /Өнөөдөр сонины 2006 дугаар сарын 1-ний дугаар/ ангийн удирдлага болон байлдагч нартай биечлэн ярилцаж, тайлбар авлаа.

Манай анги дээр хүний эрхийн зөрчил болох, ялгавартай хандах, дүрмийн бус харьцаа байгаа нь үнэн.

Жишээ нь: өмнөх ээлжийн цэрэг дараагийн ээлжийн цэргээ дээрэлхэх, дээд курсийн оюутан доод курсийн оюутнаа дээрэлхэх, мөн хот хөдөөний ялгаа их гардаг. Хамгийн ноцтой нь бид үүнийг илрүүлж чадахгүй байгаад юм. Асууж сураглан, уулзаж ярилцан санал асуулга авахад хэлдэггүй, далд байгаад байдаг. Ангийн удирдлагад дүрмийн бус харьцааны асуудлаар урьд өмнө нь ямарваа нэгэн өргөдөл гомдол гараж байгаагүй. Саяны гарсан тохиолдол дээр бид салааны ахлагч А.Батсүхэд дүрмийн бус харьцаа гаргасан тул МУ-ын "Цэргийн сахилгын дүрэм"-ийн 42-ийн "б"-д зааснаар үндсэн цалинг 2 сар 20 хувиар бууруулан шийтгэж, анги орхиж оргосон 10 байлдагчийн энэ хэргийг зохион байгуулсан гэх 3 байлдагчийг /гол зохион байгуулагчид/ Л.Хишигбатыг 10 хоног, байлдагч О.Наранбаяр, Б.Бат-Эрдэнэ нарыг 7 хоног тус тус сахилгын хорих байранд тусгайрлан хорьсон байгаа. Үүнээс гадна бид салаан ахлагч, байлдагч нарын хоорондоо эвсэг найртай байх, бие биенээ ойлголцох боломж олгох үүднээс БХИС-ийн сэтгэл зүйч багштай уулзуулан ярилцлага хийлгэн, хуулийн зөвлөх урьж эрх зүйн болон харилцааны асуудлаар лекц уншуулсан.

Өнөөдрийн байдлаар эдгээр цэргийн албан хаагчдын хоорондоо ойлголцох байдал дээрдэж байна. Мөн оргосон 10 байлдагчтай нэг бүрчлэн ганцаарчлан уулзаж, бичгээр санал хүсэлтийг нь авсан. Хоорондоо ялихгүй юм дээр үл ойлголцож, салаан дарга нь жаахан түргэдсэн асуудал гарсан байна билээ.

**Ангийн захирагч, хошууч генерал Н.Жалбажавтай хийсэн ярилцлагаас**

**Энэ асуудлаар ангийн удирдлагын зүгээсхийсэн тайлбар албан тоотыг хавсаргав.**

Офицер, цэргүүдийн хоорондоо үл үйлголцох харьцаанаас болж энэ асуудал үүсэж оргосон. Салаан даргыг орж ирэхэд тоглоомоор хоорондоо ноцолдож байхад учрыг нь ойлгохгүй уурлаж сахилгын арга хэмжээ авна гэсэн. Тайлбар хийхэд сонсохыг хүсээгүй. 11 дүгээр сарын 15-нд асуудал болсон оройдоо оройн тоонд гараад оргосон. Маргааш нөгөөдрөөс нь хэсэгчилж ирсэн. Заримыг нь салаан дарга цуглуулж, заримыг нь ар гэрийнхэн авчирч, зарим нь өөрсдөө ирсэн. Шалихгүй тоглоом шоглоомын зүйлээс болж шийтгэл авахаас айсан учир оргосон. Хоорондоо цугтаа ирсэн нэг үеийн цэргүүд наргиж наадах зүйл байна шүү дээ. Үүнийг ойлгоогүй. Оройн тоонд гарахад нэг, нэг удаа шанаа өгч, оройн тооны дараа та нартай хатуу ярина, шөнө унтахгүй шүү гэх мэтээр айлган сүрдүүлэхэд нь бид айгаад оргосон.

Мөн хувцас тайлуулж цаг барьж, хурдан хурдан өмсүүлэх зэргээр дарамталж дэглэсэн. Одоо анги соёл хүмүүжлийн лекц хурал хийж, салаан даргатай тулж ярих ярилцлага зохиож, БХИС-ын сэтгэл зүйчтэй уулзуулсан гэх мэт арга хэмжээ зохион байгуулсан. Энэ явдлаас хойш бидний харьцаа дээшилж байна. Ингээгүй бол яах ч байсан юм. Урьд нь харьцааны тал дээр болон өөр соёл хүмүүжлийн арга хэмжээг зохион байгуулж байгаагүй. Энэ асуудлаас хойш идэвхтэй зохиож асуудал дээрдэж байгаа. Өргөдөл гомдол гаргах эрхтэйгээ бид өмнө мэдээж байгаагүй. Хэнд яаж хандахаа мэддэггүй байсан. Үндсэндээ зохион байгуулсан хүн байгаа, тэд нарыг гаргаж хэл гэж тулгасан учраас манай 3 цэрэг сахилгад орсон. Анги дээр хоцорч ирсэн 3 цэргийг зохион байгуулсан гэж үзсэн. Үнэндээ бид шийтгэл авахаас бид айж байсан учир оргосон болохоос, нэг нь санаачлага гарган удирдаж зохион байгуулсан юм байхгүй ээ. Ер нь соёл хүмүүжил, харьцааны талаар ямар ваа нэг арга хэмжээ, сургалт зохиодоггүй тул бие биенээ үл ойлгох, дэгийн асуудал үүсдэг нь үнэн. Одоо бидний харьцаа зүгээр байгаа. Ямар нэгэн гомдолгүй.

**Оргосон хэмээх 10 цэргийн 7-той нь хийсэн ярилцлагаас/ бусад нь харуулд гарсан байв/**

**Сахилгын хорих байранд тусгаарлан саатуулагдсан 3 байлдагчдаас авсан тайлбарыг хавсаргав.**

Эмнэлгийн “Ангийн эмнэлэгт хэвтэгсдийн жагсаалт”, “Гадуур эмнэлэгт хэвтэгсдийн журнал”, “Эм томилгооны жагсаалт” хэмээх бүртгэлийн дэвтрүүдтэй танилцахад, бүртгэлийг хангалтгүй хөтөлдөг бөгөөд тухайлбал: үйлчлүүлэгчийн овог нэр бүтэн бүртгэгдээгүй, өвчний шалтгаан тэмдэглэгдээгүй зөвхөн онош тавигдсан байснаас ажиглагдаж байна. Бүртгэлийн ихэнх нь гэмтэл бэртэл авсан цэргүүдийн бүртгэл байсан бөгөөд энэ нь дүрмийн бус харьцаанаас үүдэлтэй гэмтэл бэртэл байж болзошгүй хэмээн үзэж, эмч нараас юунаас үүдсэн гэмтэл бэртэл болохыг тодруулахад мэдэхгүй, мартсан гэсэн хариултыг өгч байсан нь анхаарал татаж байв. 28 байлдагч хамрагдагсдын 71.4 хувь нь цэргийн байгууллагад ийм харьцаа ямар нэгэн хэмжээгээр байдаг гэдгийг хүлээн зөвшөөрсөн байгаа нь дүрмийн бусаар харьцах зөрчил бага бус байгааг харуулж байна.

Ийм зөрчлийг хэний зүгээс гаргаж байгааг судалж үзэхэд ийм харьцааг офицеруудын зүгээс гаргадаг гэж 13 хүн, ахлагч нарын зүгээс гаргадаг гэж 3 хүн, түрүүч нарын зүгээс гаргадаг гэж 7 хүн, байлдагч нарын зүгээс гаргадаг гэж 5 хүн хариулсан байна. Санал асуулгад оролцогсдоос ялгавартай ханддаг гэж 18 хүн, айлган сүрдүүлж дарамталдаг гэж 22 хүн, мөнгө эд зүйл шаарддаг гэж 21 хүн, зодож хүч хэрэглэдэг гэж 17 хүн, үг хэлээр доромжилдог гэж 17 хүн, дүрмийн бус шийтгэл хүлээлгэдэг гэж 17 хүн, бусдаар зодуулдаг гэж 13 хүн тус тус хариулсан нь дүрмийн бус харьцааны ямар хэлбэрүүд ихэвчлэн гардгийг харуулж байна.

Санал асуулгын хуудсанд удирдах албан тушаалтнуудын зүгээс өөрт чинь хүч хэрэглэсэн, дарамталсан, зүй бус харьцсан ноцтой тохиолдол байгаа тухайгаа дэлгэрэнгүй бичнэ үү? гэсэн асуултанд: Хааяа биднээс биелэгдэшгүй зүйлийг шаардах, зодох, мөнгө төгрөг нэхэх, гадны өөр ангийн офицерууд ирж дүрмийн бусаар харьцах, шийтгэл оногдуулах тохиолдол байдаг гэж хариулсан байна. /Жич: тэд эдгээр албан тушаалтнуудын нэрийг бичихээс татгалзсан/

Үүнээс үзэхэд цэргүүдийн дунд байгаа дүрмийн бус харьцаа нь маш нууцлагдмал, ил гаргаж тавих боломж, нөхцөл бүрдээгүй, зохих журмын дагуу гомдол гаргаж шалгуулдаггүй байдал хэвшил болсон гэж үзэх үндэстэй байна.

Шалгалтын явцад өргөдөл, гомдол гаргах боломжтой юу? гэж асуухад 28 байлдагчаас 22 байлдагч боломжтой, 6 байлдагч боломжгүй гэж хариулсан бөгөөд эдгээр цэргүүд удирдагадаа өргөдөл гомдол гаргах эрхтэйгээ сая болсон явдлаас хойш мэдэж байгаа гэсэн тайлбарыг өгөв.

2006 оны Улаанбаатар цэргийн хүрээний ёс журам сахиулах 032 дугаар ангийн сахилгын хорих байранд хоногтоо сатуулагдсан цэргийн албан хаагчдын мэдээтэй танилцахад 029 дүгээр ангийн хувьд 18 цэргийн албан хаагчид хоногтоо

саатуулагдах сахилгын шийтгэлийн хэлбэрийг хүлээсэн байна. Үүнээс сахилгын шийтгэлийн хоногтоо тусгаарлан саатуулах хэлбэрийг хүлээлгэсэн үндэслэлийг судлан үзэхэд: оргосон, сахилгын зөрчил гаргасан, чөлөөгүй явсан зэрэг үндэслэлүүд байна. Энэ шийтгэлийн хэлбэрийг ихэнх тохиолдолд байлдагчид хүлээж байжээ. Тус ангийн хоногтоо тусгаарлан саатуулах сахилгын шийтгэлийн хэлбэрийг 3, 5, 7, 10 хүртэл хоногийн хугацаатайгаар оногдуулдаг байна. Саатуулагсдыг хүлээн авах хуудсыг судлан үзэж танилцахад ямар үндэслэлээр саатуулагдаж буйг бичдэггүй, зөвхөн тэр даргын шийдвэр, энэ даргын шийдвэрээр сахилгын шийтгэл оногдуулсан гэсэн бүрхэгдүү байдлаар хуудсыг бөглөдөг, мөн зарим хуудас байхгүй огт тэмдэглэгээгүй байна. Ерөнхийдөө тус ангийн байдлаар цэргүүдэд хоногтоо саатуулах сахилгын шийтгэл хүлээлгэх хэлбэрийн үндэслэл болж буй тохиолдлууд нь оргох буюу чөлөөгүй явах тохиолдлууд байна. Иймд оргоход нөлөөлж буй гол шалтгаан нөхцлийг судлан үзэж, үүнийг таслан зогсоохын тулд тодорхой арга хэмжээ авах нь зүйтэй байна.

Мөн мэдээнд БХИС-ын 8 сонсогч, Ахлагчийн коллежийн 6 сонсогч хоногтоо саатуулагдах сахилгын шийтгэлийн хэлбэрийг хүлээсэн байна. Дээрх сонсогчдын сахилгын шийтгэл оногдуулсан үндэслэлийг тусгаарлан саатуулах хуудаснаас үзэж танилцахад: жижүүрийн томилгоо тасалсан, харуул манаанд гарахаас эсэргүүцэж тушаал биелүүлээгүй, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хичээл тасалсан, шалгалт тасалсан, архи уусан зэрэг үндэслэлүүд байна. Мөн зарим саатуулах хуудсанд шийтгэл оногдуулсан үндэслэл бичигдээгүй, зарим хуудас нь байхгүй байна. БХИС-ын сонсогч Б.Говь, Харуулын ротын Н.Дугарсүрэн нар 2 удаа сахилгын шийтгэлийн хоногтоо тусгаарлан саатуулах шийтгэлийн хэлбэрийг хүлээж байсан байна.

## **6. Албадан хөдөлмөр**

Санал асуулгын хуудсаар цэргийн албан хаагчдаас ар гэртээ болон танил талынхаа ажлыг хийлгэдэг эсэх талаар 28 байлдагчидаас 67,8 хувь нь ийм ажил хийлгэдгийг үгүйсгээгүй байна.

Мөн хэрэв хийлгэдэг бол ямар төрлийн ажил хийлгэдэг талаар тайлбарт: хар ажил хийлгэж, хортой нөхцөлд ажиллуулдаг, гуйвраар янз бүрийн ажил хийлгэдэг, газар шорооны ажил, айл нүүлгэх, нүх ухах, дарга нарын гуйлтаар ар гэрийн ажлыг нь хийдэг, сургуулийн анги танхимд ажилладаг хэмээн дийлэнхи нь хариулсан байна. Үүнээс үзэхэд цэргийн ангид албадан хөдөлмөр эрхлүүлэх асуудал газар авсан байна гэсэн дүгнэлтэнд хүргэж байна.



## 7. Бусад

Тус Комисст хандаж хэлэх зүйл байгаа эсэх талаар санал асуулгаар 029 дүгээр ангийн цэргийн албан хаагчид ялгаварлан гадуурхалтыг зогсоох, бидний зөрчигдөж буй эрхийг хамгаалах, орон байрны нөхцлийг сайжруулах, түүнчлэн бидний эрх, үүргийг ойлгуулж өгөхийг хүссэж байна.

Хугацаат цэргийн албан хаагчид сард түрүүч 2700 ₮, байлдагч 2150 ₮ -ийн цалин хөлсийг улсын төсвөөс олгох ёстой бөгөөд сар бүрийн цалингийн хүснэгтэд гарын үсэг зурдгаас өөр энэхүү цалин хөлс нь тэдний нэрийн дансанд шилжиддэг үгүйг мэдэхгүй, гар дээр нь бэлнээр олгогддоггүй, хаашаа ордгийг мэдмээр байна гэсэн хүсэлтийг гаргасан.

## 8. Хөдөлмөрийн гэрээгээр ажилладаг энгийн ажилчдын санал асуулга

029 дүгээр ангид ажиллаж байгаа энгийн 5 ажилтнаас санал асуулгын хуудас бөглүүлж, гарч буй ямар зөрчил дутагдал байгааг дүгнэж үзэхэд: ажлын ачаалал их байдгаас илүү цагаар ажлуулах асуудал их гардаг байна.

Санал асуулгын хуудаснаас харахад тус ангид ажилчдын эрх ашгийг төлөөлсөн үйлдвэрчний байгууллага байдаггүй, хамтын гэрээ хэлэлцээр, хамтын гэрээний талаар ойлголтгүй, мөн хөдөлмөрийн маргаан таслах комисс байхгүй, сахилгын шийтгэлийн цалингаас хасах хэлбэрийг оногдуулдаг, мэргэжлийн зэргийн нэмэгдэл, хөдөлмөрийн нөхцлийн нэмэгдэл олгогддоггүй, илүү цагаар ажилласны нэмэгдэл хөлс, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс, нийтээр амрах баярын өдөр ажилласны нэмэгдэл хөлс, долоо хоногийн амралтын өдөр ажилласны нэмэгдэл хөлс зэрэг нь заримдаа олгогдоод заримдаа олгогддоггүй байна.

## 9. ДҮГНЭЛТ, САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Шалгалтын явцад авсан санал асуулга, ярилцлага, ажиглалт, олж авсан мэдээллээс харахад ЗХЖШ-ын 029 дүгээр ангийн цэргийн албан хаагчдын дунд дүрмийн бусаар харьцах, хүч хэрэглэх, зодох, зэрэг зөрчлүүд гардаг гэж үзэх үндэстэй байна.

Ялангуяа ийм зөрчил нь офицер, түрүүч нарын зүгээс их гардаг нь санал асуулгын дүнгээс илт харагдаж байна, тухайлбал ямарваа нэгэн хэлбэрээр ялгаварлан гадуурхах, айлган сүрдүүлэх, мөнгө эд зүйлс шаардах, зодох хүч хэрэглэх гэх мэт дүрмийн бус харьцаа нь дээрхи албан тушаалтнуудын зүгээс илүүтэй гардаг байна.

Санал асуулгад хамрагдсан хуучин цэргүүдийн нилээд хувь нь дүрмийн бус харьцаа байдаг гэдгийг хүлээн зөвшөөрсөн байна. Ийм зөрчлийг тус ангийн хүрээнд

нийтлэг зөрчил дутагдал гэж үзэхээс өөр аргагүй, энэ зөрчлийг юугаар ч зөвтгөх аргагүй гэж дүгнэж байна.

Цэргийн албан хаагчдын амрах, ажиллах, суралцах орон байрны хувьд хүрэлцээ муутай, ахуй нөхцөл шаардлагын хэмжээнд хүрээгүй, цэргийн албан хаагчид чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх ая тухтай нөхцөл бүрэн бүрдээгүй, цэргийн албан хаагчдын дунд соёл хүмүүжлийн болон бие бялдраа хөгжүүлэх ажил хангалтгүй байна.

Цэргийн ангид хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсадын хөдөлмөрийн харилцааг хөдөлмөрийн хуулийн хүрээнд зохицуулж, хөдөлмөрийн гэрээнийхээ заалтыг хатуу мөрдөж, хууль тогтоомж зөрчиж байгаа аливаа үйлдлийг зргсоох шаардлагатай байна.

Шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, дахин гаргахгүй байх үүднээс дараах зүйлүүдийг санал зөвлөмж болгож байна.

1. Цэргийн байгууллагад захирагч, захирагдагч, байлдагч нарын хооронд гарч байгаа аливаа дүрмийн бус харьцаа ялангуяа хүч хэрэглэх, дэглэх зэрэг ноцтой зөрчлүүдийг таслан зогсоох, офицер, ахлагч, түрүүч зэрэг удирдах тушаалын албан хаагчдын харьцааны соёлыг дээшлүүлэх, зөвхөн хууль, цэргийн дүрмийн хүрээнд харьцаж, цэргийн сахилга, дүрэм зөрчсөн цэргийн албан хаагчид цэргийн дүрмийн хүрээнд сахилгын шийтгэл оноодог болгох талаар удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх.
2. Байлдагч нартай дүрмийн бусаар харьцсан, хүч хэрэглэсэн, дэгэлсэн, дүрмийн бус шийтгэл хүлээлгэсэн тохиолдол бүрийг судлан бүртгэж, гэм буруутай албан хаагчид зохих хариуцлага тооцож, нийт бие бүрэлдэхүүнээр хэлэлцүүлж, тодорхой арга хэмжээ авч хэвших.
3. Цэргийн албан хаагчдын орон байрны ахуй нөхцлийг сайжруулах, амьдрах орчин нөхцлийг дээшлүүлэх, цэрэг бүрийг ор дэвсгэрээр хангах, унтаж амрах нөхцлийг нь бүрдүүлэх, хоол хүнснийх хангамж, чанарын доголдлыг арилгаж, цэргийн албаа нэр хүндтэй хаах нөхцлийг нь дээшлүүлэх.
4. Цэргийн албан хаагчдын эрүүл мэндийн үйлчилгээнд гарч буй зөрчил дутагдлыг арилгаж, эмнэлгийн үйлчилгээг, үүнээс эрүүл мэндийн бүртгэлийг нарийн хөтлөх талаар анхаарч ажиллах.
5. Харуулын ротын байлдагч нар чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх ахуй нөхцлийг сайжруулж, бие бялдраа хөгжүүлэх, бие хамгаалах урлагт суралцах, спортоор хичээллэхэд шаардагдах тоног төхөөрөмжөөр хангах, ажлын

ачаалал, стрессээ тайлах, харилцааны ёс зүйн талаар сургалт явуулах талаар системтэй ажил зохион байгуулах.

6. Цэргийн ангийн эмнэлгийн албыг бэхжүүлэхэд байгаа нөөц бололцоогоо дайчлан, албан хаагчдыг эрүүлжүүлэх, ажиллах нөхцөл бололцоог нь дээшлүүлэх, орон байраар хангах чиглэлээр тодорхой ажил зохиох.
7. 029 дүгээр ангийн байлдагч болон цэргийн албан хаагчид захирагч /дээд албан тушаалтан/-хаа хууль бус харьцаа, үйл ажиллагаанд гомдол санал гаргах уур амьсгалыг бүрдүүлэх, ингэснийх нь төлөө аливаа дарамт шахалт үзүүлдэггүй байх нөхцлийг бүрдүүлэх.
8. Цэргийн байгууллагад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй энгийн ажилчдын хөдөлмөрийн харилцааг хөдөлмөрийн хууль бусад хуулийн хүрээнд зохион байгуулж, илүү цагаар амралт чөлөөгүй ажиллуулах, хөдөлмөрийн гэрээнд зааснаас өөр ажил гүйцэтгүүлэх зөрчлийг арилгаж ажиллах.
9. Цэргийн албан хаагчдыг гуйх нэрийдлээр ар гэрийнхээ болон танил талынхаа ажлыг хийлгэдэг албадан хөдөлмөр эрхлүүлэх асуудлыг таслан зогсоох.
10. Хугацаат цэргийн албан хаагчдын улсын төсвөөс олгодог цалин хөлсний талаар мэдээллийг цэргийн албан хаагчдад хийж, нэг мөр ойлголттой болгох ажлыг зохион байгуулж байх.

## ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБЫН 326, 120, 032 ДУГААР АНГИУДАД ХИЙСЭН ШАЛГАЛТЫН ИЛТГЭХ ХУУДАС

Тус Комиссоос 2006 оны 12 дугаар сарын 12-15-ны өдөрүүдэд Зэвсэгт хүчний Жанжин Штабын 326, 120, 032 дугаар ангиудад цэргийн албан хаагчдын эрхийн хэрэгжилтын байдалд тусгай удирдамжийн дагуу шалгалт хийж, тухайн ангиудын орон байр, ахуй нөхцөл байдалтай танилцан, ангийн удирдлага, цэргийн албан хаагчидтай уулзаж, санал асуулга авч, дүнг нэгтгэв. Шалгалтыг тус Комиссын референт А.Саруул, мэргэжилтэн З.Өнөржаргал нар анги тус бүр дээр нэг, нэг өдөр ажиллаж, гүйцэтгэв.

Санал асуулгын хуудсыг 326 дугаар ангиас 206 цэрэг, 19 энгийн ажилчид, 120 дугаар ангиас 246 цэрэг, 15 энгийн ажилчид, 032 дугаар ангиас 141 цэрэг, 23 энгийн ажилчид, нийт 593 цэргийн албан хаагч, 53 энгийн ажилчдаас авсан болно. Санал асуулгын хуудсыг тус тусд нь нэгтгэж илтгэх хуудсанд хавсаргав.

Зэвсэгт хүчний нийт ангиудад ЗХЖШ-ын даргын 2006 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 872 тоот тушаалыг үндэслэн Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн орон тооны бус салбар зөвлөлийг байгуулсан байна./Тушаалыг хавсаргав/

### **1. Орон байр, ахуй нөхцөл**

**1.1** Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн захирагч хурандаа С.Батболд, анги нь нийт бие бүрэлдэхүүн нь 100 офицер ахлагч, 100 хуучин цэрэг, 100 шинэ цэрэг, гэрээт цэрэг 30, БХИС-ийн 30 сонсогч цэрэг дадлага хийж, 40 гаруй энгийн ажилтан байна. Цэргийн байр нь 1976 онд баригдсан. Тус анги уг байранд 10 жилийн өмнө шилжин ирсэн ба зохих хэмжээнд урсгал засвар хийж өнөөг хүртэл ашиглаж байгаа болно.

Орон байрны нөхцөл нь цэргийн албан хаагчдын амьдарч буй байрны хувьд төдийлөн сайн биш байна. Цэргийн байр нь хуучин, шинэ, сонсогч, гэрээт цэргийн байр гэсэн ангилалтаар зохион байгуулагдсан, үүний дагуу цэргийн албан хаагчдын амьдрах нөхцөл байдалтай танилцлаа. Эдгээр байрууд нь амралт соёлжилтын өрөө, гар нүүр угаах өрөөтэй байна. /усыг өдөрт цагийн хуваарийн дагуу 3 удаа шахдаг/ Тасаг өрөөнүүд нь халаалт муу, гэрлийн цахилгаан монтаж гэмтэлтэй, гэрэл нь байнга шаттдаг, гэрэлтүүлэг хангалтгүй, цонхнууд дулаалгагүй байв.

### **Хугацаат цэргийн байр:**

- Байр нь 4 тасагтай, хуарангийн байдлаар амьдардаг, тасгийн хэмжээ 72 м кв, 1 тасагт 30 байлдагч амьдардаг, өрөөний тохижолтийн хувьд 8 тумбочка, хувцасны өлгүүр, 11 -15 сандалтай байв.

- Эдгээр байруудад амралтын 45 м кв өрөөтэй, тохижилтын хувьд 2 жижиг ширээ, 1 шкаф, 2 кресло, 1 диван, 1 зурагт, DVD тоглуулагч, номын тавиуртай, мөн бялдаржуулах танхимтай байна. Хуучин цэргийн байр нь компьютертэй байв.

**Гэрээт цэргийн байр:**

- Тус байр нь 5 тасагтай, тасгуудыг 8, 6, 4 гэсэн байлдагчид амьдрахаар тохижуулсан. Тохижилтын хувьд сайн боловч, зүүн жигүүрт нь халаалт ирэх нь муу байна.
- Амралт соёлжилтын танхим нь хугацаат цэргийн албан хаагчдын амралтын өрөөтэй адил тохижуулагдсан.

**Сонсогчийн байр:**

- 2 тасагтай, тасаг тус бүрт 15 байлдагч амьдардаг, тохижилтын хувьд хугацаат цэргийн албан хаагчдын амьдрах байртай адил тохижуулагдсан.

Эдгээр байрууд чийг ихтэй, хана, таазнаас нуралт өгч эхэлсэн, халаалт муу, засвар хийх шаардлагатай болсон байна.

Халуун ус, угаалгын байр нь тааз нуралттай, нилэнхүүдээ мөөгөнцөртэй байгаа тул их засвар хийх шаардлагатай болсон байна.

Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн захирагч хурандаа Б.Цагаан 2006 оны 8 сараас тус ангийн захирагчийн ажлыг хүлээн авч ажиллан, ангийн бие бүрэлдэхүүн болох 140 офицер, ахлагч, 86 хуучин цэрэг, 150 шинэ цэрэг, гэрээт цэрэг 20, БХИС-ийн дадлагын 31 сонсогч цэрэг, 80 гаруй энгийн ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Тус анги 1967 он байгуулагдсан, Зэвсэгт хүчний артиллерийн тусгай хорооны анги юм.

Ангийн захирагчийн танилцуулгаар Хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөлийг 2006 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр байгуулан, нийт 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа тодорхой төлөвлөгөөний дагуу явуулж байгаа сайшаалтай байлаа. Тус ангийн 61 байгууламжаас урсгал засварыг 12, бүрэн засварыг 1 байгууламжид хийсэн байна. /Танилцуулгыг хавсаргав/

**Хугацаат цэргийн байр:**

- 2006 оны 2 дугаар ээлжээр цэрэгт татагдсан цэргүүдийг дээд, доод давхруудад хувиарлан, давхар тус бүр нь 2 тасгаас бүрдсэн, цэргүүд хуарангийн байдлаар амьдардаг, тасгийн хэмжээ 72 м кв, 1 тасагт 35 байлдагч амьдардаг, өрөөний тохижилтыг 12 тумбочка, хувцасны өлгүүр, 22 сандал байхаар тохижуулсан.

- Эдгээр давхарт 45 м кв бүхий соёлжилт амралтын өрөөг 2 жижиг ширээ, 1 шкаф, 2 кресло, 1 диван, 1 зурагт, DVD тоглуулагч, номын тавиур, мөн хөгжим, шатар, даамтай байхаар тохижуулсан байна.
- Хуучин цэргийн байр 3 тасагтай, /1 тасагт 22 байлдагч амьдардаг/ соёлжилт амралтын танхимтай тохижилтын хувьд дээрхтэй адил байна.
- Хугацаат цэргийн албан хаагчид хуарангийн байдлаар /давхарласан ортой/ амьдардаг. Дээрх цэргийн байрууд нь гэрэлтүүлэг муутай, коридорын үндсэн гэрэл асдаг, тасгуудын гэрлүүд асдаггүй байна. Коридоруудад зурагт байрлуулсан байна.

**Гэрээт цэргийн байр:**

Гэрээт цэргүүдийн амьдрах ахуй нөхцөл орчинг хангалттай бүрдүүлсэн байна. Гэрээт цэргүүдийн байр 3 тасагтай, тасаг тус бүрд 5-6 цэргийн албан хаагчид амьдардаг байна. Тус байр нь амралт соёлжилтын танхим, хичээлийн танхим, цайны өрөө, ахуй үйлчилгээний өрөө, угаалгын өрөөнүүдтэй байна.

**Харуулын цэргүүдийн байр:**

Тус байр нь 3 тасагтай, тасаг бүрд 10 цэргийн албан хаагч амьдардаг амьдрах орчин нөхцөл боломжийн байлаа.

**Сонсогчийн байр:**

- Ойролцоогоор 50 м кв өрөөнд нийт 31 сонсогч амьдардаг, тэдгээр цэргийн албан хаагчид их давчуу, багтаж зайгүй, өрөөнд өдрийн 1 ширхэг гэрэлтэй, гэрэлтүүлэг муу, агааржуулалт муу, чийгшилт ихтэй нөхцөлд амьдарч байна.

1.2 Цэргийн албан хаагчдын ариун цэвэр, эрүүл ахуйн хэрэгслийн хангамжийг санал асуулга авч, уулзаж ярилцан, газар дээр нь шалгаж дүгнэсэн.

326 дугаар ангийн хувьд өдөр тутмын хэргэцээнд зориулж цэргийн албан хаагч тус бүрд сард:

- Оо 1 ширхэг,
- Алчуур 1 ширхэг, / хагас жилд/
- Сойз 1 ширхэг, / улиралд олгох/
- Нүүр гарын саван 1 ширхэг,
- Гутлын тос 1 ширхэг,
- Усанд орох саванг нь 7 хоногт 1 удаа усанд ороход нь тусд нь өгдөг,
- Барааны саванг хувцас угаахад тусд нь олгодог байна.

Ор дэрний даавуу, дотуур хувцасыг Цэргийн албаныг зохион байгуулах зааврын нийтийн болон хувийн ариун цэврийн талаарх заалтын дагуу цэргийн албан хаагч 7 хоногт 1 удаа сольж угаалгад шилжүүлнэ гэсэн ба энэ заалт нь мөрдөгддөггүй болох

нь дараахь байдлаас харагдаж байна. Нийтийн угаалгын газарт ор дэрний даавуу, нүүр гарын алчуураа 14 хоногт 1 удаа угаалгад өгдөг гэж ярьж байлаа.

00 цаасыг хангалтаар авдаггүй, хангалтаар ирж буй гутлын тос чанарын шаардлага хангадаггүй зэргийг үндэслэн цэргийн албан хаагчдын саналыг авч, тэдгээрийн цалин дээрээс нь үнийг нь суутгаж 00 цаас авч өгдөг, гутлыг цёткыг цэргийн албан хаагчдын гэрээс нь авчруулдаг тухай ангийн удирдлага тайлбарлаж байлаа.

120 дугаар анги өдөр тутмын хэрэгцээнд зориулж цэргийн албан хаагч тус бүрд сард:

- Оо 1 ширхэг,
- Алчуур 1 ширхэг, / хагас жилд/
- Сойз 1 ширхэг, / улиралд олгох/
- Нүүр гарын саван 1 ширхэг,
- 00 цаас 1 ширхэг
- Гутлын тос 1 ширхэг,.
- Усанд орох саванг нь 7 хоногт 1 удаа усанд ороход нь тусд нь өгдөг,
- Барааны саванг хувцас угаахад тусд нь олгодог байна.

Дээрх цэргийн ангиуд цэргийн албан хаагчдын гаргасан саналыг нь үндэслэн тэдгээрийн цалин дээрээс 1300₮ тапочка авч өгсөн, үлдсэн мөнгийг нь цээж зурагны мөнгөнд суутгасан, одоогоор цалигаасаа гар дээр мөнгө аваагүй тухай цэргүүд ярьж байлаа.

Сонгинохайрхан цэргийн хүрээний цэргийн ангиуд нь сахилгын хорих байргүй, сахилгын шийтгэлийн тусгаарлан саатуулах шийтгэлийн хэлбэрийг оногдуулсан тохиолдолд ЗХЖШ-ын 032 дугаар ангийн Улаанбаатар цэргийн хүрээний ёс журам сахиулах ангийн сахилгын хорих байранд саатуулдаг байна. Сахилгын шийтгэлийн хоногтоо тусгаарлан саатуулах шийтгэлийн хэлбэрийг оногдуулахаа больсон хэмээн тус ангиудын удирдлагууд мэдэгдэж байлаа. Улаанбаатар цэргийн хүрээний ёс журам сахиулах ангийн 2006 оны сахилгын хорих байранд хоногтоо саатуулагдсан цэргийн албан хаагчдын 2006 оны мэдээнээс үзэхэд ЗХЖШ-ын 120 дугаар ангиас 2 цэргийн албан хаагчид дээрх шийтгэлийг хүлээсэн байна. Тус ангийн байлдагч А.Ганзоригт цэргийн төв эмнэлэгт хэвтэж байхдаа байгууллагын дотоод журам зөрчсөн гэсэн үндэслэлээр 3 хоногийн тусгаарлан саатуулах сахилгын шийтгэлийн хэлбэрийг оногдуулсан байна. Харин нөгөө цэргийн албан хаагч нь хэний хэн, ямар үндэслэлээр шийтгэл оногдуулсан тухай мэдээллийг 032 дугаар ангийн цэрэг

цагдаагийн бүлгийн сахилгын хорих байрны саатуулагчдын хуудастай танилцахад байхгүй байсан.

120 дугаар анги нь эргэлт уулзалтын байргүй, цэргүүдийн эргэлт уулзалтыг шалган нэвтрүүлэх байрандаа хүлээн авч уулзуулдаг байна.

Харин 326 дугаар анги нь 12.5 м кв бүхий эргэлт уулзалтын өрөөтэй, өрөө нь 1 ширээ, 1 урт сандалтай, гэрэлтүүлэггүй, цементэн шалтай, халаалтгүй, хагархай цонхтой, ер нь ашиглагддаггүй байна гэж дүгнэж байна. Иймд дээрх өрөөг ашиглалтанд оруулах талаар тус ангийн удирдлага анхааралдаа авах хэрэгтэй байна. 326, 120 дугаар ангиудын бие засах газар гадаа байрладаг, ариун цэврийг хангалттай сахидаггүй, дахин жорлон гаргах, эсвэл цэвэрлэгээг сайн хийх, халтиргаагүй болгох ажлыг тогтмол сайн хийж байх нь зүйтэй байна.

032 дугаар ангийн амьдрах байрны нөхцөлтэй танилцаагүй болно. Тус ангийн захирагч Г.Энхбаатарын танилцуулгаар анги 1924 онд байгуулагдсан. Төрийн болон цэргийн ёслол хүндэтгэлийн үүрэг, БХЯ, ЗХЖШ-ын харуул хамгаалалт, шалган нэвтрүүлэх үүргийг гүйцэтгэдэг. Улаанбаатар цэргийн хүрээний ёс журам сахиулах, цэргийн цагдаагийн үүрэг /хоногтоо тусгаарлан саатуулах, баривчлах ялыг эдлүүлэх/ гүйцэтгэдэг. Ангийн нийт бие бүрэлдэхүүн 200 гаруй хугацаат цэргийн албан хаагчид, 60 гаруй офицер, ахлагч, 30 гаруй энгийн ажилтантай байна. Тус ангид хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөлийг байгуулсан ч одоогоор хийгдсэн тодорхой ажил байхгүй тухай танилцуулсан.

Улаанбаатар цэргийн хүрээний ёс журам сахиулах ангийн 2006 оны сахилгын хорих байранд хоногтоо саатуулагдсан цэргийн албан хаагчдын мэдээнээс үзэхэд: 032 дугаар ангиас 26 цэргийн албан хаагчид сахилгын шийтгэлийн хоногтоо тусгаарлан саатуулах шийтгэлийн хэлбэрийг хүлээсэн байна. Үүнээс сахилгын шийтгэлийн хоногтоо тусгаарлан саатуулах хэлбэрийг хүлээлгэсэн үндэслэлийг судлан үзэхэд: оргосон, архи уусан, ажлаас шантарч цэргүүдийг уруу татсан, харьцааны зөрчил гаргасан, зүү залгисан, чөлөөгүй явсан зэрэг үндэслэлүүд байна. Энэ шийтгэлийн хэлбэрийг ихэнх тохиолдолд байлдагчид хүлээж байжээ.

Мөн тус ангийн байлдагч Т.Эрдэнэбат, Э.Оюунболд, Т.Анхболд Э.Золбаяр нар тус бүр 2 удаа хоногтоо тусгаарлан саатуулагдах сахилгын шийтгэлийн хэлбэрийг 10 хоног хүртэл хугацаагаар хүлээж байжээ. Тус ангийн хоногтоо тусгаарлан саатуулах сахилгын шийтгэлийн хэлбэрийг 3, 5, 7, 10 хүртэл хоногийн хугацаатайгаар оногдуулдаг байна. Ангийн цэрэг цагдаагийн бүлэг нь сахилгын хорих байранд саатуулагдсан цэргийн албан хаагчдын бүртгэлийг хөтөлдөггүй, саатуулагсдын нэрсийн жагсаалтыг зөвхөн улирал, хагас жил, жилээр мэдээ гаргаж өгөхдөө цол,



овог нэр, /зарим цэргийн албан хаагчдын овог нэр бүтэн бичигдээгүй байх/ анги, ямар өрөөнд саатуулагдсан тухай тэмдэглэдэг, буюу 032 дугаар ангиас саатуулагдсан цэргийн албан хаагчдын бүртгэлийг огт мэдээндээ оруулдаггүй байна. Саатуулагсдыг хүлээн авах хуудсыг судлан үзэж танилцахад ямар үндэслэлээр саатуулагдаж буйг бичдэггүй, зөвхөн тэр даргын шийдвэр, энэ даргын шийдвэрээр сахилгын шийтгэл оногдуулсан гэсэн бүрхэгдүү байдлаар хуудсанд тэмдэглэгээ хийж ажлаа явуулдаг байна. Дээр дурьдагдсан 4 байлдагчийн сахилгын шийтгэл оногдуулсан үндэслэлтэй танилцах гэтэл бичигдээгүй байлаа. Тухайн үед зөвхөн тус ангиас саатуулагдаж байсан байлдагч Б.Пүрэвдоржийн тушаалтай танилцсан болно. /Тушаалыг хавсаргав/

Ерөнхийдөө тус ангийн байдлаар цэргүүдэд хоногтоо саатуулах сахилгын шийтгэл хүлээлгэх хэлбэрийн үндэслэл болж буй тохиолдлууд нь оргох буюу чөлөөгүй явах тохиолдлууд байна. Иймд оргоход нөлөөлж буй гол шалтгаан нөхцлийг судлан үзэж, үүнийг таслан зогсоохын тулд тодорхой арга хэмжээ авах нь зүйтэй байна.

**Сахилгын байрны хувьд:**

Улаанбаатар цэргийн хүрээний ёс журам сахиулах анги буюу ЗХЖШ-ын 032 дугаар ангийн сахилгын хорих байранд ЗХЖШ, ДЦ, ХЦ ангиудаас сахилгын шийтгэлийн хоногтоо тусгаарлан саатуулах шийтгэлийн хэлбэрийг хүлээсэн цэргийн албан хаагчид саатуулагддаг, мөн баривчлах ялтай цэргийн жинхэнэ албан хаагчид тус ангийн сахилгын хорих байранд ганцаарчлан ялыг эдэлдэг байна. /ЭХ-ийн 51.4 дүгээр зүйл/ Тус сахилгын хорих байр нь нийт 11 камертай байна. /үүнээс 1 хүний 6 камер, 2 хүний 5 камер/ Хорих байр нь 1984 онд ашиглалтанд орсон, 2004 онд урсгал засвар хийгдсэн, нэг хүний камерийн өрөө 2,4 м кв, наарны хэмжээ нь 140\*80 см, хоёр хүний камерийн өрөө 16,5 м кв наарны хэмжээ 140\*60 см байна. Эдгээр өрөөнүүд нь хүйтэн, чийгшилттэй байлаа. Шалгалтын үед 2 байлдагч, 1 сонсогч нэг бүрийн хорих өрөөнд хоногтоо тусгаарлан саатуулагдаж байсан.

Тус сахилгын хорих байранд хоногтоо тусгаарлан саатуулагдаж байгаа БХИС-ын 4 дүгээр курсын сонсогч Т.Тэгшбаяр, 032 дугаар ангийн байлдагч Б.Пүрэвдоржоос тайлбар авч, зарим асуудлыг тодруулав. Тэдгээр цэргийн албан хаагчдыг өглөөний ангийн нэгтгэлд оруулдаг, өдөрт 2 удаа, заримдаа 1 удаа хооллож, крантны түүхий ус ууж, өдөрт салхилуулдаггүй, орой унтахад шинель, ор хөнжлийн даавуу өгдөггүй зөвхөн нааран дээрээ унтдаг, их хүйтэн даарч хонодог, унших ном, хууль дүрэм өгдөггүй тухай тэмдэглэн хэлсэн. /ЗХЖШ-ын харуулын ротын 029 дүгээр ангийн оргосон цэргүүдийг удирдан зохион байгуулсан 3 байлдагчаас тайлбар авахад мөн

дээрхтэй адил тайлбар өгч байсан/ Тус ангийн цэрэг цагдаагийн бүлгийн жижүүр, дарга нараас саатуулагчдыг хэдэн удаа салхилуулдаг, камерууд их хүйтэн байгаа үед ор хөнжлийн давуу, шинель өгдөг эсэх талаар асууж лавлахад: өдөрт 3 удаа салхилуулж, орой унтахад нь ор хөнжлийн давууг нь өгдөг гэсэн тайлбарыг хийсэн.

## **2. Хоол хүнс, хувцасны хангалт**

**2.1.** Цэргийн албаныг зохион байгуулах зааварт цэргийн гал тогоо нь хооллох бүрэлдэхүүний тооноос хамаарч тодорхой хэмжээний зай багтаамж бүхий ажлын байр, өрөөтэй байна гэж заажээ. Үүнээс үзэхэд :

326 дугаар анги нь халуун хоол боловсруулах өрөө, мах бэлтгэх өрөө, ногоо бэлтгэх өрөө, хүнс хуурай хэрэглэл хадгалах өрөө, сав хэрэглэл угаах, хатаах хадгалах өрөөнүүдтэй, 1 ахлах тогооч, 4 ээлжийн тогооч, 4 бэлтгэгч, 3 сав угаагч гэсэн орон тооны ажилчидтай, талх барих цех нь тусдаа талх хадгалах, тавьж олгох өрөө, талх барих өрөөтэй, 3 ажилтан ээлжээр ажилладаг байна.

Ахлах тогоочийн буюу гал тогоонд ажиллагчдын бэлтгэл, сургалтын өрөө, гал тогооны жижүүр, ээлжийн тогооч, бэлтгэгч нарын өрөө, хувцас хэрэглэл хадгалах өрөөнүүдтэй, эдгээр өрөөнүүдээс халуун хоол боловсруулах өрөө нь чийгшилт ихтэй, мөөгөнцөртэй байлаа. Тус ангийн барилга нь 1976 онд ашиглалтанд орсон, жижиг урсгал засваруудыг бага багаар хийдэг тухай ярисан.

Хоолны заал нь 300 м кв талбайтай, 300 орчим хүн нэг дор хооллох багтаамжтай, ширээ сандлын хүрэлцээ, хоолны ширээ засахад ширээн дээр тавигдах зүйлүүд /хувин, данхны тавиур, давс, перецны сав, давхарлан тавьсан таваг, хувингийн халбага, цайны аяга, халбага, цөцгийн тос, элсэн чихэртэй сав, хоол цайны үлдэгдэл хийх сав гэх мэт/ хангалтгүй, 2 ээлжээр цэргийн албан хаагчдыг хооллодог байна. Хооллох заалны нэг хана доошоо суулт өгсөн, энэ нь хэдийд ч нурж магадгүй байгаа тул Мэргэжлийн хяналтын газраас дүгнэлт гаргуулах шаардлагатай байна. Мөн тус заалны гэрэлтүүлэг, дулаан хангалтгүй байв.

Цэргийн албан хаагчдад өдөрт 1 хүнд:

- Мах 420 г
- Гурил 100 г
- Талх 600 г
- Цагаан будаа 60 г
- Бусад будаа 40 г
- Элсэн чихэр 70 г
- Гоймон 40г
- Төмс 500 г

- Байцаа 100 г
- Манжин 20 г
- Лууван 40 г
- Варенье 30 г
- Ургамалын тос 10 г
- Өөхөн тос 25 г
- Цөцгийн тос 30 г
- Цай 4 г
- Давс 25 г
- Сонгино 30 г-аар бодож хоолыг нэр төрөл, өтгөн шингэний байдал, амт чанар, илчлэг хуваарилалт, хүрэлцээ зэргийг харгалзан үзэж, хоолны нэр төрлийг давхардуулахгүйгээр 7 хоногоор хоолны хуваарь гарган мөрддөг байна.

Хоолны норм бүх ангиудад адилхан ЗГ-ын тогтоолоор хангалтыг ЗХЖШ-ын 310 дугаар ангиас хийдэг байна. Ангиудын хангалтаар ирэх ёстой амтлагчууд гэх мэт зүйл нь хангалттай ирдэггүйг тус ангиудын удирдлагууд, цэргүүдээс авсан санал асуулга, уулзалт ярианаас тэмдэглэгдэж байна.

Санал асуулгын хуудсаар 206 цэргийн албан хаагчдаас судалгаа авч дүгнэхэд өлсдөг гэж 10, заримдаа өлсдөг гэж 46, өлсдөггүй гэж 150 цэргүүд хариулсан байна. Харин хоолны амт чанарын талаарх санал асуулгад хоол хүнсний чанарын байдлыг сайн гэж 135, дунд гэж 59, муу гэж 12 цэрэг хариулсан байна.

Хоолны хүрэлцээ, амт чанарын талаар цэргүүдийн өгсөн санал асуулгад хоол хүнсний нөхцөл байдал дунд, муу гэж нийт санал асуулга өгсөн цэргүүдийн 35 хувь нь үзжээ. Зарим ярилцлага, санал асуулгын хуудсанд бичигдсэн санал анхаарлыг татаж байна. Тухайлбал: зарим цэрэг санал асуулгын хуудсанд хөц будаа угаагддаггүй, хоолны амт чанар муу, хоолондоо цаддаггүй, талх түүхий байдаг, давс амтлагч багатай, байцаа хөлдүү, хоолны өтгөн шингэний байдал муу, усан шөл, шингэн хоол хийдэг, талхыг хар гурилаар хийдэг гашуун байдаг, хоол заримдаа их муухай амттай, орц хэмжээндээ хүрдэггүй, хоолны давс заримдаа их, заримдаа бага байдаг, гэдэс дотроор их хоол хийдэг, 1 ширээнд 8 хүн суухад хоол нь аягалж хүрдэггүй, маш их ам цангадаг, цай их уумаар байдаг, мах өөх тосгүй байна.

Эдгээр тэмдэглэл, ярилцлагаас үзвэл хоол хүнсэнд хэрэглэж байгаа махан бүтээгдэхүүний чанар, нэр төрөл төдийлөн сайн биш байдаг байна гэсэн дүгнэлтийг хийж болохоор байна. Иймд цэргүүдийн хоол хүнсэнд хэрэглэж байгаа хүнсний бүтээгдэхүүний чанар, нэр төрөлд анхаарах хэрэгтэй болох нь харагдаж байна.

Тус ангийн хувьд хүнсний складууд ангилалтгүй, хүнс хуурай хэрэглэл хадгалалтын складанд цувдайгаа хамт хадгалсан, махны зоорьгүйгээс сав хэрэглэл хадгалах складандаа махаа шалан дээр хураасан зэрэг байдлууд ажиглагдаж байв.

120 ангийн хувьд халуун хоол боловсруулах өрөө, хуурай хэрэглэл хадгалах өрөө, гурил бэлтгэх өрөө, ногоо бэлтгэх өрөө, мах бэлтгэх өрөө, сав хэрэглэл угаах, хадгалах өрөө, гал тогооны жижүүр, ээлжийн тогооч, бэлтгэгч нарын өрөө, хувцас хэрэглэл хадгалах хувцас солих өрөөнүүдтэй, 1 ахлах тогооч, 3 ээлжийн тогооч, 2 бэлтгэгч, 3 угаагч, 1 үйлчлэгч ажилладаг, талхан цех нь тусдаа 2 ажилтантай байна.

Тус ангийн хувьд махны зоорийг үзэхэд: үхэр, хонь ямааны гулууз мах, цувдайг ангилж хадгалсан, ногооны зоорины төмс, луувангийн хадгалалтын явцад стандартын дагуу байнгын ангилалтыг хийдэг, хүнс хуурай хэрэглэл хадгалалтын складны ангилалт, хадгалалтыг сайн гэж дүгнэхээр байна.

Санал асуулгын хуудсаар 246 цэргийн албан хаагчдаас судалгаа авч дүгнэхэд өлсдөг гэж 6, заримдаа өлсдөг гэж 72, өлсдөггүй гэж 168 цэргүүд хариулсан байна. Харин хоолны амт чанарын талаарх санал асуулгад хоол хүнсний чанарын байдлыг сайн гэж 114, дунд гэж 111, муу гэж 21 цэрэг хариулсан байна.

Хоолны хүрэлцээ, амт чанарын талаар цэргүүдийн өгсөн санал асуулгад хоол хүнсний нөхцөл байдал дунд, муу гэж нийт санал асуулга өгсөн цэргүүдийн 53,6 хувь нь үзжээ. Зарим ярилцлага, санал асуулгын хуудсанд бичигдсэн санал анхаарлыг татаж байна. Тухайлбал: Орц хэмжээндээ хүрч хуваарилагддаггүй, амт шим муутай, илчлэг багатай, хоол нь заримдаа дутуу болгосон байдаг, байцааны усан шөл байнга өгдөг, талх түүхий байдаг, гэдсээр шөл хийдэг тэр нь шивтэр, баастай байдаг, хоолноос гялгар уут, хадаас, элдэв янзын зүйл байнга гардаг, өглөө оройны хоолыг маш бага порцоор өгдөг, өдөр дарга нар байдаг болохоор гайгүй орц хэмжээндээ байдаг.

Эдгээр тэмдэглэл, ярилцлагаас үзвэл хоол хүнсэнд хэрэглэж байгаа махан бүтээгдэхүүний чанар, нэр төрөл төдийлөн сайн биш байдаг байна гэсэн дүгнэлтийг хийж болохоор байна. Иймд цэргүүдийн хоол хүнсэнд хэрэглэж байгаа хүнсний бүтээгдэхүүний чанар нэр төрөлд анхаарах, хоолны ариун цэврийг сайн сахих, эрүүл ахуй талаас нь эмчийн хяналтыг сайжруулах арга хэмжээг авах хэрэгтэй байна.

032 дугаар ангийн хувьд халуун хоол боловсруулах өрөө болон бусад өрөөнүүдэд урсгал засвар болон их засварыг хийх хэрэгтэй байлаа.

Санал асуулгын хуудсаар 141 цэргийн албан хаагчдаас судалгаа авч дүгнэхэд өлсдөг гэж 1, заримдаа өлсдөг гэж 13, өлсдөггүй гэж 127 цэргүүд хариулсан байна.

Харин хоолны амт чанарын талаархи санал асуулгад хоол хүнсний чанарын байдлыг сайн гэж 129, дунд гэж 9, муу гэж 3 цэрэг хариулсан байна.

Хоолны хүрэлцээ, амт чанарын талаар цэргүүдийн өгсөн санал асуулгад хоол хүнсний нөхцөл байдал дунд, муу гэж нийт санал асуулга өгсөн цэргүүдийн 9,3 хувь нь үзжээ. Санал асуулгын хуудсанд бичигдсэн хоол хүнсний чанарын дутагдлын талаар тухайлбал: талх түүхий, хоол нь маш муу, хоол нь бага байдаг, гэдэс цувдайгаар хоол их хийдэг, хоолноос нь янз янзын юм гардаг, хоолны ариун цэвэр муу гэсэн хариултыг өгчээ. Иймд цэргүүдийн хоол хүнсэнд хэрэглэж байгаа хүнсний бүтээгдэхүүний чанар нэр төрөлд анхаарах, хоолны ариун цэврийг сайн сахих, эрүүл ахуй талаас нь эмчийн хяналтыг сайжруулах арга хэмжээг авах хэрэгтэй байна.

**2.2** Хувцасны хангалтыг өвөл, зуны улиралд жилд хоёр удаа тавьж олгодог байна. 326 дугаар ангийн санал асуулгын дүнгээс үзэхэд гутал, хувцасны хангалтын талаар бүгд 206 цэрэг санал асуулгад хамрагдсанаас хувцасны хангалт сайн 176, дунд 27, муу 3 гэсэн байна. Харин хувцасны хангалтын талаар дутагдалтай зүйл байна уу? гэсэн асуултанд: гутал муу цан их татдаг, өвлийн гутал хэрэгтэй байна, хөл өглөө оройд гадаа зогсохоор их даардаг, хөлийн жийрэг бага, эдэлгээ муутай амархан урагддаг, одоо урагдсан, оймс өмсөөр байна, хүзүүний ороолт хэрэгтэй байна, гутлын тос өгдөггүй, бүс бас муу байна, бидний дотуур хувцас угаагддаггүй, ирснээр одоо болтол угаагаагүй, 14 хоногт нэг угааж болохгүй юм уу, хөлийн жийрэг ээлжийн байж болдоггүй юм уу, гутлын улавч бас ээлжийн баймаар байна, гутал их чийг татдаг, чанарын шаардлага хангахгүй байна гэсэн хариултын өгчээ. Үүнээс үзэхэд: 326 ангийн байрлаж байгаа газар Улаанбаатар хотоос 10 хэмээр илүү хүйтэн байдаг, хятад бакал нь эдэлгээ муу, амархан элэгддэг, гадаа зогсоход их дааруулдаг, улавчгүй, ороолт нь хангалттай биш, /1 цэрэгт нормд нь 1,60 см ороолт олгодог/ улавчгүй байдгаас халагдсан цэргүүдийн хувцаснаас хөлийн улавч хийж цэргүүдэд өгдөг гэдгийг ярилцлагын явцад бүх цэргүүд, ангийн удирдлага тайлбарласан.

Тус ангийн эмнэлэгт хэвтэж байгаа байлдагч С.Чулуунбаатар нь бакалнаасаа хөлөө холгуулаад идээлж шархлуулан эмчилгээ хийлгэж байгаа, мөн байлдагч С.Дашбаяр нь гадаа бэлтгэл хийж, удаан зогссоноос бакал нь хөлийг нь хайрснаас ангийн эмнэлэгт хэвтэж эмчлүүлж байгаа тухай уулзалт ярилцлага, эмнэлэгт хэвтэгсдийн бүртгэлээс үзэж танилцлаа. Иймд ЗХЖШ-ын хувцасны хангалтыг нийлүүлэхдээ чанарын шаардлага хангасан гутлыг нийлүүлэх шаардлагатай байна.

120 ангийн санал асуулгад хамрагдсан 246 цэргийн албан хаагчдаас гутал хувцасны хангалтын байдалд сайн 202, дунд 39, муу 5 гэж үзсэн байна. Харин хувцасны хангалтын талаар дутагдалтай зүйл байна уу гэсэн асуултанд: Гутал муу

жинддэг, их даардаг, хөлний ороолт жижигхэн, чанар муутай амархан цоордог, гутлын ул хугацаагаа даахгүй элэгддэг, малгай жижигхэн толгой барьж, чих даардаг, бүс бас муу байна, эсгий улавч, оймс тавьж, хөлний ороолтыг 2 ээлжийн болгох, мөн дотуур труски хэрэгтэй байна, гутлын хувьд хавар намар өмсдөг гутал өмсдөг тул дулаахан өвлийн гуталтай болмоор байна, хятад бакалыг өөрчилж болдоггүй юм уу, их дааруулдаг, хөл их хайрдаг гадаа удаан зогсоход хэцүү байдаг, цалингаас табочка, авсан, бусад мөнгө нь зураг авахуулсны суутгалд төлөгдсөн гэсэн хариултыг өгсөн байна.

032 дугаар ангийн санал асуулгад хамрагдсан 141 цэргийн албан хаагчдаас гутал хувцасны хангалтын байдалд сайн 136, дунд 5 гэж үзсэн байна. Харин хувцасны хангалтын талаар дутагдалтай зүйл байна уу гэсэн асуултанд: Гутал амархан элэгддэг ер нь бол 6 сар болж чаддаггүй, гутлын тах хэрэгтэй байна. Их даардаг, жинддэг, улавч хэрэгтэй байна, хөлийн жийргэвч их муу, амархан урагддаг, бид цалингаасаа оймс авч өмссөн, ээлжийн баймаар байна, мөн 00 цаасыг цалингаас авдаг, хангалтаар өгч болдоггүй юм уу, гэсэн хариултыг өгчээ.

032 дугаар ангийн хувьд хүндэт харуулын үүргийг гүйцэтгэдэг онцлог үүрэгтэй учраас тус ангид алба хааж байгаа цэргийн албан хаагчдад ёслолын хувцсыг олгодог байна. Энэ хувцсыг цэргүүдийн дунд дамжуулан хэрэглүүлэх тохиолдлууд их гардаг, мөн хүн эмнэлгийн бүртгэлд бүртгэгдсэн арьс өнгөний өвчнүүдийн нэг эх үүсвэр байх магадлалтай тул хүндэт харуулын хувцсыг тодорхой хугацаанд ариутгал хими цэвэрлэгээнд оруулах ажлын хийх нь зүйтэй гэж үзэж байна.

### **3. Соёл хүмүүжлийн арга хэмжээ**

ЗХЖШ-ын 326, 120, 032 дугаар ангиудад Монголын залуучуудын холбооноос хэрэгжүүлж буй бичиг үсэг сургах төслийн хүрээнд дээрх ангиудаас нилээдгүй цэргүүд хамрагдаж байна. Мөн 326 дугаар ангийн цэргийн албан хаагчдыг жолооны курст сургах, жолооч болгох зэрэг арга хэмжээг авч байна.

326 дугаар анги нь биеийн тамирын спорт заалгүй, гадаа задгай талбайд биеийн тамирын талбайтай, түүнд зуны цагт хичээллэх болоцоотой, бие бялдаржуулах, чийрэгжүүлэх танхимтай боловч тэр нь цэргийн албаныг зохион байгуулах зааварт заасны дагуу тодорхой хэрэгслүүдгүй учраас хичээллэх орчин нөхцөл бүрдээгүйг цэргийн албан хаагчдаас авсан санал асуулгад тэмдэглэгдсэн бөгөөд ажиглалтын явцад харагдаж байлаа.

Соёл хүмүүжлийн ажил зохион байгуулагддаг эсэх талаар санал асуулгын хуудсанд хамрагдсан 206 цэргийн албан хаагчдын 163 нь зохиогддог, 12 нь зохиогддоггүй, 31 нь заримдаа зохиогддог гэж үзжээ. Хүсэн хүлээсэн ямар ажлыг

зохиох хэрэгтэй вэ? гэдэг асуултанд тухайлбал: Спортын төрлийн тэмцээн уралдаан /сагс, волейбол, теннис, биллиард гэх мэт/ зохиох, соёл хүмүүжлийн ажлыг сайн зохион байгуулах хэрэгтэй байна, 3 жил сурсан зүйлээрээ уралдаж өөрсдийхөө чадварыг мэдэх, гадаад улс орнуудын мэдээлэл хийж байх, хот орж үзэх хоттой танилцмаар байна, хотын цэргийн тодотголтой музей үзэх, номын санд суумаар байна, оюун ухаан сорьсон бодлого тоглоом тоглох, концерт, дуу, бүжиг үзэх, мэргэжил олгох төлбөртэй сургалтанд хамрагдмаар байна, хамаагүй мөнгийг нь төлж болно, гитар хөгжим хэрэгтэй байна, цэргүүдийн дунд дуу бүжиг, хөгжмийн дугуйлан хичээллүүлж болох уу, тойрон аялал хийж болох уу, 7 хоногт 1 удаа ч гэсэн ямар нэг арга хэмжээ зохиомоор байна. Соёл хүмүүжлийн ажил зохиогддог ч нэх сонирхолтой биш байдаг гэсэн хариултыг өгчээ. Мөн чөлөөт цагаа хэрхэн өнгөрүүлдэг тухай асуухад: чөлөөт цаг гардаггүй, байнга бэлтгэл сургуулилт, жагсаалын бэлтгэл хийдэг, зөв боловсон амралтыг хүсэж байна, амралтын бус байдалд чөлөөт цагаа муу өнгөрүүлдэг, хувийн ариун цэвэр сахих, сонин хачин ярих, шатар даам тоглох, тэгс ингэс гээд яахав дээ л өнгөрөөдөг, гүйж өнгөрөөдөг, шалаа зүлгээд цэвэрлээд өнгөрөөдөг, шагай тоглодог, Соёл хүмүүжлийн танхимд телевизор нь жижиг муу гардаг, VSD-гээр кино үздэг, чөлөөт цаггүй, ихэнхдээ цэвэрлэгээ хийдэг. Спортын заал байхгүй, янз бүрийн спортын /штанк, турник гэх мэт/ хэрэгслүүд байхгүй, спортоор хичээллэх орчин бүрдээгүй байна, чийрэгжүүлэх өрөөндөө оруулдаггүй, бие бялдраа хөгжүүлэх цаг зав гарахгүй байна, ерөнхийдөө хичээллэх орчинг нөхцлийг бүрдүүлэх шаардлагатай байна гэсэн хүсэлтийг тавьсан байна.

120 дугаар анги нь биеийн тамирын спорт заалтай, заал нь хүйтэн, ангийн удирдлага сагсан бөмбөг, гар бөмбөгийн хамгийн сайн чанартайг нь авч хэрэглүүлж байгааг танилцуулсан. Соёл хүмүүжлийн ажил зохион байгуулагддаг эсэх талаар санал асуулгын хуудсанд хамрагдсан 246 цэргийн албан хаагчдын 211 нь зохиогддог, 2 нь зохиогддоггүй, 33 нь заримдаа зохиогддог гэж үзжээ. Хүсэн хүлээсэн ямар ажлыг зохиох хэрэгтэй вэ? гэдэг асуултанд тухайлбал: Бие бялдар хөгжүүлэх орчин нөхцлийг бий болгох, янз бүрийн сургалтууд болон соёл хүмүүжлийн сонирхолтой ажлуудыг зохиох, бусад цэргийн сургуулиудтай шефийн холбоотой хамтарч ажиллах, оюун ухаан сорьсон тэмцээн уралдаан зохиомоор байна, номын сан гэж байдаг гэсэн гэхдээ нээгдэхгүй байна, хот орж үзмээр байна, дийлэнх нь хөдөөний цэргүүд байна, хоттой танилцаж, музей үзмээр байна, бэлтгэл хийх заал хүйтэн, биеийн тамирын хувцас байдаггүй, гэрээсээ авчруулж болох уу, байранд спортын хэрэгслүүдгүй, бидний амьдарч буй орчин нөхцөл муу, биеийн тамираар хичээллэх сонирхол их байдаг ч хичээллэж чаддаггүй, бие бялдаржуулах танхим байхгүй,

техник хэрэгслүүд ч байдаггүй гэж хариулжээ. Чөлөөт цагаа хэрхэн өнгөрүүлдэг талаар асуухад: зурагт үзэх, хөгжим сонсох, унтаж амрах, сонин унших, ажил хийх, шал зүлгэх байдлаар өнгөрөөдөг, заримдаа амрах цаг гардаггүй тухай тэмдэглэжээ.

036 дугаар ангийн хувьд спортын заалтай, зааланд тоглох цаг зав гардаггүй, байнгын бэлтгэл сургуулилттай, маш их ядардаг, чөлөөт цаг бага байдгаа илэрхийлж байсан.

#### 4. Эмнэлэгийн үйлчилгээ

326 дугаар ангийн эмнэлэг албан ёсны орон тооны оргүй боловч ангийн зүгээс гаргасан 8 ортой, 2 тасагтай, физик эмчилгээний өрөөтэй 1 их эмч, 1 бага эмч, ээлжийн 4 сувилагч, 1 асрагчтайгаар ангийн нийт бие бүрэлдэхүүнд үйлчилдэг.

120 дугаар ангиийн эмнэлэг албан ёсны орон тооны оргүй боловч ангийн зүгээс гаргасан 6 ортой, 2 тасагтай, физик эмчилгээний өрөөтэй 2 их эмч, 1 бага эмч, ээлжийн 4 сувилагч, 1 асрагчтайгаар ангийн нийт бие бүрэлдэхүүнд үйлчилдэг.

032 дугаар ангиийн эмнэлэг албан ёсны орон тооны оргүй боловч ангийн зүгээс гаргасан 6 ортой, 2 тасагтай, физик эмчилгээний өрөөтэй 1 их эмч, 4 бага эмч, 1 эмийн санчийн орон тоотойгоор ангийн нийт бие бүрэлдэхүүнд үйлчилдэг.

Дээрх ангиудын хүн эмнэлэг жилийн 2 сая ₮ төсөвтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг байна.

326, 120 дугаар ангиудын эмнэлгийн “Ангийн эмнэлэгт хэвтэгсдийн жагсаалт”, “Гадуур эмнэлэгт хэвтэгсдийн журнал”, “Эм томилгооны жагсаалт” хэмээх бүртгэлийн дэвтэрүүдтэй танилцахад бүртгэл нь хангалтгүй хөтлөгдөж байна. Тухайлбал: үйлчлүүлэгчийн овог нэр бүтэн бүртгэгдээгүй, өвчний шалтгаан тэмдэглэгдээгүй зөвхөн онош тавигдсан, бүртгэлүүдтэй нэг бүрчлэн танилцахад ихэнх нь гэмтэл бэртэлтэй холбоотой бүртгэл байлаа.

Эдгээр нь дүрмийн бус харьцаанаас үүдэлтэй байж болзошгүй хэмээн үзэж, эмч нараас юунаас үүдсэн гэмтэл бэртэл болохыг нь асууж лавлахад мэдэхгүй, мартсан гэсэн хариултыг өгч байсан нь анхаарал татаж байв. Жишээ нь: 326 дугаар ангийн Госпитальд шилжүүлсэн 4 байлдагчийн өвчний түүх, онош, шалтгаан бичигдээгүй, эм олголтын бүртгэлд онош нь бичигдээгүй байхад эм олголтыг хийсэн гэх мэт байна. Мөн ангийн хэмжээнд үлд, түүхий, хатиг гарсан тохиолдол нилээдгүй байна. Энэ асуудал юунаас болж гарч байгааг лавлахад үсний машин, цэргүүд малгайгаа сольж өмснөөс болж байгаа гэж үзэж байна.

Тус ангид 4 цэрэг варикоцельтэй байна. Үүнийг асууж тодруулахад цэрэг татлагаар ирсэн гэсэн тайлбар өгч байна. Мөн эмнэлэгт хэвтэж эмчлүүлж буй 8 цэргүүдээс 5 цэрэг нь хатиг, түүхий гарснаас эмнэлэгт эмчлүүлж байлаа. Тус ангийн цэргийн



албан хаагчдад худагны ус уух явдал түгээмэл байна. Иймд энэ түүхий ус уух явдлыг таслан зогсоох арга хэмжээг авах нь зүйтэй байна.

032 дугаар ангийн эмнэлэг нь осол, гэмтлийн протокол хөтөлдөг, эмчийн хариуцлага сайн байгаа нь бусад ангиудад үлгэр дууриалал болохоор байлаа.

Дээрх ангиудын эмнэлэгээр үйлчлүүлэгсдийн дунд хатиг, үлд, түүхий зэрэг арьс өнгөний өвчин, БЗХӨ, мөн бөөр, ходоод буюу хоол боловсруулах эрхтний өвчин түгээмэл байна.

Эмийн сангийн хувь анги тус бүрээс яаралтай эмийн сан болон эмийн сангаас хугацаа дууссан эм гарсан ба энэ нь тухай ангиудад хангалт хийдэг ЗХЖШ-ын 310 дугаар ангийн хангалттай холбоотой байна.

326 дугаар ангийн эмийн санд:

- Диарекс 1 хайрцаг, 2006 оны 12 дугаар сар,
- Феназенам 2 хайрцаг, 2006 оны 4 дүгээр сар,
- Кордамин, 1 хайрцаг, 2006 оны 12 дугаар сар,
- Фуросемит 1 хайрцаг, 2006 оны 11 дүгээр сар,
- Мөн бичиг үсэг нь арилсан юунд хэрэглэх нь мэдэгдэхгүй, устгалд оруулаагүй 11 ампул тариа яаралтай эмнэлгийн хайрцагт байна.

120 дугаар ангийн эмийн санд:

- Фуросемит 1 хайрцаг, 2006 оны 2 дугаар сар, /яаралтай эмийн сан/
- Дибазол 5 мл, 1 ампул 2005 оны 2 дугаар сар, /яаралтай эмийн сан/
- Дибазол 5 мл, 1 ампул 2004 оны 7 дугаар сар, /яаралтай эмийн сан/
- Ношпа 1 амп., 2006 оны 9 дүгээр сар, /яаралтай эмийн сан/
- Аналгин 3 амп., 2006 оны 2 дугаар сар, /яаралтай эмийн сан/
- Мазь окасилиновая 0.25% 1 ширхэг, 2005 оны 12 дугаар сар,
- Гризософульвина 1 хайрцаг, 2006 оны 3 дугаар сар,
- Мазь преднизалонная 2 хайрцаг, 2005 оны 11 дүгээр сар,
- Нисинаг 1 хайрцаг, 2006 оны 5 дугаар сар,
- Токофарм 2 хайрцаг, 2006 оны 7 дугаар сар,
- Викасол 1 хайрцаг, 2006 оны 11 дүгээр сар
- Викасол 1 хайрцаг, 2006 оны 3 дугаар сар
- Викасол 1 хайрцаг, 2006 оны 8 дугаар сар
- Глюкоза 10 мл 1 амп, 2005 оны 10 дугаар сар,
- Глюкоза 10 мл 1 амп, 2004 оны 12 дугаар сар,

032 дугаар ангийн эмийн сантай эм зүйч нь эзгүй тул танилцаж чадаагүй, яаралтай эмийн сангаас:

- Сульфацин- натрия 2005 оны 10 дугаар сар,
- Дибазол 5 мл 3 амп., 2006 оны 9 дүгээр сар,
- Кофейн 1 мл 7 амп., 2005 оны 9 дүгээр сар,

032 дугаар ангийн эмнэлгийн бүртгэлтэй танилцаж байхад жагсаалын бэлтгэл сургуулалт хийж байхдаа санамсаргүй байдлаар бууны жадны үзүүрээр нүд, уруул уруугаа хатгуулсан тохиолддууд байна.

- 2006 оны 7 дугаар сарын 20-ны өдөр байлдагч Б.Пүрэвдоо нь жагсаалын бэлтгэл хийж байгаад байлдагч Түвшинбаярын бууны жадны үзүүрт санамсаргүй хатгуулсан. Баруун нүдний дээд доод зовхи орчим шархтай, нүдний алим уруу нэвтэрсэн, нүдний зураглагч бүрхэвч гэмтсэн, нүднээс нулимс гарна.
- 2006 оны 8 дугаар сарын 1-ны өдөр байлдагч Б.Шижирбаатар нь жагсаалын бэлтгэл хийж байгаад байлдагч Батбаярын бууны жадны үзүүрт санамсаргүй хатгуулсан. Баруун уруулын дээд хэсэгт 0,3 см орчим шархтай, цус алдсан.
- 2006 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр байлдагч О.Алтангэрэл нь жагсаалын бэлтгэл хийж байгаад зүүн нүдэндээ бууны жадны үзүүрээр хатгуулсан. Нүд бүрэлзэж, юм хоёр болж харагдах болсон.

## 5. Дүрмийн бус харьцаа

Цэргийн удирдах албан тушаалтан, офицерууд удирдлагадаа байгаа цэргийн албан хаагчдад хүч хэрэглэх, дарамтлах дүрмийн бус харьцаагаар харьцах нь цэргийн байгууллага дахь хүний эрхийн хамгийн ноцтой зөрчил гэж үздэг тул ийм харьцаа байгаа эсэхийг тодруулах зорилгоор цэргийн албан хаагч, байлдагч нараас санал асуулга авах, ярилцлага хийх, эмнэлгийн баримт бичигтэй танилцах зэрэг ажил зохион байгуулав.

326 дугаар ангид шалгалтаар очих үед байлдагч А.Алтанхуяг нь салаан дарга ахлагч Батбаяраар чихээ мушгиулаад, чих нь устаж хавдсан, 20 хоноход 2 удаа чихнийх нь усыг авсан, өөр ямар нэг эмнэлгийн тусламж үзүүлээгүй байлаа. Энэ байдлыг тус ангийн удирдлагад танилцуулж, авсан арга хэмжээнийхээ талаар албан бичгээр танилцуулахыг шаардсан болно.

Дүрмийн бус харьцааны зөрчлийг хэний зүгээс гаргаж байгааг судалж үзэхэд: ийм харьцааг офицеруудын зүгээс гаргадаг гэж 118, ахлагч нарын зүгээс гаргадаг гэж 113, түрүүч нарын зүгээс гаргадаг гэж 239, байлдагч нарын зүгээс гаргадаг гэж 77 байлдагчид, ялгавартай ханддаг гэж 93, айлган сүрдүүлж дарамталдаг гэж 76, мөнгө эд зүйл шаарддаг гэж 92, зодож хүч хэрэглэдэг гэж 77, үг хэлээр доромжилдог гэж 90, дүрмийн бус шийтгэл хүлээлгэдэг гэж 73, өөр бусдаар зодуулдаг гэж 64 байлдагч тус тус хариулсан нь дүрмийн бус харьцааны ямар хэлбэрүүд ихэвчлэн гардгийг харуулж байна.

Тус ангийн 2006 оны 1 дүгээр ээлжийн 60 цэргүүдийн санал асуулгаас үзэхэд нийт 25 цэрэг зодуулсан бөгөөд тэдэнтэй зүй бусаар харьцдаг гэдгийг үгүйсгээгүй, 2 дугаар ээлжийн 122 цэргүүдээс 55 цэрэг мөн адил зодуулдаг, зүй бус харьцдаг гэдгийг санал асуулгын хуудсанд бичсэн байна. Үүнээс гадна тус ангийн гэрээт цэргүүд, түрүүч нар бас зодуулдаг, дарамтлуулдаг зүй бус харьцдаг гэдгийг тэмдэглэсэн байна. Санал асуулгын хуудсаар та бүхэнтэй удирдах албан тушаалтнуудын зүгээс өөрт чинь хүч хэрэглэсэн, дарамталсан, зүй бус харьцсан ноцтой тохиолдол байгаа бол энэ талаар дэлгэрэнгүй бичнэ үү? гэсэн асуултанд: “дэд ахлагч Көвтелүү /энэ хүний тухай дийлэнх цэргүүд санал асуулгын хуудсанд бичсэн/ дарамталдаг, зоддог, харьцааны соёлгүй, түрүүч нар зоддог, энэ асуугаад байгаа асуудал чинь маш нууц явагддаг учраас бид бичиж чадахгүй байна, өргөдөл гомдол гаргах боломжтой гэх боловч боломжгүй байдаг, учир нь захидал бичээд дээш өгөх гэхээр офицер ахлагч нар задалж, уншаад өгдөггүй дамжуулдаггүй, ахлагч нар зодож дарамтлаад, дүрмийн бус шийтгэл хүлээлгэдэг, эргэлт уулзалт ирэхээр түрүүч нар бүх юмыг нэгжээд хурааж авдаг, ангийн эмнэлгийн үйлчилгээ муу, гар хардаг, шүд өвдөөд үзүүлэхэд эмчилж өгөхгүй, тариа байхгүй гээд эмч нар нь гар хардаг, үүнд их гомдолтой байна, эмнэлэгт нь мэргэжлийн эмч байлгаж болдоггүй юм уу, ерөнхий эмч нь эмнэлэгт очоод үзүүлэхээр юу ч мэдэхгүй юм, түрүүч, ахлагч офицер нар бүгд тийм дээрэнгүй харьцаатай, зарим ахлагч, офицер нарын дээрэнгүй занг болиулмаар байна, бид ард байхдаа эрх чөлөөтэй иргэн байсан, одоо бол шоронд байгаа юм шиг санагддаг, бид тангараг өргөсөн цэргийн албан хаагч болохоос биш ял хийсэн ялтан биш, бид бол хүн ялтан биш биз дээ, яагаад шоронд байгаа юм шиг байх ёстой юм вэ, түрүүч нар бүгд тийм харьцаатай, тэднийг халмаар байна, маш хэцүү байна, дарамт шахалт ихтэй, офицерүүд хал цэргүүдээр биднийг зодуулдаг” гэдгийг тэмдэглэсэн байна.

120 дугаар ангийн эмнэлгийн бүртгэлийн дэвтэртэй танилцахад 2006 оны байдлаар тус ангид зөөлөн эдийн гэмтэл бэртлийг хөл, гарандаа авсан 17 цэргийн албан хаагч байгаа бөгөөд тэдгээрийг бүртгэлд тодорхой бичээгүй байна.

Мөн цэргийн төв Госпитальд 2006 оны 8 дугаар сард ахлах дэслэгч Алтантөгсд зодуулснаас болж тус ангийн байлдагч А.Цогтгэрэл, М.Батбаяр, А.Ганзориг Э.Энхбаяр, А.Мягмарсүрэн, Г.Энхбаатар, Б.Ариунмөрөн, Ч.Мөнхбаяр нар хэвтэж эмчлүүлж байжээ.

120 дугаар ангид 2006 оны 8 дугаар сараас хойш /ангийн удирдлагууд солигдсон/ ямар нэгэн байдлаар бэртэл гэмтэл авсан цэргийн албан хаагчдын тоо эрс буурч, мөн байлдагч А.Цогтгэрэл нь удаа дараа /3 удаа/ зөөлөн эдийн бэртэл

гэмтэл авч байсан нь тус ангид дүрмийн бус харьцаа байна хэмээн үзэн, ангийн удирдлага энэ асуудлыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч, тодорхой ажлууд зохиож, тэмцэж буй тухайгаа танилцуулсан.

Гэсэн хэдий ч цэргийн албан хаагчдаас авсан санал асуулгын дүнгээр нийт 243 байлдагч хамрагдагсдын 40 гаруй хувь нь цэргийн байгууллагад ийм харьцаа ямар нэгэн хэмжээгээр байдаг гэдгийг хүлээн зөвшөөрсөн байгаа нь дүрмийн бусаар харьцах зөрчил бага бус байгааг харуулж байна.

Ийм зөрчлийг хэний зүгээс гаргаж байгааг судалж үзэхэд давхардсан тоогоор ийм харьцааг офицеруудын зүгээс гаргадаг гэж 76, ахлагч нарын зүгээс гаргадаг гэж 111, түрүүч нарын зүгээс гаргадаг гэж 139, байлдагч нарын зүгээс гаргадаг гэж 81 байлдагчид, ялгавартай ханддаг гэж 62, айлган сүрдүүлж дарамталдаг гэж 58, мөнгө эд зүйл шаарддаг гэж 54, зодож хүч хэрэглэдэг гэж 52, үг хэлээр доромжилдог гэж 95, дүрмийн бус шийтгэл хүлээлгэдэг гэж 45, өөр бусдаар зодуулдаг гэж 41 байлдагч тус тус хариулсан нь дүрмийн бус харьцааны ямар хэлбэрүүд ихэвчлэн гардгийг харуулж байна.

Санал асуулгын хуудсаар та бүхэнтэй удирдах албан тушаалтнуудын зүгээс өөрт чинь хүч хэрэглэсэн, дарамталсан, зүй бус харьцсан ноцтой тохиолдол байгаа бол энэ талаар дэлгэрэнгүй бичнэ үү? гэсэн асуултанд: өвчтэй зовиуртай байхад түрүүч нар тоохгүй эмнэлэгт үзүүлж арга хэмжээ авдаггүй, түрүүч нарыг байлгамааргүй байна, бид нараас салаан дарга тангараг өргөх баяраар хүн бүрээс 200₮ авсан, түүгээрээ архи уусан сураг байсан. Уг нь бидэнд зориулна гэж авсан мөнгө байгаа юм ахиад 3000₮ авна гэсэн. Салаан дарга Ө.Ариунбаяр, жагсаалын дарга Батхүү /гэрээт цэрэг/ жагсаалын дарга нар эргэлт уулзалт ирэхээр архи нэхдэг, Хойд байлдааны холимог Амарзаяа, дэд түрүүч Ган-Эрдэнэ нар их дарамт шахалт ихтэй мөн адил байдаг. /Сонсогчийн цэргүүдээс/ Бид бүгдээс мөнгө авдаг, харин чөлөөгөөр явахад салаан дарга надад архины оронд мөнгө авчир, юу авч ирэхээ ч өөрөө мэд гэдэг, салаан дарга нар чөлөөгөөр явахад их гар хардаг, орой болгон дүрмийн бус шийтгэл хүлээлгэдэг /ялаа алуулах/, жагсаалын даргад зүгээр байж байгаад алгадуулмааргүй байна, бид нараас салаан дарга тангарагийн баяраар хүн бүрээс 3000 төгрөг аваад архи уусан гэсэн, уул нь тэр мөнгийг бидэнд зориулна гэж авсан мөнгө л дөө, ахиад 3000 төгрөг авна гэж байна лээ. Жагсаалын дарга эргэлт уулзалт ирсэн эсвэл чөлөөгөөр явахад надад юу авчрах билээ гээд заавал архи авхуулдаг. Үүнийг болиулмаар байна. Биднийг шууд захирах дарга нартай уулзаж ярилцах гэхээр уулзуулдаггүй, Номын санд сууя гэхээр суулгадаггүй шууд урдаас загнадаг гэж тэмдэглэсэн байна.

032 дугаар ангийн эмнэлгийн бүртгэлтэй танилцахад 2006 онд дүрмийн бус харьцаанаас үүдсэн гэмтэл бэртэл авсан тохиолдлууд нэлээдгүй байна.

- 2006 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр Байлдагч Г.Ганбаатар нь зүүн талын хавирганы нум орчмоор хүндүүрлэн өвдөн, 8,9 дүгээр хавирга суганы орчим хаван хавдартай гэсэн оноштой.
- 2006 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр Байлдагч Г.Азбаяр нуруугаар хөшиж өвдөнө, хөдөлж болохгүй, нуруу улайсан, 2 бөөр орчим хөхөрсөн, дэд түрүүч Энхтөр 2 хоногийн өмнө сандлаар цохисон.
- 2006 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр байлдагч М.Бат-Эрдэнэ чих уруугаа түрүүчээр цохиулсан. Хатгаж өвдөнө, шингэн зүйл гарч байгаа, эмзэглэлтэй гэсэн оноштой.
- 2006 оны 11 дүгээр сарын 29-ны өдөр байлдагч Д.Давгадэмбэрэл байлдагч Даваадоржтой зодолдож нүдэндээ цохиулсан.
- 2006 оны 1 дүгээр сарын 6-ны өдөр байлдагч Г.Аюурзана зүүн нүдэндээ цохиулсан. Хавдартай, хөхөрсөн, эмзэглэлтэй оноштой.
- 2006 оны 1 дүгээр сарын 2-ны өдөр Ч.Мөнхбаатар түрүүч Эрдэнэбатад 2 удаа өшиглүүлснээс ар нуруу ууцаар, мөн хөл дагаж өвдөнө, цээж өвдөн зэрэг эмзэглэлтэй.
- 2006 оны 1 дүгээр сарын 11-ны өдөр байлдагч Т.Эрдэнэ хамар нь гэмтэлтэй, цохиулсан.
- 2006 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр байлдагч С.Нэргүй 2 нүд хөмсөгний хооронд хавдсан. Хамрын хэлбэр алдагдсан, хамрын хянга зулгарсан. Байлдагч Ч.Тулга баруун гарын тохой хавдсан, байлдагч Ш.Аваансүрэн толгой өвдөнө, баруун хөл доголоно, зүүн гарын 1,2 дугаар хурууны хооронд хавдсан, байлдагч Ц.Ууганбаяр баруун хөлийн тавхай, шагайн орчмоор хаван хавдартай эмзэглэлтэй гэсэн оноштой. Дэд түрүүч Бат-Өлзий, ахлах байлдагч Батхүү, байлдагч Батзориг, байлдагч Энхтогтох нарт зодуулсан.
- 2006 оны 2 дугаар сарын 18-ны өдөр байлдагч Л.Гансүх нь скаладны харуулд гарч байхдаа доошоо буухдаа төмсгөө нидэрсэн.Төмсөг нь хавдсан хөхөрсөн гэсэн оноштой, Үүнийг цохиулсан гэж үзэх үндэстэй байна.
- 2006 оны 12 дугаар сарын 14-ны өдөр байлдагч Г.Санчир түрүүч Баттулгад чих уруугаа алгадуулж, зүүн чихний хэнгэрэг нь цоорч, чихнээс цустай шингэн зүйл гардаг болсон.
- 2006 оны 5 дугаар сарын 10-ны өдөр байлдагч Л.Гансүх хүзүү уруугаа цохиулснаас хойш толгой эргэнэ, цээж хөхөрч шарласан, хүзүү зүүн тийш хазайхад эмзэглэлтэй.
- 2006 оны 1 дүгээр сарын 11-ны өдөр байлдагч Хүрэлбаатар нь зүүн нүдний дээд, доод зовхи нь хөхөрсөн эмзэглэлтэй. Цохиулсан гэж үзэх үндэслэлтэй байна.

/ эмнэлгийн өвчтөнүүдийн түүхээс 032 дугаар

032 дугаар ангийн санал асуулгаар дүрмийн бус харьцааны зөрчлийг хэний зүгээс гаргаж байгааг судалж үзэхэд давхардсан тоогоор ийм харьцааг офицеруудын зүгээс гаргадаг гэж 7, ахлагч нарын зүгээс гаргадаг гэж 7, түрүүч нарын зүгээс гаргадаг гэж 43, байлдагч нарын зүгээс гаргадаг гэж 29 байлдагчид, ялгавартай ханддаг гэж 10, айлган сүрдүүлж дарамталдаг гэж 13, мөнгө эд зүйл шаарддаг гэж 25, зодож хүч хэрэглэдэг гэж 13, үг хэлээр доромжилдог гэж 13, дүрмийн бус шийтгэл хүлээлгэдэг гэж 15, өөр бусдаар зодуулдаг гэж 13 байлдагч тус тус хариулсан нь дүрмийн бус харьцааны ямар хэлбэрүүд ихэвчлэн гардгийг харуулж байна.

Санал асуулгын хуудсаар та бүхэнтэй удирдах албан тушаалтнуудын зүгээс өөрт чинь хүч хэрэглэсэн, дарамталсан, зүй бус харьцсан ноцтой тохиолдол байгаа бол энэ талаар дэлгэрэнгүй бичнэ үү? гэсэн асуултанд: ахлах дэслэгч Батмөнх, түрүүч нар зоддог, гэмтээдэг, хэл амаар доромжлодог. Түрүүч нар мөн адил мөнгө их нэхдэг, зоддог, чөлөөний хуудас зардаг энэ асуудлыг арилгаж өгөөч. Тус ангийн дэгийн асуудлыг шийдэж өгч болох уу, ХХТР-ын дэд түрүүч Гансүх, Энхтөр,

Амармэнд байнга зоддог. ХХТР-ын а/д Батмөнх чөлөөний хуудас зардаг, мөнгө нэхдэг, ялгаварлан гадуурхадаг гэж хариулсан байна.

#### **6. Албадан хөдөлмөр**

326 дугаар ангийн санал асуулгаар цэргийн албан хаагчдаас ар гэртээ болон танил талынхаа ажлыг хийлгэдэг эсэх талаар санал асуулгад хамрагдсан нийт 206 байлдагчдаас 56 буюу 27.1 хувь нь ийм ажил хийлгэдэг гэдгийг тэмдэглэсэн байна. Ямар төрлийн ажил хийлгэдэг талаар асуухад: Офицер ахлагч нар хувийнхаа ажлыг хийлгэдэг, хувцас хунар хайрлаж, хамгаалахгүй ажиллуулдаг, барилгын ажил шавар шохойны ажил зэрэг бүх л барилгын хүнд ажлуудыг хийлгэдэг, ойр зуурын гэрийн ажил хийлгүүлдэг, түлээ, мод хагалуулах, зөөлгөх, ус зөөх, өөрсдийнхөө хийж чадахгүй ажлаа биднээр хийлгэдэг гэдгийг тэмдэглэжээ. Тус ангид ажил хийж байгаад ямар гэмтэл авсан тухай тодруулахад: Хааяа гэмтэл авдаг, хөлний яс цуурсан гэхдээ тоогоогүй ээ, яс хугарч байсан гэсэн хариултыг өгсөн. 326 дугаар ангийн байлдагч Э.Мөнхбат нь 2006 оны 9 дүгээр сард ангийн ногоог хурааж байхдаа чиргүүлийн гарыг хөл дээрээ унагаж, алдаад хөлийн хуруугаа тайруулсан. Одоогийн байдлаар түүний хөл маш их даардаг, ялангуяа өглөө, оройдоо бүр их даардаг, ангийн байрлаж буй газар их хүйтэн, бакал нь хөлийг нь их хайрч, дааруулдаг тухай өгүүлж байсан.

120 дугаар ангийн санал асуулгын хуудсаар цэргийн албан хаагчдаас ар гэртээ болон танил талынхаа ажлыг хийлгэдэг эсэх талаар санал асуулгад хамрагдсан нийт 246 байлдагчдаас 218 буюу 88.6 хувь нь ийм ажил хийлгэдэг гэдгийг үгүйсгээгүй байна. Хэрэв ажил хийлгэдэг бол ямар төрлийн ажил хийлгэдэг вэ гэсэн асуултанд: Гэрийн ажил хийлгэдэг, ус түлээ зөөлгөх, зэрэг бага сага ажил хийлгэдэг, хааяа юм зөөлгөх ажил хийлгэдэг, мөн ямарч хамаагүй ажлаа байнга хийлгэдэг, хар ажил, газар шорооны ажил хийлгэдэг, гол төлөв ус их зөөдөг, офицер, ахлагч нарын гэрийн хашаа хороог цэвэрлэж, ус зөөх, түлээ хагалах ажлыг нь хийдэг, өөрсдийн хувийн бүх ажлаа хийлгэдэг гэж хариулсан байна. Тус ангид ажил хийж байгаад гэмтэл авсан тохиолдол байна уу? гэсэн асуултанд: ГХХ-ын үүрэг гүйцэтгэж яваад хавирга цөмөрсөн тухайгаа тэмдэглэсэн байна.

032 дугаар ангийн санал асуулгын хуудсаар цэргийн албан хаагчдаас ар гэртээ болон танил талынхаа ажлыг хийлгэдэг эсэх талаар 141 байлдагчдаас 96 буюу 68.0 хувь нь ийм ажил хийлгэдэг гэдгийг үгүйсгээгүй байна. Ямар төрлийн ажил хийлгэдэг талаар асуухад: Хар ажил хийлгэж, гуйвраар янз бүрийн ажил хийлгэдэг, газар шорооны ажил, айл нүүлгэх, нүх ухах, дарга нарын гуйлтаар ар гэрийн ажлыг нүүлгэх суулгах, барилгын ажил, муу гэсэн бүх ажлыг хийлгэдэг, жорлон ухуулдаг,

барилга шохойны ажил, хийлгэдэг, яахав заримдаа гуйвраар хөнгөн ажил хийлгэж байдаг гэж хариулжээ.

Түүнчлэн тус ангийн эмнэлгийн бүртгэлтэй танилцахад барилга дээр ажиллаж байгаад гэмтэл бэртэл авч байсан цэргүүд цөөнгүй байна.

- 2006 оны 10 дугаар сарын 25-ны өдөр байлдагч Ч.Энхтайван дэд хурандаа Лхагвасүрэнгийн гуйлтаар барилга дээр ажиллаж байгаад шат нь нурж унасан. *Rallialis* цуурсан.
  - 2006 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр байлдагч Ш.Түвшинбаяр нь Толгойтод далангийн бетон завсар хавчуулагддаг мод хөрөөдөж байгаад баруун баруун өвдөгний дээд талд 7 см хэмжээтэй гүн 2 см хөрөөдсөн.
  - 2006 оны 9 дүгээр сарын 14-ны өдөр Б.Ууганбаяр гал тогооны тааз замасгдаж байгаад давхарлаж тавьсан ширээн дээрээс толгойгоороо унасан.
  - 2006 оны 9 дүгээр сарын 14-ны өдөр байлдагч Лутбаяр нь ажил хийж байгаад целийтний машинд хуруугаа авсан. Баруун гарын 3 дугаар хурууны 1 дүгээр үе хугаралттай.
  - 2006 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр байлдагч Ч.Батлхагва нь барилгын ажил хийж байгаад далангаас унасан. Баруун 7,8 дугаар хавирга, далин голын хавирга, зүүн гарын бугуйн үе эмзэглэлтэй, баруун бугуйны дотор тал хөхөрсөн.
  - 2006 оны 7 дугаар сарын 1-ны өдөр байлдагч Билгүүн барилгын ажил хийж байгаад баруун гар дээрээ банз унагасан.
  - 2006 оны 6 дугаар сарын 3-ны өдөр Тавантолгойд марш тактикийн бэлтгэл хийж байхад троссон дээр явж байсан 14 цэрэг гэнэт тросс тасарснаас унаж гэмтэл авсан. Госпитальд хэвтэж эмчлүүлсэн.
  - 2006 оны 10 дугаар сарын 14-ны өдөр байлдагч Ш.Ганхүү будгийн лааз задалж байгаад 2 гараа зүссэн. 4 оёдол тавиулсан.
  - 2006 оны 10 дугаар сарын 8-ны өдөр байлдагч Б.Үйтүмэн нь "Мон-трейд"ХХК-ны барилгын муу усны сувгийг газар ухаж байгаад, нуранги шороонд цээж хүртэл дарагдсан. Бүсэлхийнээс доош эмзэглэлтэй, явж чадахгүй, зүүн нүдний дээд, доод зовхи хөхөрч шарласан, зүүн чих шалбарч тав тогтсон.
- /Хүн эмнэлгийн өвчөний түүхээс 032 дугаар анги/*

Дээрх тохиолдлуудаас үзэхэд ЗХЖШ-ын цэргийн ангиудад цэргийн албан хаагчдаар албадан хөдөлмөр эрхлүүлэх асуудал газар авсан байна гэсэн дүгнэлтэнд хүргэж байна.

## 7. Бусад

Тус Комисст хандаж хэлэх зүйл байгаа эсэх талаар санал асуулгаар 326 дугаар ангийн цэргийн албан хаагчид: Бидний бичсэн бүхнийг номонд нь оруулж өгнө үү, үүнийг л хүсэж байна, бид бүх үнэнийг бичлээ, цэргүүдийн дотор оны ялгаа маш их байдгийг арилгаж өгнө үү, эргэлт уулзалтын цаг 30 минут үүнийг нэг цаг болгож болох уу, бидний дотор нуугдаж байгаа бүхнийг бичүүлж, сэтгэлийг минь хуваалцаж байгаа нь сайхан байна, сэтгэл сайхан онгойж байна, та бүхэн бидний саналыг нэг нэгээр нь авч болох уу, их юм яримаар байна. Цэргийн ангийг үнэн зөв шудрага ажлуулж өгнө үү, энэ санал асуулгаар дээрх дутагдлыг арилгаж чадах уу, эргэлтийн хугацааг сунгаж өгнө үү, олон улсад захиа явуулдаг болмоор байна, хугацаат цэргийн албан хаагчдад түр цагийн чөлөө олгодоггүй,үүнд гомдолтой байна, тодорхой арга хэмжээ авбал зохино, гэр лүүгээ ярьдаг утастай болмоор байна, хүний эрхийн зөрчил маш их байна, үүнийг таслан зогсоож өгнө үү, та бүхэн биднээс тус тусад нь

бүсчлэн уулзаж болох уу, тэгвэл бид маш их юм яримаар байна, хүний эрхийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авмаар байна, чөлөөг 7 хоногт 3 цэргээр байлгаж болох уу, бидний эрх маш их зөрчигдөж байгаа тул таслан зогсоож өгнө үү, мэргэжилтэй болох хүсэлтэй, үнэ хөлсийг нь өгөөд ч хамаагүй сургалтанд хамрагдмаар байна, ангид бид хүний эрхэнд чөлөөтэй биш, нэг л газраа зогссон бол зогссон, суусан бол суусан чигээрээ байдаг, тэр нь хэцүү юм аа, бидний эрх их зөрчигддөг, таслан зогсоож өгнө үү, ийм санал асуулгыг сард 1 удаа авч байна уу, гэсэн хүсэлтийг тавьсан байна.

120 дугаар ангийн санал асуулгад хамрагдсан цэргийн албан хаагчид тус Комисст хандсан хүсэлтэндээ: Эмнэлгийн ажилтнуудын харьцаа муу, их уцаартай, Байлдагч Дүүрэнжаргал миний нүд муу санаа тавьж болох уу, хөдөө орон нутгийн цэргүүдэд урт хугацааны чөлөө олгох 48 цаг, хөдөөнөөс ирсэн цэргүүд хоттой танилцах хүсэл ихтэй, сардаа биш юмаа гэхэд улиралдаа нэг үзвэр, урлагийн юм үзэх сонирхолтой, хугацаат цэргийн албыг 6 сар болгох, арын амьдралдаа санаа зовдог, гэрээ ганц тэжээдэг байсан хүүхдүүд их байдаг, та бүхэнтэй ганцаарчилж уулзаж болох уу, хуучин хувцастайгаа халагдах хүсэлтэй, ер бүх хангалтыг бүрэн тавиулмаар байна, гэрээт цэргүүдийг их дээд сургуульд суралцуулах боломж хэр байдаг вэ, мөн гадагшаа үүрэг гүйцэтгүүлэх боломж байдаг уу, сонсогчийн цэргүүд доод оны гэсэн дарамтаас гаргаж өгнө үү, цалингаа өгөхгүй байгаа тухай илэрхийлжээ.

032 дугаар ангийн санал асуулгад хамрагдсан цэргийн албан хаагчид тус Комисст хандсан хүсэлтэндээ: Уулзалтын хугацааг уртасгах 30 минут байдаг ядаж 1 цаг байж болохгүй юу, хөдөө орон нутгаас ирж байгаа ээж аавтайгаа удаан уулзаж чаддаггүй, уулзалтын хугацааг сунгаж өгөөч, хол газрын цэргүүдэд урт чөлөө өгөх 48 цагийн чөлөө байж болох уу, та бүхэн ирж бидний санал хүсэлтийн байнга авч байна уу гэсэн хүсэлтийг гаргасан байна.

**8. Хөдөлмөрийн гэрээгээр ажилладаг энгийн ажилчдын эрхийн хэрэгжилт**  
ЗХЖШ-ын 326 дугаар ангийн санал асуулгад хамрагдсан хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй 19 ажилтнаас хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтийн байдлын талаар нь ярилцлага хийж, санал асуулга авч дүнг нэгтгэхэд дараахь нөхцөл байдал тодорхойлогдов.

Санал асуулгад оролцсон 19 хүний 79 хувь нь эмэгтэй, 21 хувь нь эрэгтэй бөгөөд насны хувьд 10.6 хувь нь 20-30 насны, 42.1 хувь нь 30-45 насны, 47.3 хувь нь 45-60 насны ажилчид байв.



Санал асуулгын хуудаснаас харахад тус ангид ажилчдын эрх ашгийг төлөөлсөн үйлдвэрчний байгууллага байдаггүй, хамтын гэрээ хэлэлцээр, хамтын гэрээний талаар ойлголт байхгүй байна.

Харин санал асуулгад оролцогсод бүгд хөдөлмөрийн гэрээ байгуулж, гэрээний нэг хувьтай танилцдаг боловч хувь нь өөрт олгогддоггүй тухай тэмдэглэжээ. Хөдөлмөрийн гэрээтэй холбоотой санал гомдлоос харахад санал асуулгад оролцогсдын дийлэнх нь гэрээнд заасан хугацаанаас илүү цагаар, тушаалын дагуу, ажлын ачаалал их болохоор илүү цагаар ажиллуулдаг гэсэн байна.

Цалин хөлсний олголтын хувьд хэвийн боловч ажлын үр дүнгийн нэмэгдэл хөлс заримдаа олгогдоод заримдаа олгогддоггүй, илүү цагаар ажилласны нэмэгдэл хөлс дутуу бодогддог, долоо хоногийн амралтын өдөр ажилласны нэмэгдэл хөлс олгогддоггүй, мөн бусад төрлийн нэмэгдэл хөлс тогтмол олгодоггүй тухай тэмдэглэжээ. Ялангуяа хөдөлмөрийн нөхцлийн нэмэгдэл, мэргэжлийн зэргийн нэмэгдэл олгогддоггүй бөгөөд энэ талаар ямар нэг ойлголтгүй, мэдэхгүй гэдгээ илэрхийлжээ. Ажилчид ээлжийн амралтаа цаг тухайд нь эдэлж, ажлын байрны хэвийн нөхцөлд ажилладаг байна.

Хөдөлмөрийн нөхцөл, ажил үүрэгт тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах, хөдөлмөрийн хэвийн бус орчинд ажилладаг ажилтанд хор саармагжуулах бодис, хүнсний бүтээгдэхүүн олгох ажил хангалтгүй байна. Харин эрүүл мэндийн үзлэгт жилд 2 удаа оруулдаг, хөдөлмөр хамгааллын зааварчилгаа, ажлын байран дээрх сургалт зохион байгуулдаг гэжээ.

Жирэмсэн эмэгтэй, 8 хүртэлх насны хүүхэдтэй ганц бие эх, ганц бие эцгийг өөрөө зөвшөөрөөгүй тохиолдолд шөнийн буюу илүү цагаар, түүнчлэн албан томилолтоор ажиллуулдаг, жирийн ажлын өдөр нялх хүүхэдтэй эх, ганц бие эцэгт хүүхэд асрах нэмэлт чөлөө олгодоггүй гэж санал асуулгад оролцогсдын дийлэнх нь хариулсан байна.

Мөн сахилгын шийтгэл оногдуулдаг тогтолцоо хууль болон гэрээнд зааснаас өөр байдаг. Жишээ нь: Жагсаж нэгдээгүй тохиолдолд цалингаас хувиар суутгадаг. Цалингаас хувь хүнээс асуулгүй ямар нэг татвар авах, шууд суутгах тохиолдол байдаг байна.

Тус ангид хөдөлмөрийн маргаан таслах комисс байдаггүй, танай байгууллагад хөдөлмөрийн хамтын маргаан гарч байсан уу? гэсэн асуултад бүгд үгүй гэж хариулсан ба гарч байсан хөдөлмөрийн маргааныг хэрхэн шийдвэрлэдэг вэ? гэсэн асуултад хөдөлмөрийн маргаан гаргах боломжгүй, ажил олгогчтой маргавал гадуурхан шууд хална, солино, зайлаарай гэж хэлдгийг тэмдэглэжээ.

Санал асуулгад оролцогсдын дийлэнх нь сануулах, цалин хасах, ажлаас халах хэлбэрийн сахилгын шийтгэлийг оногдуулдаг гэсэн байна.

120 дугаар ангийн санал асуулгад оролцсон 15 ажилчдын 10 нь эмэгтэй, 5 эрэгтэй бөгөөд насны хувьд дийлэнх нь 30-45 настай байлаа.

Санал асуулгын хуудаснаас харахад тус ангид ажилчдын эрх ашгийг төлөөлсөн үйлдвэрчний байгууллага байдаггүй, хамтын гэрээ хэлэлцээр, хамтын гэрээний талаар ойлголт байхгүй байна.

Харин санал асуулгад оролцогсод бүгд хөдөлмөрийн гэрээ байгуулж, гэрээний нэг хувьтай танилцдаг гэхдээ олгогддоггүй тухай тэмдэглэжээ. Хөдөлмөрийн гэрээтэй холбоотой санал гомдлоос харахад санал асуулгад оролцогсдын дийлэнх нь гэрээнд заасан хугацаанаас илүү цагаар, тушаалын дагуу, ажлын ачаалал их болохоор илүү цагаар ажиллуулдаг, ажлын цагаар нэгдэлт болж байна гээд удаан зогсоодог, мөн офицер ахлагч нар цолны нэмэгдэл авдаг бол бид шөнийн цагаар ажилласны нэмэгдэл, илүү цагаар ажилласны нэмэгдэл, нийтээр амрах баярын өдөр ажилласны нэмэгдэл, долоо хоногийн амралтын өдөр ажилласны нэмэгдэл, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс авдаггүй, мөн мэргэжлийн зэргийн нэмэгдэл, хөдөлмөрийн нөхцлийн нэмэгдэл олгогддоггүй, томилолтоор хөдөө хээрийн нөхцөлд ажилласан үед томилолтын мөнгө өгдөггүй байна.

Санал асуулгад оролцсон ажилчдын дийлэнх нь ажлын байрны хэвийн бус нөхцөлд ажилладаг тухайгаа илэрхийлсэн байна.

Хөдөлмөрийн нөхцөл, ажил үүрэгт тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах, хөдөлмөрийн хэвийн бус орчинд ажилладаг ажилтанд хор саармагжуулах бодис, хүнсний бүтээгдэхүүн олгох ажил хангалтгүй байна. Харин эрүүл мэндийн үзлэгт жилд 2 удаа оруулдаг, хөдөлмөр хамгааллын зааварчилгаа, ажлын байран дээрх сургалтыг заримдаа зохион байгуулдаг гэжээ.

Жирэмсэн эмэгтэй, 8 хүртэлх насны хүүхэдтэй ганц бие эх, ганц бие эцгийг өөрөө зөвшөөрөөгүй тохиолдолд шөнийн буюу илүү цагаар, түүнчлэн албан томилолтоор ажиллуулдаг, жирийн ажлын өдөр нялх хүүхэдтэй эх, ганц бие эцэгт хүүхэд асрах нэмэлт чөлөө олгодоггүй гэж санал асуулгад оролцогсод хариулсан байна.

Тус ангид хөдөлмөрийн маргаан таслах комисс байдаггүй, танай байгууллагад хөдөлмөрийн хамтын маргаан гарч байсан уу? гэсэн асуултад бүгд үгүй гэж хариулсан ба гарч байсан хөдөлмөрийн маргааныг хэрхэн шийдвэрлэдэг вэ? гэсэн асуултад хөдөлмөрийн маргаан гаргах боломжгүй, цэргийн байгууллагад ажиллаж байгаа энгийн ажилчид цэргийн хүний адил хэдэн цаг ч хамаагүй гадаа зогсоон,

үүрэгдэж энэ тухай эсэргүүцэл илэрхийлбэл хавчиж дарамталдаг, нэгдэлтэнд ороогүй тохиолдолд ажил тасалснаар тооцож цалингаас хасдаг, өвдөж эрхгүй, өвчтэй хүнд чөлөө олгодоггүй, ямар нэгэн асуудал гарч чөлөө авах гэхээр хүндэтгэн үзэхгүйгээр шууд цалинтай тооцдог тухай тэмдэглэжээ.

Санал асуулгад оролцогсдын дийлэнх нь сануулах, цалин хасах, ажлаас халах хэлбэрийн сахилгын шийтгэлийг оногдуулдаг гэсэн байна. Сахилгын шийтгэлийг оногдуулахдаа дарга нараас өгсөн үүрэг даалгаварынг тодорхой шалтгаанаар биелүүлээгүй, ажлаас хоцорсон тохиолдолд цалингийн хувиар шийтгэл оногдуулдаг гэсэн байна.

032 дугаар ангийн санал асуулгад оролцсон 23 ажилчдын 6 эрэгтэй, 18 эмэгтэй үүнээс насны хувьд дийлэнх нь 30-45, 45-60 настай тус ангид 1-16 жил ажилласан байна.

Санал асуулгын хуудаснаас харахад тус ангид ажилчдын эрх ашгийг төлөөлсөн үйлдвэрчний байгууллага байдаггүй, хамтын гэрээ хэлэлцээр, хамтын гэрээний талаар ойлголт байхгүй байна.

Харин санал асуулгад оролцогсод бүгд хөдөлмөрийн гэрээ байгуулж, гэрээний нэг хувьтай танилцдаг, нэг хувийг нь олгодоггүй гэж тэмдэглэжээ. Хөдөлмөрийн гэрээтэй холбоотой санал гомдлоос харахад санал асуулгад оролцогсдын дийлэнх нь гэрээнд заасан хугацаанаас илүү цагаар, тушаалын дагуу, ажлын ачаалал их болохоор илүү цагаар ажиллуулдаг тухайгаа илэрхийлжээ.

Санал асуулгад оролцсон ажилчид ажлын байрны хэвийн нөхцөлд ажилладаг тухайгаа илэрхийлсэн байна.

Тус ангид шөнийн цагаар ажилласны нэмэгдэл, илүү цагаар ажилласны нэмэгдэл, нийтээр амрах баярын өдөр ажилласны нэмэгдэл, долоо хоногийн амралтын өдөр ажилласны нэмэгдэл, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс янз бүр олгогддог, үзэмжээрээ байдаг, мөн мэргэжлийн зэргийн нэмэгдэл, хөдөлмөрийн нөхцлийн нэмэгдэл олгогддоггүй гэсэн байна.

Хөдөлмөрийн нөхцөл, ажил үүрэгт тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах, хөдөлмөрийн хэвийн бус орчинд ажилладаг ажилтанд хор саармагжуулах бодис, хүнсний бүтээгдэхүүн олгох ажил хангалтгүй байна. Харин эрүүл мэндийн үзлэгт жилд 2 удаа оруулдаг, хөдөлмөр хамгааллын зааварчилгаа, ажлын байран дээрх сургалтыг заримдаа зохион байгуулдаг гэжээ.

Жирэмсэн эмэгтэй, 8 хүртэлх насны хүүхэдтэй ганц бие эх, ганц бие эцгийг өөрөө зөвшөөрөөгүй тохиолдолд шөнийн буюу илүү цагаар, түүнчлэн албан томилолтоор ажиллуулдаг, жирийн ажлын өдөр нялх хүүхэдтэй эх, ганц бие эцэгт

хүүхэд асрах нэмэлт чөлөө олгодоггүй гэж санал асуулгад оролцогсод хариулсан байна.

Тус ангид хөдөлмөрийн маргаан таслах комисс байгаа эсэх талаар ажилчид нэг мөр ойлголтгүй, зарим нь байдаг, зарим нь байдаггүй гэж хариулсан бөгөөд танай байгууллагад хөдөлмөрийн хамтын маргаан гарч байсан уу? гэсэн асуултад бүгд үгүй тэмдэглэжээ.

Санал асуулгад оролцогсдын дийлэнх нь сануулах, цалин хасах, ажлаас халах хэлбэрийн сахилгын шийтгэлийг оногдуулдаг гэсэн байна.

Цэргийн газар ажиллаж байгаа энгийн ажилчид бүгд тушаалаар өдөр шөнөгүй илүү цагаар ажиллаж байгаад тэтгэвэрт гадаг. Гэтэл цэргийн албан хаагчид болохоор тэтгэвэрт гарахдаа тэтгэмжийн мөнгө авдаг. Харин бид тэтгэвэрт гарахад улсаас тэтгэмж олгодоггүй талаар анхаарч үзнэ үү гэсэн хүсэлтийг гаргасан байна.

**ХИЛИЙН ЦЭРГИЙН АНГИУДЫН ЦЭРГИЙН  
АЛБАН ХААГЧДААС АВСАН САНАЛ АСУУЛГЫН  
НЭГДСЭН ДҮН**

Хилийн цэргийн 0245, 0311, 0168, 0108, 0129 дүгээр ангиуд								
	Асуулт		0168-р анги	0108-р анги	0129-р анги	0245-р анги	0311-р анги	Нийт дүн
			105 цэргийн албан хаагч	96 цэргийн албан хаагч	124 цэргийн албан хаагч	113 цэргийн албан хаагч	84 цэргийн албан хаагч	522 цэрэг
1.	Боловсрол	Дээд	-	2	-	2	-	4
		Бүрэн дунд	43	26	40	43	22	174
		Бүрэн бус дунд	17	12	25	-	-	54
		Бага	28	7	2	67	50	154
		Боловсролгүй	10	-	11	17	12	50
2.	Хоол, хүнсний тэжээлийн хангамж, хүрэлцээний байдал	өлсдөг	3	1	3	5	1	13
		заримдаа	4	1	6	7	9	27
		өлсдөггүй	105	35	80	101	74	395
3.	Хоол хүнсний чанарын байдал	Сайн	91	45	75	100	72	383
		Дунд	22	2	11	13	12	60
		Муу	3	-	-	-	-	3
4.	Иддэг хоолныхоо чанарын талаар дутагдал байвал бичнэ үү?							
5.	Сард хэдэн удаа усанд ордог вэ?		Мэдэхгүй	3	3	4	4	14
6.	Ариун цэврийн хэрэгсэл хангалттай эсэх	Хангалттай	98	47	-	111	83	339
		Хангалтгүй	9	-	-	2	1	12
7.	Гутал хувцасны хангалтын байдал	Сайн	88	46	85	111	79	409
		Дунд	10	1	2	2	5	20
		Муу	2	-	1	-	-	3
8.	Хувцасны хангалтын талаар дутагдалтай зүйлээ бичнэ үү?							

9.	<b>Чөлөөт цагаа хэрхэн өнгөрүүлдэг вэ?</b>							
10.	<b>Тогтмол сонин, хэвлэл уншдаг эсэх</b>	Уншдаг	15	35	14	31	28	123
		Хааяа	22	10	38	36	26	132
		Уншдаггүй	60	2	35	36	30	163
11.	<b>Радио сонсох боломжтой эсэх</b>	Боломжтой	40	38	29	48	69	224
		Боломжгүй	37	1	41	43	10	132
		Заримдаа	27	8	19	22	5	81
12.	<b>Сургалт, хүмүүжлийн ажил зохион байгуулагддаг эсэх</b>	Зохиогддог	66	44	51	77	79	317
		Зохиогддоггүй	11	-	3	22	4	40
		Заримдаа	22	3	9	14	1	49
13.	<b>Таны хүсэн хүлээдэг ямар ажил зохиох хэрэгтэй байна вэ?</b>							
14.	<b>Чөлөөт цагаа хэрхэн өнгөрүүлдэг вэ?</b>							
15.	<b>Эмнэлгийн үзлэгт ордог эсэх</b>	Ордог	91	47	79	100	80	397
		Ордоггүй	9	-	1	7	-	17
		Заримдаа	11	-	3	6	4	24
16.	<b>Эм тарианы хангалт хэр зэрэг вэ?</b>	Хангалттай	78	45	79	77	70	349
		Хангалтгүй	32	2	7	36	14	91
17.	<b>Бие бялдраа хөгжүүлэх, спортоор хичээллэх боломжтой эсэх.</b>	Боломжтой	85	47	78	104	75	389
		Боломжгүй	20	-	10	9	9	48
18.	<b>Боломж муутай бол дутагдлын талаар бичнэ үү?</b>							
19.	<b>Өргөдөл гомдол гаргах боломжтой эсэх</b>	Боломжтой	67	41	76	104	78	366
		Боломжгүй	27	6	6	9	6	54
20.	<b>Эргэлт уулзалт авдаг эсэх</b>	Авдаг	62	46	75	66	71	320
		Авдаггүй	28	1	8	47	13	97
21.	<b>Захидлаар харилцах боломжтой эсэх</b>	Боломжтой	102	47	79	44	81	353
		Боломжгүй	8	-	5	69	3	85
22.	<b>Хөдөлмөр эрхлэхдээ хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэдэг эсэх</b>	Хэрэглэдэг	59	43	65	23	69	259
		Хэрэглэгдэггүй	24	1	11	81	7	124
		Заримдаа	19	3	14	9	8	53

23.	Ажил хөдөлмөр эрхлэж байхдаа гэмтэл авч байсан бол тэр талаар дэлгэрэнгүй бичнэ үү?							
24.	Цэргийн албан хаагчдаас ар гэртээ болон танил талынхаа ажлыг хийлгэдэг эсэх	Байнга	3	3	4	2	1	13
		Хааяа	49	-	11	5	4	69
		Огт үгүй	51	44	71	106	79	351
25.	Хэрэв хийлгэдэг бол ямар төрлийн ажил хийлгэдэг талаар дэлгэрэнгүй бичнэ үү?		Мод хагалах, хашаа янзлах, гэр барих, байр дээвэрлэх					
26.	Танд тус Комисст хандаж хэлэх зүйл байвал бичнэ үү?		Гадаад хэл ,компьютерийн сургалтанд хамрагдах хүсэлтэй, Шээх боломж муутайгаа өмд гутландаа шээсэн. Хуучин цэрэг хувцастайгаа халагдах хүсэлтэй байдаг.					

### ДҮРМИЙН БУС ХАРЬЦАА

Зөрчил	0168				0129				0108				0245				0311				Нийт			
	Офицер	Ахлагч	Түрүүч	Байлдагч	Офицер	Ахлагч	Түрүүч	Байлдагч	Офицер	Ахлагч	Түрүүч	Байлдагч	Офицер	Ахлагч	Түрүүч	Байлдагч	Офицер	Ахлагч	Түрүүч	Байлдагч	Офицер	Ахлагч	Түрүүч	Байлдагч
Ялгавартай хандах	7	4	1	5	1	4	-	-	-	-	-	-	-	1	2	3	-	-	1	2	8	9	4	10
Айлган сүрдүүлэх, дарамтлах	8	8	1	-	2	10	-	-	-	-	-	-	-	-	-	5	-	-	1	1	10	18	2	6
Мөнгө эд зүйл шаардах	1	1	1	1	-	2	-	-	-	-	-	-	-	-	-	1	1	2	1	2	2	5	2	4
Зодох, хүч хэрэглэх	5	8	1	1	-	7	-	1	-	-	-	-	-	-	1	6	1	-	1	4	6	15	3	12
Үг хэлээр доромжлох/нэр хоч өгөх гм/	13	14	1	4	4	12	1	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	3	3	17	26	5	8
Дүрмийн бус шийтгэл хүлээлгэх	4	5	1	1	-	7	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	4	3	4	12	5	4
Өөр бусдаар зодуулах шийтгэх	-	-	-	-	-	6	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	1	-	6	-	1
Бүгд	38	40	6	12	7	48	1	2	-	-	-	-	-	1	3	15	2	2	11	16	47	91	21	45

**УБ ХОТ ДАХЬ ЗАРИМ ЦЭРГИЙН АНГИУДЫН ЦЭРГИЙН  
АЛБАН ХААГЧДААС АВСАН САНАЛ АСУУЛГЫН  
НЭГДСЭН ДҮН**

ЗХЖШ-ЫН 013, 015, 326, 120, 032, 029 дүгээр ангиуд									
	Асуулт	013-р анги	015-р анги	0326-р анги	0120-р анги	032-р анги	029-р анги	Нийт дүн	
		172 цэргийн албан хаагч	36 цэргийн албан хаагч	206 цэргийн албан хаагч	246 цэргийн албан хаагч	141 цэргийн албан хаагч	28 цэргийн албан хаагч	829 цэрэг	
27.	Боловсрол	Дээд	7	2	4	8	2	3	26
		Бүрэн дунд	103	13	137	113	124	24	514
		Бүрэн бус дунд	39	6	61	-	-	-	106
		Бага	39	3	-	108	2	1	153
		Боловсролгүй	23	-	4	17	13	-	57
28.	Хоол, хүнсний тэжээлийн хангамж, хүрэлцээний байдал	өлсдөг	2	-	10	6	1	-	19
		заримдаа	32	2	46	72	13	16	181
		өлсдөггүй	128	33	150	168	127	12	618
29.	Хоол хүнсний чанарын байдал	Сайн	108	31	135	114	129	9	526
		Дунд	45	2	59	111	9	18	244
		Муу	2	1	12	21	3	1	40
30.	Иддэг хоолныхоо чанарын талаар дутагдал байвал бичнэ үү?								
31.	Сард хэдэн удаа усанд ордог вэ?								
32.	Ариун цэврийн хэрэгсэл хангалттай эсэх	Хангалттай	133	34	168	229	140	22	726
		Хангалтгүй	20	-	38	17	1	6	82
33.	Гутал хувцасны хангалтын байдал	Сайн	145	32	176	202	136	18	709
		Дунд	21	1	27	39	5	9	102
		Муу	4	-	3	5	-	1	13
34.	Хувцасны хангалтын талаар дутагдалтай зүйлээ								

107



	бичнэ үү?								
35.	Чөлөөт цагаа хэрхэн өнгөрүүлдэг вэ?								
36.	Тогтмол сонин, хэвлэл уншдаг эсэх	Уншдаг	81	23	93	120	112	15	444
		Хааяа	66	8	76	86	22	9	267
		Уншдаггүй	22	1	37	40	7	2	109
37.	Радио сонсох боломжтой эсэх	Боломжтой	100	21	80	164	129	23	517
		Боломжгүй	30	4	85	56	5	1	181
		Заримдаа	36	4	41	26	7	4	118
38.	Сургалт, хүмүүжлийн ажил зохион байгуулагддаг эсэх	Зохиогддог	124	29	163	211	138	14	679
		Зохиогддоггүй	3	-	12	2	2	-	19
		Заримдаа	45	4	31	33	1	14	128
39.	Таны хүсэн хүлээдэг ямар ажил зохиох хэрэгтэй байна вэ?								
40.	Чөлөөт цагаа хэрхэн өнгөрүүлдэг вэ?								
41.	Эмнэлгийн үзлэгт ордог эсэх	Ордог	146	30	163	199	135	20	693
		Ордоггүй	3	-	2	40	1	1	47
		Заримдаа	22	4	41	7	5	7	86
42.	Эм тарианы хангалт хэр зэрэг вэ?	Хангалттай	135	32	102	147	126	23	565
		Хангалтгүй	30	1	104	99	15	5	254
43.	Бие бялдраа хөгжүүлэх, спортоор хичээллэх боломжтой эсэх.	Боломжтой	136	24	147	189	141	5	642
		Боломжгүй	34	8	59	57	-	23	181
44.	Боломж муутай бол дутагдлын талаар бичнэ үү?								
45.	Өргөдөл гомдол гаргах боломжтой эсэх	Боломжтой	125	29	147	224	138	22	685
		Боломжгүй	34	3	59	22	3	6	127
46.	Эргэлт уулзалт авдаг эсэх	Авдаг	157	34	184	244	139	27	785
		Авдаггүй	11	-	22	2	2	1	38
47.	Захидлаар харилцах боломжтой эсэх	Боломжтой	147	34	141	206	139	24	691
		Боломжгүй	19	2	65	40	2	6	134
48.	Хөдөлмөр эрхлэхдээ хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэдэг эсэх	Хэрэглэдэг	73	30	78	186	136	3	506
		Хэрэглэгдэггүй	37	2	86	35	1	21	182
		Заримдаа	48	-	42	25	4	4	123

49.	Ажил хөдөлмөр эрхлэж байхдаа гэмтэл авч байсан бол тэр талаар дэлгэрэнгүй бичнэ үү?								
50.	Цэргийн албан хаагчдаас ар гэртээ болон танил талынхаа ажлыг хийлгэдэг эсэх	Байнга	9	-	16	186	95	2	308
		Хааяа	57	22	40	32	1	19	171
		Огт үгүй	99	14	150	28	45	7	343
51.	Хэрэв хийлгэдэг бол ямар төрлийн ажил хийлгэдэг талаар дэлгэрэнгүй бичнэ үү?								
52.	Танд тус Комисст хандаж хэлэх зүйл байвал бичнэ үү?								

### ДҮРМИЙН БУС ХАРЬЦАА

Зөрчил	013				015				0326				0120				032				029				Нийт			
	Офицер	Ахлагч	Түрүүч	Байлдагч	Офицер	Ахлагч	Түрүүч	Байлдагч	Офицер	Ахлагч	Түрүүч	Байлдагч	Офицер	Ахлагч	Түрүүч	Байлдагч	Офицер	Ахлагч	Түрүүч	Байлдагч	Офицер	Ахлагч	Түрүүч	Байлдагч	Офицер	Ахлагч	Түрүүч	Байлдагч
Ялгавартай хандах	26	22	23	16	-	2	2	1	18	17	41	17	10	18	21	13	1	1	5	3	9	1	4	4	64	61	96	54
Айлган сүрдүүлэх, дарамтлах	35	28	26	14	1	-	2	3	18	19	32	7	8	13	26	11	1	1	7	4	9	2	6	5	72	63	99	44
Мөнгө эд зүйл шаардах	38	30	34	20	-	-	-	-	20	26	41	5	10	19	18	7	1	1	8	5	10	2	7	2	79	78	108	39

Зодох, хүч хэрэглэх	31	28	31	18	-	-	-	1	18	18	33	8	9	14	20	9	1	1	7	4	8	2	4	3	67	63	95	43
Үг хэлээр доромжлох/нэр хоч өгөх гм/	29	25	28	17	1	1	2	3	17	18	40	15	19	22	32	22	1	1	7	4	6	2	4	5	73	69	113	66
Дүрмийн бус шийтгэл хүлээлгэх	30	31	30	8	-	-	-	-	14	18	28	13	10	14	12	9	1	1	8	5	8	2	5	2	63	66	83	37
Өөр бусдаар зодуулах шийтгэх	18	15	20	10	-	-	-	-	13	15	24	12	10	11	10	10	1	1	7	4	4	3	4	2	46	45	65	38
Бүгд					2	3	6	8	118	113	239	77	76	111	139	81	7	7	43	29	52	14	34	23	464	445	659	321